| 33   | гучин гурав             | 8888 | найман мянга найман зуун наян найм      |
| 333  | гурван зуун гучин гурав | 9999 | есөн мянга есөн зуун ерэн ес            |

**Note:** If other numbers or nouns are after a number, except for one and two, the first number takes "н." For example: зуун тав, зуун ном, хоёр ном, нэг ном.

The number one alone does not need "н" but when combined with other numbers, it must have "н." For example: арван нэгэн ном, хорин нэгэн ном.

If 1000 is in front of other numbers, it does not take "н," but if it is in front of nouns, it takes "н." For example: 1500 — мянга таван зуу, 1010 — мянга арав, 5200 — таван мянга хоёр зуу, 1000 ном — мянган ном, 5000 хүн — таван мянган хүн.

## Дасгал 4

Унш. (Read.)

12 үзэг<sup>4</sup> — 12 pens

34 багш — 34 teachers

1 дэвтэр — 1 notebook

3 ном — 3 books

2500 төгрөг — 2500 togrogs

2 харандаа — 2 pencils

25 цүнх — 25 purses

100 доллар — 100 dollars

32 оюутан — 32 students

**Note:** When Mongolians say years, we say them as whole numbers.

For example: 1995 он — мянга есөн зуун ерэн таван он (year of 1995).

4 When nouns are with numbers that show plural, they do not use plural suffixes.

|         |         |         |         |
|---------|---------|---------|---------|
| 1996 он | 1970 он | 1966 он | 2001 он |
| 1999 он | 1991 он | 1977 он | 2003 он |
| 1988 он | 1939 он | 2000 он | 2020 он |

**Note:** When we say phone numbers, we say them two by two.

*For example:* 99 20 45 55 — ерэн ес, хорь, дөчин тав, тавин тав.

|             |             |             |             |
|-------------|-------------|-------------|-------------|
| 99 06 31 28 | 95 16 02 10 | 50 35 22 34 | 11 45 40 13 |
| 99 36 43 34 | 96 66 35 44 | 88 37 75 04 | 11 45 00 11 |
| 91 16 35 77 | 50 15 01 11 | 88 55 22 88 | 11 67 30 08 |

## Дасгал 5

A. Доорх кодыг ашиглан үгсийг бич. (Using the code below, write the words.)

**Код:**

|            |                  |                  |                 |
|------------|------------------|------------------|-----------------|
| А = нэг    | И = арав         | Р = арван ес     | Ш = хорин найм  |
| Б = хоёр   | Й = арван нэг    | С = хорь         | Щ = хорин ес    |
| В = гурав  | К = арван хоёр   | Т = хорин нэг    | Ъ = гуч         |
| Г = дөрөв  | Л = арван гурав  | У = хорин хоёр   | Ы = гучин нэг   |
| Д = тав    | М = арван дөрөв  | Ү = хорин гурав  | Ь = гучин хоёр  |
| Е = зургаа | Н = арван тав    | Ф = хорин дөрөв  | Э = гучин гурав |
| Ё = долоо  | О = арван зургаа | Х = хорин тав    | Ю = гучин дөрөв |
| Ж = найм   | Ө = арван долоо  | Ц = хорин зургаа | Я = гучин тав   |
| З = ес     | П = арван найм   | Ч = хорин долоо  |                 |

|                            |                    |                 |
|----------------------------|--------------------|-----------------|
| 14-10-15-10-11             | 26-23-15-25        | 5-16-13-13-1-19 |
| 21-1-15-31                 | 16-34-22-21-1-15   | 2-1-4-28        |
| 22-13-1-1-15-2-1-1-21-1-19 | 25-1-19-1-15-5-1-1 | 5-33-3-21-33-19 |
| 14-16-15-4-16-13           | 21-17-4-19-17-4    | 15-16-14        |

B. Дээрх кодыг ашиглан мэддэг үгсээ бич. (Write words that you know using the code above.)



## Нэр үгийн -тай<sup>3</sup> нөхцөл (Noun suffix -тай<sup>3</sup>)

-тай<sup>3</sup> (have or with) / -гүй (don't have or without)

Би дэвтэртэй. I **have** a notebook.

Би номгүй. I **don't have** a book.

Би дэвтэргүй. I **don't have** a notebook.

Би багштай. I **have** a teacher.

Би номтой. I **have** a book.

Би багшгүй. I **don't have** a teacher.

сүүтэй цай (milk tea), зураг**тай** ном (book **with** pictures), мах**тай** хоол (food **with** meat)

### Spelling rules:

|   |             |                           |             |
|---|-------------|---------------------------|-------------|
| After nouns with <b>a</b> or <b>y</b>       | <b>-тай</b> | After nouns with <b>o</b> | <b>-той</b> |
| After nouns with <b>э, ү, ө</b> or <b>и</b> | <b>-тэй</b> | After all nouns           | <b>-гүй</b> |

## Дасгал 6

Өгүүлбэрийг "-тай<sup>3</sup>", "-гүй" нөхцөлийг ашиглан гүйцээ. (Complete the sentences using the suffixes "-тай<sup>3</sup>" or "-гүй.")

A. For example (Жишээ нь): Би хоёр үзэгтэй. (I have two pens.)

- |                           |                          |
|---------------------------|--------------------------|
| 1. Би таван харандаа..... | 9. Би дөрвөн дүү.....    |
| 2. Би сайн ширээ.....     | 10. Би сайн эмээ.....    |
| 3. Би арван сандал.....   | 11. Би сайн өвөө.....    |
| 4. Би сайн цүнх.....      | 12. Би сайн найз.....    |
| 5. Би сайн аав.....       | 13. Би хоёр багш.....    |
| 6. Би сайн ээж.....       | 14. Би арван оюутан..... |
| 7. Би гурван ах.....      | 15. Би есөн хүүхэд.....  |
| 8. Би нэг эгч.....        | 16. Би таван охин.....   |

Шинэ үгс: ширээ — table, сандал — chair, аав — father, ээж — mother, ах — brother, эгч — sister, дүү — younger sibling, эмээ — grandmother, өвөө — grandfather, найз — friend, хүүхэд — child, охин — daughter

B. For example (Жишээ нь): Би үзэггүй. (I don't have a pen.)

- |                         |                    |
|-------------------------|--------------------|
| 1. Би харандаа.....     | 7. Би жолооч.....  |
| 2. Би сандал.....       | 8. Би охин.....    |
| 3. Би ах.....           | 9. Би хүү.....     |
| 4. Би дүү.....          | 10. Би оюутан..... |
| 5. Би эрэгтэй дүү.....  | 11. Би хүүхэд..... |
| 6. Би эмэгтэй найз..... | 12. Би багш.....   |

Шинэ үгс: жолооч — driver, манай — our, танай — your, эрэгтэй — male, эмэгтэй — female, хүү — son

## Дасгал 7

Эмнөх дасгалын шинэ үгс болон "-май<sup>3</sup>" нөхцөлийг ашиглан өөрийнхөө (найзынхаа, ахынхаа, багшийнхаа г.м.) тухай ярь. (Tell about yourself (your friends, your brother, your teacher, etc.) using the new words from the previous exercise and using the suffix "-май<sup>3</sup>.")

For example (Жишээ нь): Миний эгч нэг хүүхэдтэй. Манай эгч сайн найзтай.

1. Би .....
2. Манай монгол<sup>5</sup> найз .....
3. Манай багш .....
4. Манай ах .....

## Дасгал 8

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан холбож зур. (Match the Mongolian and English words by connecting them with lines.)

|        |                 |         |          |
|--------|-----------------|---------|----------|
| ширээ  | father          | жолооч  | your     |
| аав    | sister          | манай   | chair    |
| ээж    | younger sibling | танай   | son      |
| ах     | grandmother     | сандал  | driver   |
| эгч    | table           | эрэгтэй | our      |
| дүү    | child           | эмэгтэй | pen      |
| эмээ   | friend          | хүү     | male     |
| өвөө   | daughter        | дэвтэр  | year     |
| найз   | brother         | цүнх    | purse    |
| хүүхэд | mother          | үзэг    | female   |
| охин   | grandfather     | он      | notebook |

<sup>5</sup> Mongolia (the country) is spelled with capital letter "M" like "Монгол (улс)." Mongolian (as an adjective) is spelled with a small "m," like "монгол багш." This is also true for other country names.

# Тавдугаар хичээл



## Асуух сул үг (Question particles)

### Spelling rules:

|                                       |   | If the last word of a sentence ends with a short vowel or consonant | If the last word of a sentence ends with a long vowel or diphthong |
|---------------------------------------|---|---|--|
| If a sentence has no question pronoun | If the last word of a sentence has <b>а, о</b> or <b>у</b>    | уу  | юу   |
|                                       | If the last word of a sentence has <b>э, ө, ү</b> or <b>и</b> | үү  | юү   |

|                                      | If the last word of a sentence ends with any vowel or consonant <b>besides H, M or B</b> | If the last word of a sentence ends with <b>н, м</b> or <b>в</b> |
|--------------------------------------|--|--|
| If a sentence has a question pronoun | вэ   | бэ   |

For example (Жишээ нь):

- |                                |                            |
|--------------------------------|----------------------------|
| 1. Сайн байна уу?              | How are you?               |
| 2. Та багш уу?                 | Are you a teacher?         |
| 3. Энэ таны үзэг үү?           | Is this your pen?          |
| 4. Энэ таны харандаа юу?       | Is this your pencil?       |
| 5. Энэ таны ширээ юү?          | Is this your table?        |
| 6. Та үзэгтэй юү?              | Do you have a pen?         |
| 7. Энэ юу вэ?                  | What is this?              |
| 8. Энэ хэд вэ?                 | How much is this?          |
| 9. Чингис хаан хаана байна вэ? | Where is King Chinggis?    |
| 10. Таны нэр хэн бэ?           | What is your name?         |
| 11. Энэ ямар ном бэ?           | What kind of book is this? |
| 12. Энэ хэний сав бэ?          | Whose container is this?   |

### Асуух төлөөний үгс (Question pronouns):

|        |       |         |                       |
|--------|-------|---------|-----------------------|
| хэн    | who   | хэд(эн) | how many              |
| юу     | what  | ямар    | what (what kind)      |
| хэзээ  | when  | аль     | which                 |
| хаана  | where | яаж     | how (with verbs)      |
| яагаад | why   | хир     | how (with adjectives) |

## Дасгал 1

Хамтрахын тийн ялгал болон асуух сул үгсийг ашиглан асуултыг гүйцээж, хариул. (Complete the questions using the comitative case and question particles and answer them.)

Жишээ нь: Та ах...? Та хэдэн ах...?

— Та ахтай юу? (Do you have a brother?) — Та хэдэн ахтай вэ? (How many brothers do you have?)  
 — Тийм, би ахтай. (Yes, I have a brother.) — Би хоёр ахтай. (I have two brothers.)

1. Та харандаа *тай юу?*

Та хэдэн харандаа *тай вэ?*

2. Та сандал *тай юу?*

Та хэдэн сандал *тай вэ?*

3. Чи цүнх *тай юу?*

Чи хэдэн цүнх *тай вэ?*

4. Та эгч *тай юу?*

Та хэдэн эгч *тай вэ?*

5. Чи дүү *тай юу?*

Чи хэдэн дүү *тай вэ?*

6. Та эрэгтэй дүү..... ?

Та хэдэн эрэгтэй дүү..... ?

7. Чи эмэгтэй найз..... ?

Чи хэдэн эмэгтэй найз..... ?

8. Та жолооч..... ?

Та хэдэн жолооч..... ?

9. Чи охин..... ?

Чи хэдэн охин..... ?

10. Та хүү..... ?

Та хэдэн хүү..... ?

11. Чи оюутан..... ?

Чи хэдэн оюутан..... ?

12. Та хүүхэд..... ?

Та хэдэн хүүхэд..... ?

13. Чи эрэгтэй багш..... ?

Чи хэдэн эрэгтэй багш..... ?

## Дасгал 2

Цэгийн оронд асуух сул үг бичиж, асуултад хариул. (Write the question particles and answer the questions.)

Жишээ нь:

Таны ах хэдэн настай вэ? (How old is your brother?)

Миний ах 40 настай. (My brother is 40 years old.)

1. Та хэдэн настай .... ?

2. Таны эгч хэдэн настай .... ?

3. Чиний эрэгтэй дүү хэдэн настай .... ?

4. Таны эмэгтэй дүү хэдэн настай .... ?

5. Таны хүү хэдэн настай .... ?

6. Таны охин хэдэн настай .... ?

7. Тэр эмэгтэй хүн хэдэн настай .... ?

8. Таны эхнэр/нөхөр хэдэн настай .... ?

9. Таны багш хэдэн настай .... ?

10. Таны найз хэдэн настай .... ?

Шинэ үгс: эхнэр — wife, нөхөр — husband, хүн — person, нас — age

## Дасгал 3

Нэр үгст хамтрахын тийн ялгалын нөхцөл залгаж бичин, асуулт зохио. (Add the correct comitative suffix to the nouns, then make questions.)

Жишээ нь: Би гурван сайн дэвтэртэй.

Та гурван сайн дэвтэртэй юу? (Do you have three good notebooks?)

Та **хэдэн** сайн дэвтэртэй вэ? (How many good notebooks do you have?)

**Хэн** гурван сайн дэвтэртэй вэ? (Who has three good notebooks?)

- |                          |                       |                          |
|--------------------------|-----------------------|--------------------------|
| 1. Би хоёр үзэг.....     | 4. Тэр сайн багш..... | 7. Би таван дүү.....     |
| 2. Би сайн харандаа..... | 5. Би гурван ах.....  | 8. Тэр, хоёр найз.....   |
| 3. Багш арван ширээ..... | 6. Би нэг эгч.....    | 9. Тэр арван хүүхэд..... |

## Дасгал 4

Доор өгөгдсөн үгс болон "-тай³" нөхцөлийг ашиглан гэрийнхээ талаар бичээд асуулт зохио. (Write about your house using the words given below and the suffix "-тай³", then make questions.)

Жишээ нь: Би байртай.

Та байртай юу?

Манай байр гурван өрөөтэй. Танай байр хэдэн өрөөтэй вэ?

Манай өрөө дөрвөн цонхтой. Танай өрөө хэдэн цонхтой вэ?

Шинэ үгс: байр — apartment, хаалга — door, цонх — window, өрөө — room, аяга — cup, халбага — spoon, сэрээ — fork, хутга — knife, тавар — plate

## Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

- |   |                                     |
|---|-------------------------------------|
| 1. I have one sister and two brothers.  | 12. How many brothers do you have?  |
| 2. My teacher has 125 books.            | 13. Do you have a younger sibling?  |
| 3. That ger has a good door.            | 14. How many siblings do you have?  |
| 4. Your brother has a bag.              | 15. Does your brother have a wife?  |
| 5. That man has an apartment.           | 16. Do you have a book?             |
| 6. He doesn't have an apartment.        | 17. Do you have a notebook?         |
| 7. I have a good friend.                | 18. Do you have a Mongolian friend? |
| 8. I don't have a bad friend.           | 19. How old are you?                |
| 9. That teacher has 20 students.        | 20. How old is your wife/husband?   |
| 10. This restaurant has 50 good plates. | 21. Do you have a cup?              |
| 11. Do you have a brother?              | 22. Do you have a spoon?            |

## Дасгал 6

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Монгол хэл/англи хэл хэдэн үсэгтэй вэ? (35/26)
2. Таны нэр хэдэн үсэгтэй вэ?

3. Монгол хэдэн аймагтай вэ? (21)
4. "Манай өрөө дөрвөн цонхтой." Энэ өгүүлбэр хэдэн үгтэй байна вэ?

Шинэ үгс: хэл — language, үсэг — letter, англи — English, өгүүлбэр — sentence, аймаг — province, үг — word

## Дасгал 7

Асуултыг уншаад хариулж бич. (Read the questions and answer them.)

Жишээ нь:

- Энэ таны ном уу? (Is this your book?) → — Тийм, энэ миний ном. (Yes, this is my book.)  
 — Үгүй, энэ миний ном биш. (No, this is not my book.)

- |                          |                             |
|--------------------------|-----------------------------|
| 1. Энэ таны дэвтэр үү?   | Is this your notebook?      |
| 2. Энэ таны харандаа юу? | Is this your pencil?        |
| 3. Энэ таны ширээ юү?    | Is this your table?         |
| 4. Энэ таны цүнх үү?     | Is this your bag?           |
| 5. Тэр таны ах уу?       | Is he your brother?         |
| 6. Тэр таны эгч үү?      | Is she your sister?         |
| 7. Тэр таны дүү юү?      | Is he your younger sibling? |
| 8. Тэр таны өвөө юү?     | Is he your grandfather?     |
| 9. Тэр таны найз уу?     | Is she your friend?         |
| 10. Тэр таны багш уу?    | Is he your teacher?         |

## Дасгал 8

Асуух сул үгсийг нөхөж бич. (Add the correct question particle in the spaces.)

- |                               |                               |
|-------------------------------|-------------------------------|
| 1. Энэ таны дэвтэр ..... ?    | 16. Тэр таны эгч ..... ?      |
| 2. Энэ таны үзэг ..... ?      | 17. Тэр таны дүү ..... ?      |
| 3. Энэ таны харандаа ..... ?  | 18. Тэр таны эмээ ..... ?     |
| 4. Энэ таны ширээ ..... ?     | 19. Тэр таны өвөө ..... ?     |
| 5. Энэ таны сандал ..... ?    | 20. Тэр таны найз ..... ?     |
| 6. Энэ таны цүнх ..... ?      | 21. Тэр таны багш ..... ?     |
| 7. Тэр чиний дэвтэр ..... ?   | 22. Тэр таны хүүхэд ..... ?   |
| 8. Тэр чиний үзэг ..... ?     | 23. Тэр таны хүү ..... ?      |
| 9. Тэр чиний харандаа ..... ? | 24. Тэр таны охин ..... ?     |
| 10. Тэр чиний ширээ ..... ?   | 25. Энэ хэн ..... ?           |
| 11. Тэр чиний сандал ..... ?  | 26. Тэр юу ..... ?            |
| 12. Тэр чиний цүнх ..... ?    | 27. Тэр ямар хүн ..... ?      |
| 13. Тэр таны аав ..... ?      | 28. Энэ ямар ном ..... ?      |
| 14. Тэр таны ээж ..... ?      | 29. Энэ хэд ..... ?           |
| 15. Тэр таны ах ..... ?       | 30. Тэр ямар харандаа ..... ? |

## Дасгал 9

Асуух сул үгсийг нөхөж бич. (Add the correct question particle in the spaces.)

Жишээ нь: Энэ таны ном уу, миний ном уу?<sup>6</sup> (Is this your book or my book?)

1. Тэр таны дэвтэр ....., миний дэвтэр ..... ?
2. Тэр таны үзэг ....., миний үзэг ..... ?
3. Тэр таны харандаа ....., миний харандаа ..... ?
4. Тэр таны ширээ ....., миний ширээ ..... ?
5. Тэр таны сандал ....., миний сандал ..... ?
6. Тэр таны хаалга ....., миний хаалга ..... ?
7. Тэр таны цүнх ....., миний цүнх ..... ?
8. Тэр Наранхүү ....., Дашхүү ..... ?
9. Тэр эмэгтэй Мөнхмаа ....., Болормаа ..... ?
10. Энэ эрэгтэй Батхүү ....., Сүххүү ..... ?

## Дасгал 10

Асуултыг гүйцээж, хариул. (Complete the questions and answer them.)

Жишээ нь:

Энэ таны ном мөн<sup>7</sup> үү? IS this your book?  
— Тийм, энэ миний ном мөн. — Yes, this IS my book.  
— Үгүй, энэ миний ном биш. — No, this is not my book.

- |                              |                           |
|------------------------------|---------------------------|
| 1. Энэ таны дэвтэр ..... ?   | 7. Тэр таны эгч ..... ?   |
| 2. Энэ таны үзэг ..... ?     | 8. Тэр таны дүү ..... ?   |
| 3. Энэ таны харандаа ..... ? | 9. Тэр таны эмээ ..... ?  |
| 4. Энэ таны ширээ ..... ?    | 10. Тэр таны өвөө ..... ? |
| 5. Энэ таны цүнх ..... ?     | 11. Тэр таны найз ..... ? |
| 6. Тэр таны ах ..... ?       | 12. Тэр таны багш ..... ? |

## Дасгал 11

А. Багш ширээн дээр бичгийн хэрэгслүүд тавьж, загварын дагуу асуулт асууж, ярилцана. (Your teacher will put stationery things on the table and ask questions as in examples below.)


- |   |   |
|---|---|
| 1. Оюутан: — Энэ юу вэ?<br>Багш: — Энэ үзэг.  | 2. Багш: — Тэр юу вэ?<br>Оюутан: — Тэр ном. |
| 3. Оюутан: — Энэ таны ном уу?<br>Багш: — Тийм, миний ном. ( — Үгүй, миний ном биш. Таны ном.) |   |

<sup>6</sup> When we say these sentences, the question particle of the first sentence is said with a higher tone and the question particle of the second sentence is said with a slightly lower tone.

<sup>7</sup> "Мөн" is used after nouns to give emphasis.

Б. Зургийг хараад багш оюутан хоёр бие биенээсээ доорх асуултуудыг асууж, ярилц. (Look at the picture. The teacher and student should ask each other the questions written below, then talk about the picture.)

1. Тэр хэн бэ?
2. Тэр хэдэн настай вэ?



## Мэндчилгээ (Greetings)

### Харилцаа яриа 1 (Conversation 1)

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| A: — Сайн уу?                       | A: — Hi.                                    |
| Б: — Сайн, сайн уу?                 | B: — Hi.                                    |
| A: — Юу байна?                      | A: — What's up?                             |
| Б: — Юмгүй дээ.                     | B: — Nothing.                               |
| A: — Ажил төрөл сайн уу?            | A: — How is your work? (Is your work good?) |
| Б: — Сайн. Таны ажил төрөл сайн уу? | B: — Good. How is your work?                |
| A: — Сайн.                          | A: — Good.                                  |

### Харилцаа яриа 2 (Conversation 2)

- |                                      |  |
|--------------------------------------|--|
| A: — Амар байна уу?                  | A: — How are you? (During Tsagaan Sar)       |
| Б: — Мэнд ээ, амар байна уу?         | B: — I'm fine. How are you?                  |
| A: — Сайхан шинэлж байна уу?         | A: — Are you having a good New Year holiday? |
| Б: — Сайхан, сайхан шинэлж байна уу? | B: — Yes, are you having a good holiday?     |
| A: — Сайхан.                         | A: — Yes.                                    |
| A: — Өглөөний мэнд.                  | A: — Good morning.                           |
| Б: — Өглөөний мэнд.                  | B: — Good morning.                           |
| A: — Өдрийн мэнд.                    | A: — Good afternoon.                         |
| Б: — Өдрийн мэнд.                    | B: — Good afternoon.                         |
| A: — Оройн мэнд.                     | A: — Good evening.                           |
| A: — Оройн мэнд.                     | B: — Good evening.                           |
| A: — Гэрэлмаад мэнд хүргээрэй.       | A: — Please say "Hi!" to Gerelmaa.           |
| Б: — Тэгнэ ээ.                       | B: — I will.                                 |



# Давтлага хичээл (Review Lesson)

## Дасгал 1

Үгсийг унш. (Read the words.)

|           |             |         |             |
|-----------|-------------|---------|-------------|
| сайн      | хан         | байгаа  | хуруугаараа |
| хаана     | хана        | маргааш | зургаа      |
| Хэн бэ?   | сайн малгай | гэр     | гүүр        |
| сайн байр | улаан перц  | баг     | бага        |
| он        | олон        | нэг     | хог         |

## Дасгал 2

Доорх сэдвийн үгсийг үеэр тасалж унш. (Divide the words of the text below into syllables and read.)

### Инээмсэглэл<sup>8</sup>

Инээмсэглэл нь үнэ төлбөргүй атлаа ихийг бүтээдэг. Тэрээр авч байгаа хүнийг баяжуулдаг боловч өгч байгаа хүнийг ер үгүйрүүлж хоосруулдаггүй. Инээмсэглэл нь хоромхон зуур болж өнгөрөх авч заримдаа насан туршид мартагдахгүй. Инээмсэглэл нь орон гэрт аз жаргал авчирч, ажил хэрэгт тус дөхөм болдог ба ядрахад амралт, гуниглахад гэрэл гэгээ, өвдөж зовоход эм тан болдог. Инээмсэглэл нь өгөөмөр сэтгэлийн дотор байдаг зүйл бөгөөд хэн ч худалдан авч, эсвэл хулгайлж чадахгүй. Та хүмүүсийг баярлуулахыг хүсвэл инээмсэглэж бай.

## Дасгал 3

Тоонуудыг чанга хэл. (Say the numbers out loud.)

- A. 5, 10, 15, 20, 25, 30, 35, 40, 45, 50, 55, 60, 65, 70, 75, 80, 85, 90, 95, 100  
 Б. 1, 3, 5, 7, 9, 11, 13, 15, 17, 19, 21, 33, 55, 77, 99  
 В. 2, 4, 6, 8, 10, 12, 14, 16, 18, 20, 44, 66, 88

## Дасгал 4

Гэр бүлийнхээ талаар "-тай", "-гүй" нөхцөлүүдийг ашиглан ярь. (Talk about your family using the suffixes "-тай" and "-гүй.")

Жишээ нь: Би нэг ахтай. Би эгчгүй.

## Дасгал 5

Дараах өгүүлбэрүүдэд асуулт зохиож бич. (Make appropriate questions for the following sentences.)

Жишээ нь: Би дүүгүй. → Чи дүүтэй юү?

<sup>8</sup> The literal translation of this text is in the exercise answers.

- |                           |                          |
|---------------------------|--------------------------|
| 1. Би машингүй.           | 6. Миний дүү 10 настай.  |
| 2. Би нэг багштай.        | 7. Би хүүхэдтэй.         |
| 3. Би хоёр ахтай.         | 8. Би сайн найзтай.      |
| 4. Би монгол номгүй.      | 9. Манай найз 20 настай. |
| 5. Тэр эмэгтэй, нөхөргүй. | 10. Манай ээж эгчгүй.    |

### Дасгал 6

Асуултад хариул. (Answer the questions.)

- |                          |                                      |
|--------------------------|--------------------------------------|
| 1. Энэ чиний ном уу?     | 6. Энэ таны ширээ мөн үү?            |
| 2. Тэр таны харандаа юу? | 7. Энэ миний цүнх үү, чиний цүнх үү? |
| 3. Энэ танай гэр мөн үү? | 8. Тэр таны аяга уу, миний аяга уу?  |
| 4. Тэр танай машин уу?   | 9. Энэ үзэг үү, харандаа юу?         |
| 5. Энэ танай аймаг уу?   | 10. Та ахтай юу, эгчтэй юү?          |

### Дасгал 7

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан холбож зур. (Match the Mongolian and English words by connecting them with lines.)

|          |          |        |           |        |              |
|----------|----------|--------|-----------|--------|--------------|
| өгүүлбэр | English  | үг     | apartment | хаалга | son          |
| үсэг     | wife     | хэл    | person    | цонх   | cup          |
| англи    | plate    | биш    | table     | өрөө   | window       |
| аймаг    | province | байр   | language  | аяга   | door         |
| халбага  | sentence | нөхөр  | child     | хүү    | room         |
| сэрээ    | knife    | хүн    | age       | охин   | chair        |
| хутга    | letter   | нас    | word      | жолооч | driver       |
| таваг    | spoon    | ширээ  | not       | сандал | what kind of |
| эхнэр    | fork     | хүүхэд | husband   | ямар   | daughter     |

# Тест (Test)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.

(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Монгол хэл ... үсэгтэй.  
Mongolian has ... letters.  
A. 34  
B. 33  
C. 35
2. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. сайн [saim]  
B. сайн [saing] —  
C. сайн [sain]
3. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. оно [ong]  
B. оно [om] —  
C. оно [on]
4. Аль нь эр үг вэ?  
Which one is a masculine word?  
A. өгүүлбэр  
B. уугаарай  
C. ирнэ
5. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. уусэн  
B. уусан  
C. уусөн
6. Алийг нь үеэр зөв тасалсан бэ?  
Which one is correctly divided into syllables?  
A. бай/гуул/ла/га  
B. байг/уул/лага  
C. бай/гуул/лаг/а
7. Аль эгшиг балархай дуудагдах вэ?  
Which vowel is unstressed?  
A. х(а)рандаа  
B. хар(а)ндаа  
C. харанд(аа)
8. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Би сайн өвөөтэй.  
B. Би сайн өвөөтэй.  
C. Би сайн өвөөтэй.
9. Аль нь зөв бэ?  
Which one is right?  
A. Энэ таны халбага юу?  
B. Энэ таны халбага вэ?  
C. Энэ таны халбага уу?
10. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Та хэдэн хүүхэдтэй вэ?  
B. Та хэдэн хүүхэдтэй үү?  
C. Та хэдэн хүүхэдтэй юү?
11. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Би арван хоёр дэвтэртэй.  
B. Би арван хоёрон дэвтэртэй.  
C. Би арав хоёрон дэвтэртэй.
12. Асуулт (Question):  
Энэ таны ном уу?  
A. Үгүй, энэ миний ном.  
B. Үгүй, энэ миний номгүй.  
C. Үгүй, энэ миний ном биш.
13. Асуулт (Question): Та хүүтэй юү?  
A. Үгүй, би хүү биш.  
B. Үгүй, би хүү.  
C. Үгүй, би хүүгүй.
14. Асуулт (Question):  
Та хүүхэдгүй юү?  
A. Тийм, би хүүхэдгүй.  
B. Тийм, би хүүхэдтэй.  
C. Үгүй, би хүүхэдгүй.
15. "Өгүүлбэр" гэж ..... гэсэн үг.  
"Өгүүлбэр" means .....  
A. sentence  
B. word  
C. language
16. "Ямар" гэж ..... гэсэн үг. "Ямар" means .....  
A. why  
B. what kind of  
C. where

Оноо (point): 16/.....

# Зургадугаар хичээл



## Тэмдэг нэр (Adjectives)

|                 |                        |                 |               |
|-----------------|------------------------|-----------------|---------------|
| 1. халуун       | hot                    | 16. хүйтэн      | cold          |
| 2. дулаан       | warm                   | 17. сэрүүн      | cool          |
| 3. олон         | many                   | 18. цөөн        | few           |
| 4. сайн         | good                   | 19. муу         | bad           |
| 5. сайхан       | nice                   | 20. муухай      | ugly          |
| 6. том          | big                    | 21. жижиг       | small         |
| 7. хуучин       | old (inanimate things) | 22. шинэ        | new           |
| 8. хэцүү        | difficult              | 23. амар(хан)   | easy          |
| 9. амттай       | tasty                  | 24. амтгүй      | not tasty     |
| 10. хол         | far                    | 25. ойр(хон)    | near          |
| 11. үнэтэй      | expensive              | 26. хямд        | cheap         |
| 12. сонирхолтой | interesting            | 27. сонирхолгүй | uninteresting |
| 13. адил(хан)   | same                   | 28. өөр         | different     |
| 14. зөв         | right                  | 29. буруу       | wrong         |
| 15. хурдан      | fast                   | 30. удаан       | slow          |

### Дасгал 1

Дээрх тэмдэг нэрсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences using the adjectives above.)

Жишээ нь: Манай гэр халуун. (My house is hot. (in general))

Манай гэр халуун биш. (My house is not hot. (in general))

- |                       |                       |
|-----------------------|-----------------------|
| 1. Монгол (улс) ..... | 11. Монгол хэл .....  |
| 2. Америк .....       | 12. Англи хэл .....   |
| 3. Канад (улс) .....  | 13. Гадаа .....       |
| 4. Англи .....        | 14. Танай байр .....  |
| 5. Франц (улс) .....  | 15. Манай машин ..... |
| 6. Африк .....        | 16. Манай гэр .....   |
| 7. Сүүтэй цай .....   | 17. Миний ажил .....  |
| 8. Итали хоол .....   | 18. Таны ажил .....   |
| 9. Монгол хоол .....  | 19. Манай найз .....  |
| 10. Пицца .....       | 20. Миний хоол .....  |

Шинэ үгс: ажил — work, хоол — food, гэр — home/house, машин — car, улс — country, гадаа — outside, сүүтэй цай — milk tea

## Дасгал 2

Тэмдэг нэр ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences using the adjectives.)

Жишээ нь:

Манай гэр халуун байна. (My house is hot. (right now))

- |                     |                      |
|---------------------|----------------------|
| 1. Монгол .....     | 7. Танай байр .....  |
| 2. Энэ хоол .....   | 8. Энэ хүн .....     |
| 3. Энэ өрөө .....   | 9. Манай гэр .....   |
| 4. Тэр пицца .....  | 10. Миний ажил ..... |
| 5. Энэ хичээл ..... | 11. Таны цай .....   |
| 6. Гадаа .....      | 12. Энэ ном .....    |

## Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:

This food is very (much) delicious. → Энэ хоол маш (их) амттай байна.

- |                                 |                                   |
|---------------------------------|-----------------------------------|
| 1. It's very cold outside.      | 6. My school is very good.        |
| 2. My house is very hot.        | 7. This book is very interesting. |
| 3. This work is very difficult. | 8. This car is very expensive.    |
| 4. This lesson is very easy.    | 9. My horse is very fast.         |
| 5. My room is very big.         | 10. This table is very cheap.     |

## Дасгал 4

Цэгийн оронд тэмдэг нэр, өнгө заасан үгсийг нөхөж бич. (Complete the sentences using adjectives and colors.)

Жишээ нь:

Манай найз ..... машинтай. → Манай найз том, хар машинтай.

- |                                |                               |
|--------------------------------|-------------------------------|
| 1. Монгол улс ..... хүнтэй.    | 7. Манай гэр ..... цонхтой.   |
| 2. Америк ..... уултай.        | 8. Солонгос ..... цэцэгтэй.   |
| 3. Манай найз ..... хүүхэдтэй. | 9. Монгол улс ..... модтой.   |
| 4. Манай аав ..... машинтай.   | 10. Монгол ..... хоньтой.     |
| 5. Тэр ресторан ..... хоолтой. | 11. Солонгос ..... үхэртэй.   |
| 6. Би ..... найзтай.           | 12. Монгол улс ..... морьтой. |

Шинэ үгс: цэцэг — flower, мод — tree, уул — mountain, хонь — sheep, үхэр — cow, Солонгос — Korea, морь — horse

## Дасгал 5

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан холбож зур. (Match the Mongolian and English words by connecting them with lines.)

|             |             |             |               |
|-------------|-------------|-------------|---------------|
| халуун      | many        | хүйтэн      | few           |
| дулаан      | big         | сэрүүн      | bad           |
| олон        | hot         | цөөн        | small         |
| сайн        | warm        | муу         | near          |
| сайхан      | difficult   | муухай      | easy          |
| том         | old         | жигжиг      | cold          |
| хуучин      | same        | шинэ        | uninteresting |
| хэцүү       | good        | амар(хан)   | cheap         |
| амттай      | right       | амтгүй      | wrong         |
| хол         | interesting | ойр(хон)    | different     |
| үнэтэй      | nice        | хямд        | not tasty     |
| сонирхолтой | far         | сонирхолгүй | new           |
| адил(хан)   | expensive   | өөр         | cool          |
| зөв         | tasty       | буруу       | ugly          |

## Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:

I don't have a car. → Би машингүй.

That's not my car. → Тэр миний машин биш.

1. I don't have a child. I'm not a child.
2. She doesn't have a teacher. She is not a teacher.
3. You don't have horses. That's not your horse.
4. This is not my flower. I don't have flowers.
5. I don't have interesting books. This is not an interesting book.
6. I don't have a girlfriend. She is not my girlfriend.
7. She is not a student. She doesn't have any students.
8. That mountain has no trees. That's not a tree.
9. This tree doesn't have flowers. This is not a flower.
10. I don't have a car. That's not my car.
11. I don't have a red pen. It's not a red pen.
12. He doesn't have a cow. This is not his cow.

# Долдугаар хичээл.



## Өнгө (Colors)

|        |       |       |          |           |            |
|--------|-------|-------|----------|-----------|------------|
| цагаан | white | улаан | red      | цэнхэр    | light blue |
| хар    | black | хүрэн | dark red | саарал    | gray       |
| ногоон | green | шар   | yellow   | улбар шар | orange     |
| бор    | brown | хөх   | blue     | ягаан     | pink       |


## Хувцас (Clothes)

|                            |         |               |          |
|----------------------------|---------|---------------|----------|
| ороолт                     | scarf   | зангиа        | tie      |
| гутал                      | boots   | даашинз       | dress    |
| малгай                     | cap/hat | бээлий        | glove    |
| цамц                       | shirt   | хүрэм         | jacket   |
| <u>ботинк</u> <sup>9</sup> | shoes   | <u>пальто</u> | coat     |
| шорт                       | shorts  | өмд           | pants    |
| банзал                     | skirt   | борооны цув   | raincoat |
| оймс                       | sock    | <u>сандал</u> | sandal   |

## Дасгал 1

Багш оюутан хоёр зураг бүр дээр доорх асуултуудыг бие биенээсээ харилцан асууж, яриц. (The teacher and student ask each other questions for every picture below, then talk about the pictures.)

1. Энэ юу вэ? — Энэ ороолт.
2. Энэ гутал уу? — Тийм, энэ гутал.  
— Үгүй, энэ гутал биш. Энэ ботинк.



<sup>9</sup> The underlined words are Russian.

## Дасгал 2

Хувцасны нэрсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences using names for clothes.)

Жишээ нь: Би 2 жижиг, хар гуталтай. (I have two small black boots.)

- |                     |                       |
|---------------------|-----------------------|
| 1. Би .....         | 7. Миний эгч .....    |
| 2. Манай найз ..... | 8. Миний ах .....     |
| 3. Манай аав .....  | 9. Тэр хүн .....      |
| 4. Манай багш ..... | 10. Манай нохой ..... |
| 5. Тэр хүүхэд ..... | 11. Манай муур .....  |
| 6. Манай дүү .....  | 12. Тэр эмэгтэй ..... |

Шинэ үгс: нохой — dog, муур — cat

## Дасгал 3

Багш, оюутан хоёр яг одоо ямар хувцастай байгаагаа хэл. (Both teacher and student tell what clothes you have on right now.)

Жишээ нь: Би одоо улаан цамцтай байна. Багш ногоон цамцтай байна.

1. Би одоо ..... байна.
2. Манай багш/оюутан одоо ..... байна

Шинэ үгс: одоо — now

## Дасгал 4

Унш. (Read.)

## Долоо хоног<sup>10</sup> (Week)

### In official speech

(Tibetan names)

Даваа гараг  
Мягмар гараг  
Лхагва гараг  
Пүрэв гараг  
Баасан гараг  
Бямба гараг  
Ням гараг  
Бямба, ням гараг

### In everyday speech

Нэгдэх өдөр<sup>11</sup>  
Хоёрдахь өдөр  
Гуравдахь өдөр  
Дөрөвдэх өдөр  
Тавдахь өдөр  
Хагас сайн өдөр  
Бүтэн сайн өдөр  
Хагас, бүтэн сайн өдөр

### English names

Monday  
Tuesday  
Wednesday  
Thursday  
Friday  
Saturday  
Sunday  
Weekend

<sup>10</sup> Хоног means one whole day (24 hours).

<sup>11</sup> Өдөр means day time.

## Сар (Months)

| Mongolian names      | In colloquial speech  | English names |
|----------------------|-----------------------|---------------|
| Нэгдүгээр сар        | Нэг сар <sup>12</sup> | January       |
| Хоёрдугаар сар       | Хоёр сар              | February      |
| Гуравдугаар сар      | Гурван сар            | March         |
| Дөрөвдүгээр сар      | Дөрвөн сар            | April         |
| Тавдугаар сар        | Таван сар             | May           |
| Зургадугаар сар      | Зургаан сар           | June          |
| Долдугаар сар        | Долоон сар            | July          |
| Наймдугаар сар       | Найман сар            | August        |
| Есдүгээр сар         | Есөн сар              | September     |
| Аравдугаар сар       | Арван сар             | October       |
| Арван нэгдүгээр сар  | Арван нэгэн сар       | November      |
| Арван хоёрдугаар сар | Арван хоёр сар        | December      |

## Дасгал 5

Өгүүлбэрийг уншаад цээжил. (Read the sentences and memorize them.)

|                         |                                |
|-------------------------|--------------------------------|
| Маргааш уулзъя.         | See you tomorrow.              |
| Дараа уулзъя.           | See you later.                 |
| Нэгдэх өдөр уулзъя.     | See you on Monday.             |
| Хагас сайн өдөр уулзъя. | See you on Saturday.           |
| Маргааш 2 цагт уулзъя.  | See you tomorrow at 2 o'clock. |
| Ресторанд уулзъя.       | See you at the restaurant.     |
| Манай гэрт уулзъя.      | See you at my house.           |
| Танай гэрт уулзъя.      | See you at your house.         |
| Маргааш энд уулзъя.     | See you here tomorrow.         |

**Note:** Suffixes **-д** and **-т** mean in, at, to and for. "**-т**" is used after words that end with letters **г, р, с** and some words that end with the letter **в**.

<sup>12</sup> Нэг сар can also mean "for one month."

# Наймдугаар хичээл



## Харьяалахын тийн ялгал (Genitive case)

This suffix connects two nouns and it means **of** and **'s**.

For example:

зав**ын** ном — father's book

ээж**ийн** харандаа — mother's pencil

### Spelling rules:

|   | After words ending with short vowels or consonants | After words ending with diphthongs | After words ending with <b>н</b> | Masculine words ending with <b>ч, ж, ш, ь, и</b> or <b>г</b> | After words ending with long vowels or consonants (related to things) | After words ending with long vowels (related to people) |
|---|--|------------------------------------|----------------------------------|--|---|---|
| Masculine words (with <b>а, о</b> or <b>у</b> )   | -ын  | -н                                 | -ы                               | -ийн   | -(н)ы   | -(г)ийн   |
| Feminine words (with <b>э, ү, и</b> or <b>ө</b> ) | -ийн   | -н                                 | -ий                              | -ийн   | -(н)ий  | -(г)ийн   |

For example:

эгчийн      жолоочийн      сургуулийн      даргын      хүний      модны  
 үхрийн      багшийн      ангийн      өрөөний      оюутны      усны  
 өвөөгийн      багийн      ахын      хашааны      гахайн      нарны

хүүхэд + ийн = хүүхдийн, сургууль + ийн = сургуулийн, дарга + ын = даргын

**Note:** Sometimes -ийн/-ын or -ний/-ны makes a different word. For example: цагийн нөхцөл (suffixes of tense) or цагны үнэ (a price of watch), Сүхийн ах (the brother of Sukh) or сүхний иш (an ax handle)

Few words ending with **н** like сан, байшин, ан and үзэсгэлэн use **г** before genitive case (сангийн, байшингийн, ангийн, үзэсгэлэнгийн).

### Question pronouns and personal pronouns:

юу → юуны (of what)      та → таны (your)      бид → бидний<sup>13</sup> (манай)<sup>14</sup> (our)  
 хэн → хэний (whose)      чи → чиний (your)      та нар → та нарын (танай) (your)  
 би → миний (my)      тэр → түүний (his/her)      тэд → тэдний (their)

<sup>13</sup> Бидний and та нарын are used for things we possess and do not share with anyone. For example, бидний нүд (our eyes), та нарын бодол (your thoughts), бид нарын машин (our cars).

<sup>14</sup> Манай and танай are used for the things people share. For example, манай гэр (our house), манай багш (our teacher), танай сургууль (your school).

## Дасгал 1

А. Харьяалахын тийн ялгалын нөхцөлүүдээс тохирохыг нь бич. (Add proper endings from the genitive case to each word.)

Б. Холбоо үгсийг бич. (Write down pairs of words.)

Жишээ нь: ном..... → А. номын → Б. номын нэр

- |                |                   |                  |
|----------------|-------------------|------------------|
| 1. ном.....    | 11. өрөө.....     | 21. хоол.....    |
| 2. аав.....    | 12. ах.....       | 22. гутал.....   |
| 3. найз.....   | 13. дүү.....      | 23. эхнэр.....   |
| 4. өдөр.....   | 14. багш.....     | 24. дэлгүүр..... |
| 5. дэвтэр..... | 15. эгч.....      | 25. нөхөр.....   |
| 6. үхэр.....   | 16. жолооч.....   | 26. цэцэг.....   |
| 7. гахай.....  | 17. хүүхэд.....   | 27. мод.....     |
| 8. эмээ.....   | 18. сургууль..... | 28. хэл.....     |
| 9. өглөө.....  | 19. анги.....     | 29. хичээл.....  |
| 10. ширээ..... | 20. сар.....      | 30. ажил.....    |

Шинэ үгс: гахай — pig, өглөө — morning, сургууль — school, анги — classroom, хэл — language

## Дасгал 2

Цэгийн оронд харьяалахын тийн ялгалын нөхцөл нөхөж бич. (Add the genitive case in the spaces.)

1. Тэр эмэгтэй (би) ..... ах..... найз..... найз.
2. Та..... багш..... нохой гадаа байна.
3. Баярхүү..... сургууль..... нэр "Сант."
4. Дулмаа..... өвөө..... дүү..... цамц зурагтай.
5. (Би) ..... ах..... багш..... найз том, хар машинтай.
6. Тэр хүүхэд..... аав..... ажил сонирхолтой.
7. Энэ (би) ..... өдөр..... хоол, тэр та..... орой..... хоол.
8. (Би) ..... ээж..... дүү..... найз..... багш монгол хүн.
9. Тэр хүн..... дээл..... өнгө хөх.
10. Энэ анги..... ширээ..... өнгө цагаан.
11. Энэ өрөө..... цонх том.
12. Монгол хэл..... хичээл хэцүү юү, амархан уу?
13. Та ..... монгол хэл..... багш..... нэр хэн бэ?

Шинэ үгс: орой — evening, зураг — picture, байшин — house, өдөр — day, дээл — Mongolian national clothes

**Дасгал 3**

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Таны утасны дугаар хэд вэ?
2. Таны ажлын утасны (гэрийн утасны) дугаар хэд вэ?
3. Таны гар утасны дугаар хэд вэ?
4. Таны нөхрийн ажлын утасны дугаар хэд вэ?
5. Таны найзын гар утасны (гэрийн утасны) дугаар хэд вэ?

Шинэ үгс: утас — phone, дугаар — number, гар — hand

**Дасгал 4**

Асуултыг орчуулаад хариул. (Translate the questions and answer them.)

- |                                 |   |
|---------------------------------|---|
| 1. What is your name?           | 8. What is our teacher's name?            |
| 2. What is his/her name?        | 9. What is their teacher's name?          |
| 3. What is your father's name?  | 10. What is your (plural) teacher's name? |
| 4. What is your mother's name?  | 11. Is his book interesting?              |
| 5. What is your teacher's name? | 12. Is her work difficult?                |
| 6. What is his father's name?   | 13. Is our lesson easy?                   |
| 7. What is his mother's name?   | 14. Is their house big?                   |

**Дасгал 5**

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь:

- Өнөөдөр хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ? (What is the date today?)
- Өнөөдөр 2009 оны таван сарын нэгэн. (Today is May 1, 2009.)

Өнөөдөр хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ?

- |                        |                        |
|------------------------|------------------------|
| а. 2008 он, 11 сар, 25 | в. 1999 он, 12 сар, 14 |
| б. 2000 он, 2 сар, 3   | г. 1989 он, 1 сар, 30  |

Маргааш хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ?

- |                       |                       |
|-----------------------|-----------------------|
| а. 1991 он, 10 сар, 5 | в. 2001 он, 5 сар, 11 |
| б. 2002 он, 3 сар, 9  | г. 1988 он, 2 сар, 2  |

Нөгөөдөр хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ?

- |                      |                       |
|----------------------|-----------------------|
| а. 1995 он, 4 сар, 8 | в. 2010 он, 9 сар, 31 |
| б. 1992 он, 7 сар, 6 | г. 2012 он, 6 сар, 23 |

Шинэ үгс: өнөөдөр — today, маргааш — tomorrow, нөгөөдөр — the day after tomorrow

# Есдүгээр хичээл



## Биед хамаатуулах нөхцөл (Possessive suffixes)

**миний** ах = ах **минь**

**чиний** ах = ах **чинь**

**танай** ах = ах **тань**

**таны** ах = ах **тань**

**манай** ах = ах **маань**

**түүний/тэдний** ах = ах **нь**

### Дасгал 1

Харьяалахын тийн ялгалд байгаа биеийн төлөөний үгсийг биед хамаатуулах нөхцөлөөр сольж бич. (Replace personal pronouns that have genitive cases with possessive suffixes.)

Жишээ нь: миний ном = ном минь

- |                       |                           |                         |
|-----------------------|---------------------------|-------------------------|
| 1. манай ах = .....   | 8. тэдний цай = .....     | 15. тэдний охин = ..... |
| 2. миний найз = ..... | 9. манай хүүхэд = .....   | 16. миний зураг = ..... |
| 3. чиний ээж = .....  | 10. тэдний анги = .....   | 17. танай гэр = .....   |
| 4. танай найз = ..... | 11. чиний гутал = .....   | 18. түүний багш = ..... |
| 5. таны морь = .....  | 12. чиний машин = .....   | 19. түүний цамц = ..... |
| 6. манай аав = .....  | 13. таны сургууль = ..... | 20. таны гар = .....    |
| 7. чиний гэр = .....  | 14. манай байр = .....    | 21. танай охин = .....  |

### Дасгал 2

Биед хамаатуулах нөхцөлийг харьяалахын тийн ялгалд байгаа биеийн төлөөний нэрээр сольж бич. (Replace possessive suffixes with personal pronouns that have genitive cases.)

Жишээ нь: ном минь = миний ном

- |                      |                         |                           |
|----------------------|-------------------------|---------------------------|
| 1. найз тань = ..... | 8. морь тань = .....    | 15. гутал чинь = .....    |
| 2. ах маань = .....  | 9. охин нь = .....      | 16. охин тань = .....     |
| 3. гэр тань = .....  | 10. найз минь = .....   | 17. зураг минь = .....    |
| 4. цай нь = .....    | 11. байр маань = .....  | 18. аав маань = .....     |
| 5. гар чинь = .....  | 12. гэр чинь = .....    | 19. цамц нь = .....       |
| 6. анги чинь = ..... | 13. багш нь = .....     | 20. сургууль тань = ..... |
| 7. анги нь = .....   | 14. хүүхэд тань = ..... | 21. ээж чинь = .....      |

### Дасгал 3

Гэр бүлийнхээ болон найзынхаа тухай биед хамаатуулах нөхцөлийг ашиглан ярь. (Talk about your family and a friend using the possessive suffixes.)

## Дасгал 4

Харьяалахын тийн ялгалд байгаа биеийн төлөөний нэрийг биед хамаатуулах нөхцөлөөр сольж бич. (Replace personal pronouns that have genitive cases with possessive suffixes.)

Жишээ нь: Миний ах нэг хүүхэдтэй. → Ах минь нэг хүүхэдтэй.

- |                                     |                              |
|-------------------------------------|------------------------------|
| 1. Миний нохой их хөөрхөн.          | 12. Таны оюутан гадаа байна. |
| 2. Тэдний өвөө сайн хүн.            | 13. Танай хүү гэрт байна.    |
| 3. Чиний цэцэг шар.                 | 14. Тэдний машин хар.        |
| 4. Миний муур хар.                  | 15. Миний морь гадаа байна.  |
| 5. Түүний гэр их том.               | 16. Танай муур өрөөнд байна. |
| 6. Чиний машин үнэтэй.              | 17. Миний цүнх бор.          |
| 7. Манай байр шинэ.                 | 18. Түүний ном өрөөнд байна. |
| 8. Манай хүү дулаан хувцастай.      | 19. Манай аав сайн жолооч.   |
| 9. Чиний нэр сонирхолтой.           | 20. Чиний найз муу хүн биш.  |
| 10. Түүний ээж багш.                | 21. Түүний гэр дулаан.       |
| 11. Түүний сургууль олон оюутантай. | 22. Түүний цамц шар.         |



## Үндэс үүсгэх "-х" дагавар (Suffix "-х")

Suffix "-х" is used after genitive case and means " 's."

For example:

|                                 |                                 |
|---------------------------------|---------------------------------|
| Энэ таны <b>х</b> .             | This is yours.                  |
| Тэр <b>миний</b> х.             | That's <b>mine</b> .            |
| Энэ манай багший <b>н</b> х.    | This is our teacher's.          |
| Тэр үзэг Бурмаагийн <b>н</b> х. | That pen is Burmaa's.           |
| Энэ танай дүүгийн <b>н</b> х.   | This is your younger sibling's. |
| Энэ танай эгчий <b>н</b> х.     | This is your sister's.          |

## Дасгал 5

Нэр үгсийг хасч, "-х" дагаврыг харьяалахын тийн ялгалтай үгст залгаж бич. (Take out nouns and add the suffix "-х" after the personal pronouns and nouns with genitive cases.)

Жишээ нь: Энэ манай аавын машин. → Энэ манай аавынх.

- |                        |                                  |
|------------------------|----------------------------------|
| 1. Энэ миний ном.      | 7. Энэ танай компьютер.          |
| 2. Тэр таны үзэг.      | 8. Энэ манай багшийн малгай.     |
| 3. Тэр түүний дэвтэр.  | 9. Энэ танай эгчийн гутал.       |
| 4. Энэ бид нарын хоол. | 10. Тэр, Батхүүгийн ахын машин.  |
| 5. Энэ та нарын ширээ. | 11. Энэ манай дүүгийн сандал.    |
| 6. Энэ тэд нарын бал.  | 12. Энэ манай өвөөгийн харандаа. |

## Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

- |                                     |  |
|-------------------------------------|--|
| 1. This is mine.                    | 10. This is our mother's friend's.           |
| 2. This is yours.                   | 11. This is our mother's friend's child's.   |
| 3. This is Bathuu's.                | 12. This is yours, not mine.                 |
| 4. Mine is big. Yours is small.     | 13. Whose is that?                           |
| 5. Hers is nice.                    | 14. Whose is this?                           |
| 6. His is new. Mine is old.         | 15. Is this mine or yours?                   |
| 7. Mine is correct. Yours is wrong. | 16. Is this yours or hers?                   |
| 8. Ours is blue. Yours is white.    | 17. Is that our teacher's?                   |
| 9. This is my mother's.             | 18. Is that your sister's or your brother's? |

Шинэ үг: ball point pen — бал

## Хүмүүстэй танилцах (To get to know people)

- |                                  |  |
|----------------------------------|--|
| A: — Таны/чиний нэр хэн бэ?      | A: — What is your name?                          |
| B: — Миний нэр .....             | B: — My name is .....                            |
| — Таныг хэн гэдэг вэ?            | — What is your name?                             |
| A: — Намайг ..... гэдэг.         | A: — My name is .....                            |
| 1. Дэлгүүр хэдэн цагт нээх вэ?    | 8. Хичээл хэдэн цагт эхлэх вэ?               |
| 2. Та хаана амрах вэ?             | 9. Та хаашаа явах вэ?                        |
| 3. (Би) цонх нээх үү?             | 10. Таны ажил хэзээ эхлэх вэ?                |
| 4. Та хэзээ кино үзэх вэ?         | 11. Та хөдөө машинаар <sup>23</sup> явах уу? |
| 5. Банк 5 цагт хаах уу?           | 12. Та удахгүй амрах уу?                     |
| 6. Банк хэдэн цагт хаах вэ?       | 13. Хичээл 12 цагт дуусах уу?                |
| 7. Таны хичээл нэг цагт эхлэх үү? | 14. Хичээл хэдэн цагт дуусах вэ?             |

Шинэ үг: дуусах — to be finished

## Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)


- (What kind of, from where) Will you buy a car soon?
- (Which, what time) Will you go to the store?
- (When, what kind of food) Will you cook?
- (When, what time) Will you be home?
- (How many years) Will you stay here for many years?
- (Where, what time) Will you meet with your friend?
- (When) Will you rest?
- (What time) Will you come here?
- (With whom, where) Will you eat food?
- (When) Will you live in the countryside?

<sup>23</sup> -аар<sup>4</sup> — by (If you want to know more about this, see Lesson 40.)

For example: машинаар — by car, мориор — by horse, таксигаар — by taxi, автобусаар — by bus, онгоцоор — by airplane.

## Дасгал 5

Дорх зургуудыг хараад маргааш Ганхүүгийн юу юу хийхийг бич. (Look at the pictures below and write down what Ganhuu will do tomorrow.)



## Дасгал 6

Хүснэгтийг бөглөж, үг бүр дээр өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences with each word.)

Жишээ нь: зурах → зур, зураарай, зурсан, зурна, зурах дуртай, зурах хэрэгтэй

Та цэцэг зур.                      Тэр олон морь зурна.  
 Та мод зураарай.              Тэр зураг зурах дуртай.  
 Би хувцас зурсан.              Та гэр зурах хэрэгтэй.

| Infinitive | Verb stem | Please | Past tense | Future tense | like | need |
|------------|-----------|--------|------------|--------------|------|------|
| сурах      |           |        |            |              |      |      |
| дуулах     |           |        |            |              |      |      |
| бүжиглэх   |           |        |            |              |      |      |
| алхах      |           |        |            |              |      |      |
| гүйх       |           |        |            |              |      |      |

Шинэ үгс: дуулах — to sing, бүжиглэх — to dance, алхах — to walk, гүйх — to run

## Дасгал 7

Хүснэгтийг бөглөж, үг бүр дээр өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences with each word.)

| Infinitive | didn't | won't | don't like to ... | don't need to ... |
|------------|--------|-------|-------------------|-------------------|
| зурах      |        |       |                   |                   |
| сонсох     |        |       |                   |                   |
| сурах      |        |       |                   |                   |
| дуулах     |        |       |                   |                   |
| бүжиглэх   |        |       |                   |                   |

# Арван дөрөвдүгээр хичээл



## Хамтрахын тийн ялгал (Comitative case)

-тай<sup>3</sup> (have, with), -гүй (don't have, without)

Би нэг ах**тай**.

I **have** one brother.

Би Бат**тай** хөдөө явсан.

I went to the countryside **with** Bat.

Тэр найз**тайгаа** хоол идсэн.

He ate food **with his** friend.

### Spelling rules:

|   | Suffixes | Examples                |
|---|----------|-------------------------|
| After nouns with <b>а</b> or <b>у</b>       | -тай     | найзтай, устай          |
| After nouns with <b>э, ү, ө</b> or <b>и</b> | -тэй     | дүүтэй, өвөөтэй, эгчтэй |
| After nouns with <b>о</b>                   | -той     | жолоочтой, хоолтой      |
| After all nouns                             | -гүй     | найзгүй, дүүгүй, эгчгүй |

**Note:** When the possessive suffix **-аа<sup>4</sup>** is added after **-тай<sup>3</sup>**, **-г** is inserted between them.  
For example: ахтайгаа, дүүтэйгээ, өвөөтэйгөө, жолоочтойгоо.

### Question pronouns and personal pronouns:

юу → юутай

та → тантай

бид → бидэнтэй

хэн → хэнтэй

чи → чамтай

та нар → та нартай

би → надтай

тэр → түүнтэй

тэд → тэдэнтэй

## Дасгал 1

Нэр үгст хамтрахын тийн ялгалын болон биед хамаатуулах нөхцөл залгаж бич. (Add the comitative case and possessive suffixes to nouns.)

Жишээ нь: Би найз..... уулзсан. → Би найзтайгаа уулзсан.

1. Тэд аав ээж..... гадаа алхах дуртай.
2. Жаргалмаа ах..... монгол дуу дуулсан.
3. Оюутан багш..... хичээл хийх дуртай.
4. Тэр дүү..... гадаа тоглосон.
5. Тэд ээж..... гэртээ байсан.
6. Бид захирал..... ярих хэрэгтэй.
7. Багш охин..... гэрээ цэвэрлэсэн.
8. Би хүүхдүүд..... бүжиглэнэ.
9. Хүүхдүүд багш..... мэндэлдэг.

Шинэ үг: мэндлэх — to greet

## Дасгал 2

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Та хэнтэй Монголд ирсэн бэ?
2. Та хэнтэй гадаа алхдаг вэ?
3. Та хэн хэнтэй амьдардаг вэ?
4. Та өнгөрсөн сард хэнтэй хичээл хийсэн бэ?
5. Та ирэх сард хэнтэй кино үзэх вэ?
6. Та хэнтэй ажиллах дуртай вэ?
7. Та өнгөрсөн долоо хоногт хэнтэй хоол идсэн бэ?
8. Та ирэх долоо хоногт хэнтэй уулзах хэрэгтэй вэ?
9. Та ер нь хэнтэй тоглоом тоглодог вэ?
10. Та хэнтэй ярих дуртай вэ?
11. Та хэнтэй хөдөө явах дуртай вэ?
12. Хүүхдүүд хэн хэнтэй мэндэлдэг вэ?

## Дасгал 3

Эхний хүснэгтэн дэх биеийн төлөөний үгсийг хамтрахын тийн ялгалын нөхцөлөөр хувирган, өмнөх хуудаснаас харж, алдаагаа зас. Өмнөх хүснэгтээ харалгүй дараагийн хүснэгтүүдээ бөглөж бичин, өөрийгөө шалгаарай. (Add comitative cases to personal pronouns in the first table, then look at the previous page and correct them. Fill out the last tables without looking at the first one, then check your answers.)

| ХЭН       | ХЭНТЭЙ  |
|-----------|---------|
| Би        | тэйгээр |
| Чи        | тэйгээр |
| Та        | тэйгээр |
| Тэр       | тэйгээр |
| Бид (нар) | тэйгээр |
| Та нар    | тэйгээр |
| Тэд (нар) | тэйгээр |

| ХЭН       | ХЭНТЭЙ |
|-----------|--------|
| Тэд (нар) |        |
| Та нар    |        |
| Бид (нар) |        |
| Тэр       |        |
| Та        |        |
| Чи        |        |
| Би        |        |

| ХЭН       | ХЭНТЭЙ |
|-----------|--------|
| Тэр       |        |
| Тэд (нар) |        |
| Чи        |        |
| Би        |        |
| Бид (нар) |        |
| Та нар    |        |
| Та        |        |

## Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Би, тэр, мэндлэх
2. Тэр, би, ярих, хэрэгтэй
3. Тэд, та, тоглох
4. Та, тэр, бүжиглэх
5. Бид, тэд нар, хоол хийх, дуртай
6. Та, би, хичээл, хийх
7. Би, та, алхах
8. Би, та нар, амьдрах
9. Тэр, чи, байх
10. Би, чи, дуулах
11. Та нар, бид нар, хөдөө, явах
12. Та нар, би, ажил хийх
13. Тэр, чи, кино, үзэх
14. Тэр, та, уулзах

## Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

- Whom will you meet with here next week?  
Next week I will meet my friend (doctor, director) here.
- Whom did you do your lesson with?  
I did my lesson with my friend (sister, brother, mother, father).
- Whom did you go to Terelj with last Sunday?  
I went to Terelj with my driver (wife/husband, dog, cat).
- Whom will you run outside tomorrow morning with?  
I will run with my dog (child, son, daughter).
- Whom do you like to sing with?  
I like to sing with Bayarhuu (John, Gerelmaa, Bolormaa).

## Дасгал 6

Жишээ өгүүлбэрт бичсэний адилаар өгүүлбэр зохио. (Make sentences as in the examples.)

Жишээ:

Улаан малгайтай хүн миний ах. (The person with the red hat is my brother.)

Хар цамцтай эмэгтэй хоол хийнэ. (The woman with the black shirt will cook.)

- ..... эрэгтэй хүн
- ..... багш
- ..... хүүхэд
- ..... эмээ
- ..... жолооч
- ..... оюутан
- ..... сурагч
- ..... хүү
- ..... өвөө

## Талархал илэрхийлэх (To express thankfulness)

A: — Баярлалаа.

B: — Зүгээр (зүгээр).

— Маш их баярлалаа.

— Ёстой их баярлалаа.

— Ирсэнд баярлалаа.

— (Надад) тусалсанд баярлалаа.

— Асуусанд баярлалаа.

— (Надад) хэлсэнд баярлалаа.

A: — Thank you.

B: — You are welcome.

— Thank you very much.

— Thank you very, very much.

— Thank you for coming.

— Thank you for helping (me).

— Thank you for asking.

— Thank you for telling (me).

# Арван тавдугаар хичээл



## Одоо цаг (Present tense)

### Spelling rules:

|                         | After verb stems with <b>а, у</b> or <b>я</b> | After verb stems with <b>э, ү</b> or <b>и</b> | After verb stems with <b>о</b> | After verb stems with <b>ө</b> |
|-------------------------|---|---|--------------------------------|--------------------------------|
| <b>Affirmative form</b> | -даг  | -дэг  | -дог                           | -дөг                           |
| <b>Negative form</b>    | -даггүй                                       | -дэггүй                                       | -доггүй                        | -дөггүй                        |
| <b>Question form</b>    | -даг уу/вэ?                                   | -дэг үү/вэ?                                   | -дог уу/вэ?                    | -дөг үү/вэ?                    |

For example:

Тэр сургуульд **сурдаг**.

Тэр сургуульд **сурдаггүй**.

Тэр сургуульд **сурдаг уу?** (surdguu)

Тэр ямар сургуульд сурдаг вэ?

Би дандаа нэг цагт өдрийн хоол иддэг.

Тэд ер нь архи уудаггүй.

Би сард нэг удаа хөдөө явдаг.

He **studies** at a school.

He **doesn't study** at a school.

Does he study at a school?

In what school does he study?

I always eat lunch at one o'clock.

They don't drink vodka in general.

I go to the countryside once a month.

This suffix can be added directly to verb stems that end with consonant, vowel or soft sign. For example:

Тэр монгол хэл мэддэг.

Би энд суудаг.

Би машин барьдаг\*.

He knows Mongolian.

I sit here.

I drive a car.

\*барих — to hold/to catch, машин барих — to drive a car, байшин барих — to build a house, загас барих — to catch a fish, цаг барих — to be on time

### Key words for present tense:

өдөр бүр

сар бүр

жил бүр

өглөө бүр

орой бүр

шөнө бүр

дандаа

байнга

үргэлж

every day

every month

every year

every morning

every evening

every night

always

constantly

often

заримдаа

ер нь

хааяа

ховор

7 хоногт нэг удаа

сард нэг удаа

жилд нэг удаа

өдөрт 3 удаа

sometimes

in general

seldom

rarely

once a week

once a month

once a year

3 times a day

## Дасгал 1

Хүснэгтийн дээд талын эгнээнд байгаа загварын дагуу үйл үгийн үндсүүдэд одоо цагийн нөхцөлийг залгаж, асуулт зохио. Дараа нь өгүүлбэр зохио. (Add suffixes for present tense to the verb stems and make short questions as in the examples at the top of the table. Then make sentences with them.)

|     | эхэлдэг     | эхэлдэг үү? | хэзээ эхэлдэг вэ? | эхэлдэггүй  | эхэлдэггүй юү? |
|-----|-------------|-------------|-------------------|-------------|----------------|
| 1.  | яв.....     |             |                   | яв.....     |                |
| 2.  | сонс.....   |             |                   | сонс.....   |                |
| 3.  | унш.....    |             |                   | унш.....    |                |
| 4.  | амьдар..... |             |                   | амьдар..... |                |
| 5.  | тогло.....  |             |                   | тогло.....  |                |
| 6.  | сур.....    |             |                   | сур.....    |                |
| 7.  | ид.....     |             |                   | ид.....     |                |
| 8.  | уулз.....   |             |                   | уулз.....   |                |
| 9.  | уу.....     |             |                   | уу.....     |                |
| 10. | бай.....    |             |                   | бай.....    |                |
| 11. | хий.....    |             |                   | хий.....    |                |
| 12. | амар.....   |             |                   | амар.....   |                |

Жишээ нь:

Манай хичээл 9 цагт эхэлдэг.

Танай хичээл 9 цагт эхэлдэг үү?

Танай хичээл хэдэн цагт эхэлдэг вэ?

Манай хичээл 9 цагт эхэлдэггүй.

Танай хичээл 9 цагт эхэлдэггүй юү?

Танай хичээл яагаад 9 цагт эхэлдэггүй вэ?

## Дасгал 2

Асуултуудыг сонсоод, хариулж бич. (Listen to the questions and answer them.)

1. Та өдөр бүр юу хийдэг вэ?
2. Та өглөө/орой юу иддэг вэ?
3. Танай гэр хаана байдаг вэ?
4. Та нар гэрт амьдардаг уу, байшинд амьдардаг уу?
5. Та нар Монголд ямар ажил хийдэг вэ?
6. Та ямар ямар хэл мэддэг вэ?
7. Та ер нь их алхдаг уу?
8. Та машин барьдаг уу?
9. Та нар архи уудаг уу?
10. Танай гэр бүл бүтэн сайн өдөр юу хийдэг вэ?
11. Та хүмүүстэй өдөрт хэдэн удаа мэндэлдэг вэ?
12. Та долоо хоногт хэдэн удаа хичээл хийдэг вэ?
13. Та жилд хэдэн удаа хөдөө явдаг вэ?
14. Та сард хэдэн удаа банк руу явдаг вэ?

Шинэ үгс: байшин — house, архи — vodka, гэр бүл — family

## Дасгал 3

Ашигээ өгүүлбэрт бичсэний адилаар асуулт зохио. (Make questions as in the example.)

- Ашигээ: Би хагас сайн өдөр найзтайгаа ресторанд хоол иддэг.  
 — Та хагас сайн өдөр найзтайгаа ресторанд хоол иддэг үү?  
 — **Хэн** хагас сайн өдөр найзтайгаа ресторанд хоол иддэг вэ?  
 — Та **хэзээ** найзтайгаа ресторанд хоол иддэг вэ?  
 — Та хагас сайн өдөр **хэнтэй** ресторанд хоол иддэг вэ?  
 — Та хагас сайн өдөр найзтайгаа **хаана** хоол иддэг вэ?

1. Би өглөө 9 цагт сургуульдаа ирдэг.
2. Манай ээж орой бүр гэртээ монгол хоол хийдэг.
3. Тэр бүтэн сайн өдөр бүр найзтайгаа Тэрэлж рүү явдаг.
4. Би өдөр бүр шинэ талх авдаг.
5. Би орой бүр нэг цаг өрөөндөө номоо уншдаг.
6. Баярхүү найздаа сайхан имэйл бичдэг.
7. Баярхүү үдээс хойш монгол хүүхэдтэй гадаа теннис тоглодог.
8. Би өглөө нийхэртэй талх иддэг. Бас сүүтэй халуун цай уудаг.
9. Би заримдаа найзтайгаа ресторанд уулздаг.
10. Би найзтайгаа 15 дугаар хороололд, 14 дүгээр байранд амьдардаг.

— инэ үгс: дугаар — -th, хороолол — district, байр — apartment

## Дасгал 4

Элчвэрийг унш. (Read the text.)

Миний нэр Цэцэг. Би 15 настай. Би сургуулийн сурагч. Би аав ээжтэйгээ 13 дугаар хороололд амьдардаг. Би өдөр бүр 7 цагт босдог. Тэгээд усанд ордог. Өглөөний цайгаа уудаг. Тэгээд 8:30-д сургууль руугаа явдаг. Манай хичээл өглөө бүр 9 цагт эхэлдэг. Хичээл ер нь 12 цагт дуусдаг.

Би хичээлийн дараа гэртээ ирдэг. Өдрийн хоолоо иддэг. Дараа нь жаахан амардаг. Тэгээд гэрийн даалгавраа хийдэг. Би 7 хоногт хоёр удаа дэлгүүр лүү явдаг. Дэлгүүрээс мах, сүү, ногоо, жимс авдаг. 6 цагт оройн хоолоо хийдэг. Манай аав ээж хоёр, ажлаасаа 7 цагт ирдэг. Бид хамт оройн хоолоо иддэг. Дараа нь заримдаа зурагт үздэг, заримдаа тоглоом тоглодог. Би хааяа найзтайгаа театрт концерт үздэг. Бид ер нь 11 цагт унтдаг.


— инэ үгс: босох — to get up/to stand up, усанд орох — to take a bath, сурагч — pupil, унтах — to sleep

## Дасгал 5

Өдөр бүр юу хийдэг тухайгаа бич. (Write down what you do everyday.)

## Дасгал 6

Доорх зургуудыг хараад Ганхүүгийн өдөр бүр юу хийдгийг бич. (Look at the pictures below and write down what Ganhuu does every day.)



## Дасгал 7

Өгүүлбэрт асуулт зохио. (Make questions out of the sentences.)

1. Тэд үржигдар энд ном авчирсан.
2. Ер нь хүүхэд сургуульдаа тоглоом авчрах дуртай.
3. Бид ангидаа монголоор ярьдаг.
4. Би өчигдөр үдээс хойш загас барьсан.
5. Ер нь монгол хүмүүс гэр сайн барьдаг.
6. Манай хүүхэд том болсон.
7. Гэр хүмүүстэй мэндэлдэггүй.
8. Машин энд зогсдог.
9. Би шинэ үгээ мартдаггүй.

Шинэ үгс: авчрах — to bring, монголоор — in Mongolian, ярих — to speak/ to talk, болох — to become, зогсох — to stop/to stand, энд — here, мартаx — to forget

# Давтлага хичээл

## Дасгал 1

Эгүүлбэр бүрт хоёр хоёр асуулт зохио. (Make two questions for each sentence.)

1. Би гэртээ цай уусан.
2. Тэр их сайхан бүжиглэдэг.
3. Баярхүү шинэ машин авсан.
4. Бид уржигдар энд хичээл хийсэн.
5. Та нар гадаа тоглох хэрэгтэй.
6. Манай хүү бүжиглэх дуртай.
7. Тэр маргааш ангид дуулна.
8. Жаргалмаа найзтайгаа тоглосон.
9. Тэд хөдөө явсан.
10. Би найзтайгаа удахгүй уулзана.
11. Би өдөр бүр хичээлээ хийдэг.
12. Би өнгөрсөн жил Америкаас ирсэн.
13. Тэд ирэх жил Монголд байна.
14. Хүүхдүүд монгол гэрт амьдардаг.

## Дасгал 2

Асуултад үгүйсгэсэн хариулт бич. (Write negative answers to the questions.)

1. Чи дэлгүүр лүү явсан уу?
2. Та нар дэлгүүрээс мах авах уу?
3. Тэд нар ер нь ном уншдаг уу?
4. Та хичээлээ ойлгосон уу?
5. Та хоолоо идсэн үү?
6. Та кофе уух дуртай юу?
7. Чи дэвтрээ авчирсан уу?
8. Чи дуулах дуртай юу?
9. Тэд алхах хэрэгтэй юү?
10. Маргааш гадаа хүйтэн болох уу?
11. Чи шинэ үгээ амархан мартдаг уу?
12. Хүүхдүүд хичээл бичих дуртай юу?
13. Хүүхдүүд дандаа тоглох хэрэгтэй юү?
14. Чи орой эмээ өвөөтэйгөө уулзах уу?
15. Улаанбаатарт казино байдаг уу?
16. Чи өдөрт нэг удаа хоол хийдэг үү?
17. Та хагас, бүтэн сайн өдөр амрах уу?
18. Чи өнөө(дөр) өглөө гүйсэн үү?

## Дасгал 3

"Хэрэгтэй" гэдэг үгийг ашиглан өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the word "хэрэгтэй.")

Жишээ нь: Би өнөөдөр хоол идээгүй. → Чи хоол идэх хэрэгтэй.

1. Би 6 цаг гадаа тоглосон.
2. Би дандаа машинаар явдаг.
3. Би хичээл хийх их дургүй.
4. Би дандаа сүүтэй цай уудаг.
5. Би ажил хийдэггүй.
6. Би энэ жил амрахгүй.
7. Би кино их үздэг.
8. Би өглөө босох дургүй.
9. Би ус уух дургүй.
10. Би найзтайгаа ер нь их ярьдаггүй.
11. Би их жаахан хоол иддэг.
12. Би ном уншдаггүй.
13. Би хүмүүстэй мэндэлдэггүй.
14. Би монгол хэл сурахгүй.

## Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

- |   |  |
|---|--|
| 1. They met their parents.                | 9. Children like to play with their parents.   |
| 2. Children greet their teacher.          | 10. You need to talk with your younger sister. |
| 3. I live with my grandparents.           | 11. You need to work with your brother.        |
| 4. I will go to the countryside with him. | 12. She likes to eat food with her friend.     |
| 5. They danced with the children.         | 13. I like to sing with Mongolian people.      |
| 6. He will walk outside with me.          | 14. You need to study with him.                |
| 7. He always talks with his children.     | 15. They won't go with us.                     |
| 8. They met me.                           | 16. I didn't meet them.                        |

## Дасгал 5

Доогуур нь зурсан үгст биед хамаатуулах (-aa<sup>4</sup>) нөхцөл залгаж, ялгааг нь багштайгаа ярилц. (Add possessive suffix -aa<sup>4</sup> to underlined words and talk about the differences with your teacher.)

- |                                     |  |
|-------------------------------------|--|
| 1. Тэр <u>хичээл</u> хийсэн.        | 6. Би <u>сургуулиас</u> энд ирсэн.       |
| 2. Бид <u>ээжтэй</u> уулзана.       | 7. Та нар <u>гэрт</u> байх хэрэгтэй.     |
| 3. Тэд <u>ангид</u> байсан.         | 8. Манай дүү <u>ном</u> унших их дуртай. |
| 4. Хүүхдүүд <u>багштай</u> дуулдаг. | 9. Ах чинь <u>гэр</u> цэвэрлэсэн.        |
| 5. Би <u>эгчтэй</u> уулзсан.        | 10. Би <u>машин</u> угаана.              |

## Дасгал 6

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан, холбож зур. (Match Mongolian and English words by connecting them with lines.)

|            |                |             |               |
|------------|----------------|-------------|---------------|
| дугаар     | there          | архи        | family        |
| хороолол   | house          | гэр бүл     | soon          |
| сурагч     | district       | ирэх жил    | morning       |
| усанд орох | to sleep       | сарын дараа | after a month |
| босох      | to get up      | удахгүй     | evening       |
| унтах      | pupil          | өглөө       | afternoon     |
| тэнд       | -th            | орой        | vodka         |
| байшин     | to take a bath | үдээс хойш  | next year     |

# Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.

(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Та монгол гэрт амьдардаг үү?  
B. Та монгол гэрт амьдардаг юу?  
C.  Та монгол гэрт амьдардаг уу?
2. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Та өчигдөр хоол хийсэн үү?  
B. Та өчигдөр хоол хийсэн уу?  
C. Та өчигдөр хоол хийсэн юу?
3. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Тэд хэзээ энд ирсэн вэ?  
B. Тэд хэзээ энд ирсэн үү?  
C.  Тэд хэзээ энд ирсэн бэ?
4. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Чи нөгөөдөр орой кино үзнэ үү?  
B.  Чи нөгөөдөр орой кино үзэх үү?  
C. Чи нөгөөдөр орой кино үзэх уу?
5. He didn't bring his book.  
A. Тэр номоо авчрахгүй.  
B.  Тэр номоо авчраагүй.  
C. Тэр номоо авчирдаггүй.
6. I don't run.  
A. Би гүйгээгүй.  
B.  Би гүйхгүй.  
C. Би гүйдэггүй.
7. They won't walk.  
A.  Тэд алхахгүй.  
B. Тэд алхаагүй.  
C. Тэд алхдаггүй.
8. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Бид ирэх жил сургуульд сурсан.  
B.  Бид ирэх жил сургуульд сурна.  
C. Бид ирэх жил сургуульд сурдаг.
9. Аль нь зөв бэ? Which one is right?  
A.  Би уржигдар хөдөө байсан.  
B. Би уржигдар хөдөө байна.  
C. Би уржигдар хөдөө байдаг.
10. Аль нь зөв бэ? Which one is right?  
A.  Тэр заримдаа архи уудаг.  
B. Тэр заримдаа архи уусан.  
C. Тэр заримдаа архи ууна.
11. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Хүүхдүүд гадаа тоглодог дуртай.  
B.  Хүүхдүүд гадаа тоглох дуртай.  
C. Хүүхдүүд гадаа тогло дуртай.
12. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Хүмүүс амрах хэрэгтэй.  
B. Хүмүүс амар хэрэгтэй.  
C. Хүмүүс амарсан хэрэгтэй.
13. I did my lesson.  
A.  Би хичээлээ хийсэн.  
B. Би хичээл минь хийсэн.  
C. Би миний хичээл хийсэн.
14. You need to talk with your friend.  
A. Чи чиний найзтай ярих хэрэгтэй.  
B. Чи найзаатай ярих хэрэгтэй.  
C.  Чи найзтайгаа ярих хэрэгтэй.
15. I was at my house last night.  
A.  Би өчигдөр орой гэртээ байсан.  
B. Би өчигдөр орой гэрт байсан.  
C. Би өчигдөр орой гэртэй байсан.
16. She bought a bag from the store.  
A. Тэр, дэлгүүрээсээ цүнх авсан.  
B.  Тэр, дэлгүүрээс цүнх авсан.  
C. Тэр, дэлгүүр цүнх авсан.

Оноо (point): 16/.....

# Арван зургадугаар хичээл



## Үйл үгийн -маар<sup>4</sup> нөхцөл (Verb suffix -маар<sup>4</sup>)

-маар<sup>4</sup> байна/-маар<sup>4</sup>гүй байна (want to/don't want to)  
-маар<sup>4</sup> байсан/-маар<sup>4</sup>гүй байсан (wanted to/didn't want to)

### Spelling rules:

|                         | After verb stems with <b>а, у or я</b> | After verb stems with <b>э, ү or и</b> | After verb stems with <b>о</b> | After verb stems with <b>ө</b> |
|-------------------------|--|--|--------------------------------|--------------------------------|
| <b>Affirmative form</b> | -маар байна                            | -мээр байна                            | -моор байна                    | -мөөр байна                    |
| <b>Negative form</b>    | -мааргүй байна                         | -мээргүй байна                         | -мооргүй байна                 | -мөөргүй байна                 |
| <b>Question form</b>    | -маар байна уу?                        | -мээр байна уу?                        | -моор байна уу?                | -мөөр байна уу?                |

For example:

Би шинэ дуу **сурмаар байна**.

I **want to learn** a new song.

Би шинэ дуу **сурмааргүй байна**.

I **don't want to learn** a new song.

Та шинэ дуу сурмаар байна уу?

Do you want to learn a new song?

Та ямар дуу сурмаар байна вэ?

What song do you want to learn?

This suffix can be added directly to verb stems that end with consonants or vowels.

For example: уншмаар байна, хиймээр байна, тогломоор байна.

But when we add this suffix to verb stems that end with a soft sign, the soft sign becomes **и**. For example: барь + маар байна = баримаар байна.

## Дасгал 1

Эхлээд үйл үгийн үндсэн дээр "-маар<sup>4</sup> байна" нөхцөлийг залгаж, дараа нь өгүүлбэр зохио. (First add "-маар<sup>4</sup> байна" to verb stems, then make sentences.)

Жишээ нь: тогло → А. тогломоор байна. Б. Би одоо гадаа тогломоор байна.

1. амар

8. мэд

15. бүжиглэ

2. бай

9. бол

16. ав

3. ид

10. ярь

17. яв

4. хаа

11. унт

18. хий

5. нээ

12. бос

19. сур

6. авчир

13. дуул

20. март

7. барь

14. алх

21. өг

Шинэ үгс: мэдэх — to know, өгөх — to give

## Дасгал 2

Доорх нөхцөл байдлуудад тохируулан юу хийхийг хүсэж байгаа болон хүсэхгүй байгаагаа бич. (Write down what you want to do or what you don't want to do in each situation below.)

А. Жишээ нь: Та дандаа бууз иддэг. → Би бууз идмээргүй байна. Хуушуур идмээр байна.

- |                                  |                                 |
|----------------------------------|---------------------------------|
| 1. Та өдөр бүр сүүтэй цай уудаг. | 7. Гэрт их халуун байна.        |
| 2. Та олон цаг ажилласан.        | 8. Та гадаа олон цаг байсан.    |
| 3. Та ном унших их дуртай.       | 9. Та дандаа машинаар явдаг.    |
| 4. Та шөнө сайн унтаагүй.        | 10. Та зүгээр суух дургүй.      |
| 5. Та юм мартдаггүй.             | 11. Та дандаа алхдаг.           |
| 6. Та Монголд байна.             | 12. Та өглөө бүр 5 цагт босдог. |

Б. Жишээ нь: Цай уугаарай. → Би цай уумааргүй байна. Ус уумаар байна.

- |                         |                                 |
|-------------------------|---------------------------------|
| 1. Номоо уншаарай.      | 8. Одоо машин бариарай.         |
| 2. Гэрээ цэвэрлээрэй.   | 9. Чи хөдөө явах хэрэгтэй.      |
| 3. Хичээлээ хийгээрэй.  | 10. Чи номоо авчрах хэрэгтэй.   |
| 4. Чи гадаа суугаарай.  | 11. Чи эмч болох хэрэгтэй.      |
| 5. Чи гэртээ байгаарай. | 12. Та одоо дуулаарай.          |
| 6. Гадаа тоглоорой.     | 13. Та одоо бүжиглээрэй.        |
| 7. Миний хүү, унтаарай. | 14. Бүтэн сайн өдөр ажиллаарай. |

Шинэ үг: зүгээр — just

## Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: Би, гадаа, тоглох

А. Би гадаа тогломоор байсан. Гэхдээ хүйтэн байсан. Тэгээд би тоглоогүй.

(I wanted to play outside. But it was cold outside, so I didn't play.)

Б. Би гадаа тогломооргүй байсан. Гэхдээ найзтайгаа тоглосон.


(I didn't want to play outside but I played with my friend.)

- |                   |                         |
|-------------------|-------------------------|
| 1. Би, амрах      | 6. Тэр, усанд орох      |
| 2. Тэр, ажиллах   | 7. Хүү, гараа угаах     |
| 3. Би, дуулах     | 8. Тэр, монголоор ярих  |
| 4. Би, бүжиглэх   | 9. Бид, автобусаар явах |
| 5. Тэд нар, босох | 10. Хүмүүс, амрах       |

Шинэ үг: ажиллах — to work

## Дасгал 4

Доорх зургуудыг хараад Ганхүүгийн юу хийхийг хүсэж байгааг бич. (Look at the pictures below and write down what Ganhuu wants to do.)



## Зөөлний тэмдэгтэй холбоотой дүрэм (Rules related to the soft sign)

Монгол баавар — 7

Цоожоо засаад тушаачих — 9

vowel — v

я, ё — (let me ...)

| $7\text{ь} + 9 = 7\text{ь}9$ | $7\text{ь} + 7 = 7\text{и}7$ | $9\text{ь} + 9 = 9\text{и}9$ | $9\text{ь} + 7 = 9\text{и}7$ | $7\text{ь} + \text{vv} = 7\text{ив}$<br>$9\text{ь} + \text{vv} = 9\text{ив}$ | $7\text{ь} + \text{я} = 7\text{ья}$<br>$9\text{ь} + \text{ё} = 9\text{ье}$ |
|------------------------------|------------------------------|------------------------------|------------------------------|--|--|
| барьсан                      | барина                       | захисан                      | захина                       | бариарай   | барья  |
| барьдаг                      | бариг                        | захидаг                      | захиг                        | болиод   | больё  |
| барьжээ                      | барилаа                      | захижээ                      | захилаа                      | цохиорой   | цохьё  |
| барьчих                      | барив                        | захичих                      | захив                        | цохиод   | захья  |

Шинэ үгс: барь — hold, захь — order, цохь — hit, боль — stop

## Дасгал 5

Үгцэлүүдийг зөв залгаж бич. (Add the suffixes correctly.)

- |                         |                          |
|-------------------------|--------------------------|
| 1. холь + сон = .....   | 19. урь + я = .....      |
| 2. холь + оорой = ..... | 20. урь + лаа = .....    |
| 3. холь + г = .....     | 21. урь + даг = .....    |
| 4. холь + но = .....    | 22. урь + ж = .....      |
| 5. холь + моор = .....  | 23. урь + в = .....      |
| 6. холь + чих = .....   | 24. урь + аад = .....    |
| 7. холь + ё = .....     | 25. дахь + сан = .....   |
| 8. холь + лоо = .....   | 26. дахь + аарай = ..... |
| 9. холь + дог = .....   | 27. дахь + г = .....     |
| 10. холь + ж = .....    | 28. дахь + на = .....    |
| 11. холь + в = .....    | 29. дахь + маар = .....  |
| 12. холь + оод = .....  | 30. дахь + чих = .....   |
| 13. урь + сан = .....   | 31. дахь + я = .....     |
| 14. урь + аарай = ..... | 32. дахь + лаа = .....   |
| 15. урь + г = .....     | 33. дахь + даг = .....   |
| 16. урь + на = .....    | 34. дахь + ж = .....     |
| 17. урь + маар = .....  | 35. дахь + в = .....     |
| 18. урь + чих = .....   | 36. дахь + аад = .....   |

Линэ үгс: холь — mix, урь — invite, дахь — recur

## Дасгал 6

Доорх өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences below.)


### Хэрхэн цаг хэлэх (How to say time)

- |  |                  |
|--|------------------|
| — Хэдэн <u>цаг болж байна (вэ)?</u> → [tsagvoljiin] → [tsagoljiin] | What time is it? |
| — 10 цаг <u>болж байна.</u> → [boljiin]                            | It's 10 o'clock. |
| — Цаг <u>хэд болж байна (вэ)?</u> → [hedvoljiin] → [hedoljiin]     | What time is it? |
| — 10 болж байна.   | It's 10.         |

- |       |  |  |
|-------|--|--|
| 10:00 | 10 цаг болж байна.                       | Арав болж байна.                         |
| 10:15 | 10 цаг 15 минут болж байна.              | Арав, арван тав болж байна.              |
| 10:30 | 10 цаг 30 минут болж байна.              | Арав, гуч (хагас) болж байна.            |
| 10:45 | 10 цаг 45 минут болж байна.              | Арав, дөчин тав болж байна.              |
| 9:55  | 9 цаг 55 минут болж байна.               | Ес, тавин тав болж байна.                |
|       | <u>10 цагт 5 минут дутуу байна.</u>      | <u>Аравт тав дутуу байна.</u> (5 to 10.) |
| 10:05 | 10 цаг 5 минут болж байна.               | Арав, тав болж байна.                    |
|       | <u>10 (цаг)аас 5 минут өнгөрч байна.</u> | (5 minutes after 10 (o'clock.))          |

## Дасгал 7

Цаг хэд болж байгааг бич. (Write down what time it is.)



## Дасгал 8

Багш, оюутан хоёр загварын дагуу бие биенээсээ харилцан асууж, хариул. (Teacher and student, ask each other questions and answer them as in the examples.)

Оюутан: — Цаг хэд болж байна (вэ)?

Багш: — ..... болж байна.

Багш: — Цаг хэд болж байна (вэ)?

Оюутан: — ..... болж байна.

11:20.....

20:03.....

13:24.....

12:10.....

10:55.....

20:09.....

01:45.....

17:30.....

9:15.....

08:50.....

19:28.....

04:00.....

06:00.....

22:30.....

15:30.....

11:11.....

07:35.....

17:05.....

**Note:** 9 am → өглөөний 9 цаг, 9 pm → оройн 9 цаг

## Дасгал 9

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь: Та хэдэн цагт (хэдэд) ажил руугаа явдаг вэ? → Би 8 цагт (8-д) ажил руугаа явдаг.

1. Та хэдэн цагт (хэдэд) босдог вэ?
2. Та хэдэн цагт (хэдэд) өглөөний цайгаа уудаг вэ?
3. Та хэдэн цагт (хэдэд) өдрийн хоолоо иддэг вэ?
4. Та хэдэн цагт (хэдэд) оройн хоолоо иддэг вэ?
5. Таны ажил хэдэн цагт (хэдэд) эхэлдэг вэ?
6. Таны ажил хэдэн цагт (хэдэд) дуусдаг вэ?
7. Таны монгол хэлний хичээл хэдэн цагт (хэдэд) эхэлдэг вэ?
8. Таны монгол хэлний хичээл хэдэн цагт (хэдэд) дуусдаг вэ?
9. Та хэдэн цагт (хэдэд) унтдаг вэ?

# Арван долдугаар хичээл



## Байгаль, цаг агаар (Nature and weather)

|        |                    |               |                                 |
|--------|--------------------|---------------|---------------------------------|
| улирал | season             | цэцэг         | flower                          |
| өвөл   | winter             | жимс          | fruit                           |
| хавар  | spring             | солонго       | rainbow                         |
| зун    | summer             | цахилгаан     | lightening, electricity, zipper |
| намар  | fall               | хэм (градус)  | degree                          |
| агаар  | air                | салхитай      | windy                           |
| гол    | river              | нартай        | sunny                           |
| далай  | sea                | бороотой      | rainy                           |
| дэлхий | world              | цастай        | snowy                           |
| салхи  | wind               | нэмэх         | plus (to add)                   |
| сансар | space              | хасах         | minus (to subtract)             |
| од     | star               | (нар) мандах  | (sun) to rise                   |
| нар    | sun                | (нар) жаргах  | (sun) to set                    |
| сар    | moon               | (нар) гарах   | (sun) to rise                   |
| тэнгэр | sky                | (нар) орох    | (sun) to set                    |
| газар  | earth, land, place | бороо орох    | to rain                         |
| уул    | mountain           | цас орох      | to snow                         |
| үүл    | cloud              | (хавар) болох | (spring) to come                |
| мод    | tree, wood         | ургах         | to grow                         |

## Дасгал 1

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Монгол орон/танай орон хэдэн улиралтай вэ?
2. Улаанбаатар хотын агаар цэвэр үү, хөдөөний агаар цэвэр үү? Яагаад?
3. Улаанбаатар хотод хэдэн гол байдаг вэ? Танай хотод гол байдаг уу?
4. Та далай руу явах дуртай юу? Та далайн хоол идэх дуртай юу?
5. Монголд/танай оронд хэзээ их салхитай байдаг вэ?
6. Улаанбаатар/танай хотод дандаа нартай байдаг уу?
7. Монгол/Солонгос/Америк том газартай юу?
8. Монгол/Америк/Солонгос олон өндөр уултай юу?
9. Монголд/танай оронд хэзээ их бороо ордог вэ?
10. Монголд/танай оронд хэзээ их цас ордог вэ?
11. Монголд/Солонгост/Америкт өвөл хэдэн градус хүйтэн байдаг вэ?
12. Монголд/Солонгост/Америкт зун хэдэн градус дулаан байдаг вэ?

Шинэ үгс: орон — country, хот — city


## Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Өнөөдөр гадаа ямар байна (вэ)?
2. Өчигдөр гадаа ямар байсан бэ?
3. Монголд/танай оронд өвөл цаг агаар ямар байдаг вэ?
4. Монголд/танай оронд хавар цаг агаар ямар байдаг вэ?
5. Монголд/танай оронд зун цаг агаар ямар байдаг вэ?
6. Монголд/танай оронд намар цаг агаар ямар байдаг вэ?

## Дасгал 3

Зургуудыг хараад улирал, цаг агаарын талаар багштайгаа ярилц. (Look at the picture and talk with your teacher about the season and weather.)



## Дасгал 4

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Энэ ямар улирал вэ?
  - А. Гадаа нартай, халуун, жаахан салхитай байна.
  - Б. Гадаа их салхитай, жаахан цастай, хүйтэн байна.
  - В. Гадаа их хүйтэн, наргүй, цастай байна.
  - Г. Гадаа бороотой, халуун байна.

- Д. Гадаа хасах 25 хэм, нартай байна.  
 Е. Гадаа нэмэх 10 хэм, их салхитай байна.  
 Ё. Гадаа дулаан, тэнгэрт солонго байна.  
 Ж. Гадаа мод ногоон байна. Бас олон цэцэг байна.
2. Энэ ямар улирал вэ?
- А. Их бороо ордог.  
 Б. Их цас ордог.  
 В. Бороо ордоггүй.  
 Г. Цас ордоггүй.  
 Д. Бороо, цас хамт ордог.

- Е. Нар өглөө 6 цагт манддаг.  
 Ё. Нар өглөө 8 цагт манддаг.  
 Ж. Нар орой 5 цагт жаргадаг.  
 З. Нар орой 9:30-д жаргадаг.  
 И. Жимс ургадаг.

## Хоол хүнс (Foods)

|                  |                         |              |                     |
|------------------|-------------------------|--------------|---------------------|
| <b>хоол</b>      | <b>food</b>             | байцаа       | cabbage             |
| шөл              | soup                    | манжин       | turnip              |
| бууз             | buuz                    | улаан лооль  | tomato              |
| хуушуур          | huushuur                |              |                     |
| банш             | dumpling                | <b>жимс</b>  | <b>fruit</b>        |
| цуйван           | noodles+meat+vegetables | алим         | apple               |
|                  |                         | гадил        | banana              |
| өглөөний цай     | breakfast               | хан боргоцой | pineapple           |
| өдрийн хоол      | lunch                   | жүрж         | orange              |
| оройн хоол       | dinner                  | интоор       | cherry              |
|                  |                         | тоор         | peach               |
| <b>мах</b>       | <b>meat</b>             | киви         | kiwi                |
| үхрийн мах       | beef                    | нимбэг       | lemon               |
| хонины мах       | mutton                  | үзэм         | raisin              |
| тахяаны мах      | chicken                 | усан үзэм    | grape               |
| гахайн мах       | pork                    | тарвас       | watermelon          |
| ямааны мах       | goat meat               | гүзээлзгэнэ  | strawberry          |
| хиам             | sausage                 |              |                     |
|                  |                         | <b>бусад</b> | <b>other things</b> |
| <b>уух зүйлс</b> | <b>things to drink</b>  | цагаан будаа | rice                |
| ус               | water                   | гурил        | flour               |
| кофе             | coffee                  | зайрмаг      | ice cream           |
| ундаа            | soft drink              | өндөг        | egg                 |
| сүү              | milk                    | гоймон       | noodles             |
| цай              | tea                     | бяслэг       | cheese              |
| сүүтэй цай       | milk tea                | элсэн чихэр  | sugar               |
| шүүс             | juice                   | чихэр        | candy               |
| тараг            | yoghurt                 | ёотон        | lump sugar          |
|                  |                         | давс         | salt                |
| <b>ногоо</b>     | <b>vegetables</b>       | талх         | bread               |
| төмс             | potato                  | бялуу        | cake                |
| сармис           | garlic                  | тос          | oil                 |
| лууван           | carrot                  |              |                     |
| сонгино          | onion                   |              |                     |

# Арван наймдугаар хичээл



## Захирах хүсэх төлөв (2-р бие) (Imperative mood (for second person))

Verb stems are used as a command for second person and **-аар<sup>4</sup>ай<sup>3</sup>** is used for please.

For example:

Яв.                      Go.                      Суу.                      Sit.  
Яваарай.        Please go.              Суугаарай.        Please sit.

"Битгий" (don't) is used in everyday speech.

**Битгий** яв.                      **Don't** go.  
Битгий яваарай.              Please don't go.

"Бүү" (don't) is used in formal speech.

Тамхи **бүү** тат!              **Don't** smoke! (No smoking!)  
Хог бүү хая!                      Don't throw garbage!  
Шилэнд бүү хүр!                Don't touch the glass!

### Spelling rules:

|   | After verb stems ending with consonant or short vowels | After verb stems ending with long vowels or diphthongs |
|---|--|--|
| Verb stems with <b>а</b> or <b>у</b>    | -аарай   | -(г)аарай  |
| Verb stems with <b>э, ү</b> or <b>и</b> | -ээрэй   | -(г)ээрэй  |
| Verb stems with <b>о</b>                | -оорой   | -(г)оорой  |
| Verb stems with <b>ө</b>                | -өөрэй   | -(г)өөрэй  |

For example: яваарай, уугаарай, хэлээрэй, ороорой, өгөөрэй.

### Note:

If the last letters of a stem are **cvc**, the vowel in between the two consonants is dropped when we add this suffix. For example: амар + аарай = амраарай, эхэл + ээрэй = эхлээрэй.

If a verb stem ends with a short vowel, the short vowel is dropped when we add -аар<sup>4</sup>ай<sup>3</sup>.

For example: ажилла + аарай = ажиллаарай, тогло + оорой = тоглоорой.

If a verb stem ends with a soft sign, the soft sign become **и** and one of the long vowels in the suffix is dropped when we add -аар<sup>4</sup>ай<sup>3</sup>. For example: барь + аарай = бариарай, боль + оорой = болиорой.

## Дасгал 1

Үйл үгийн үндсэн дээр -аар<sup>4</sup> ай<sup>3</sup> нөхцөлийг залгаж, өгүүлбэр зохио. (Add the suffix -аар<sup>4</sup> ай<sup>3</sup> to the verb stems and make sentences.)

- |           |         |           |          |
|-----------|---------|-----------|----------|
| 1. гар    | 6. уулз | 11. гүй   | 16. хэл  |
| 2. нээ    | 7. хий  | 12. амар  | 17. шар  |
| 3. хаа    | 8. үз   | 13. өг    | 18. чана |
| 4. дуусга | 9. бод  | 14. тогло | 19. тоол |
| 5. сур    | 10. яв  | 15. ярь   | 20. тат  |

Шинэ үгс: гарах — to go out, бодох — to think, хэлэх — to say/to tell, шарах — to fry, чанах — to boil, тоолох — to count, татах — to pull

## Дасгал 2

Өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохио. (Make sentences with the given words.)

Жишээ нь: хийх, идэх → Эхлээд хичээлээ хийгээрэй (Дараа нь) хоолоо идээрэй.  
(Please do your lesson first, then eat your food.)

- |                    |                      |
|--------------------|----------------------|
| 1. идэх, ажиллах   | 11. дуулах, бүжиглэх |
| 2. амрах, ажиллах  | 12. зурах, өгөх      |
| 3. хийх, тоглох    | 13. мэндлэх, асуух   |
| 4. цэвэрлэх, унтах | 14. мэндлэх, суух    |
| 5. явах, амрах     | 15. тоолох, өгөх     |
| 6. асуух, бичих    | 16. тоолох, хэлэх    |
| 7. сурах, ярих     | 17. тоолох, чанах    |
| 8. бодох, хэлэх    | 18. ажиллах, авах    |
| 9. бодох, хийх     | 19. цэвэрлэх, шарах  |
| 10. бодох, ярих    | 20. чанах, шарах     |

## Дасгал 3

Хориглон чимэх үг "бүтгий" -г ашиглан доорх байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the word "бүтгий.")

- |                                 |  |
|---------------------------------|--|
| 1. Би дандаа муухай үг хэлдэг.  | 6. Би дулаан цамцгүй гадаа гарна.          |
| 2. Би найзаасаа их мөнгө авдаг. | 7. Би дандаа амардаг.                      |
| 3. Би өдөрт 6 аяга кофе уудаг.  | 8. Би түүний нэрийг <sup>24</sup> мартдаг. |
| 4. Би тамхи татдаг.             | 9. Би орой 10 цагт их хоол иддэг.          |
| 5. Би их санаа зовдог.          | 10. Би ер нь их олон цаг ажилладаг.        |

Шинэ үгс: мөнгө — money, тамхи татах — to smoke, санаа зовох — to worry

<sup>24</sup> The suffixes -ийг, -ыг and -r are used for specific direct object. For example: Би тэр хоолыг хийсэн. (I cooked that food.) (If you want to know more, please see Lesson 41.)

## Дасгал 4

Өгүүлдэрийг орчуул. (Translate the sentences.)

- |                                   |  |
|-----------------------------------|--|
| 1. Don't go outside. Stay home.   | 9. Don't be there for many hours.      |
| 2. Don't smoke.                   | 10. Do your lesson now! Don't play.    |
| 3. Please cook tonight.           | 11. Don't work many hours. Rest now.   |
| 4. Don't work. Please rest now.   | 12. Don't eat bad food. Eat good food. |
| 5. Please don't buy food!         | 13. Ask many questions. Don't worry.   |
| 6. Do house work. Don't just sit. | 14. Don't sit here! Please sit there!  |
| 7. Don't go to the countryside.   | 15. Please work now, then rest.        |
| 8. Don't meet that bad person.    | 16. Please don't play outside.         |

## Дасгал 5

Үзсэн хэлзүйгээ ашиглан, өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирох зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the grammar you have just learned.)

1. Би хөдөө явна.
2. Би ирэх сард Африк руу явна. Тэнд хоёр жил амьдарна.
3. Би шинэ машин авна.
4. Би ирэх сараас монгол хэл сурна.
5. Би монгол хоол хийнэ.
6. Би Улаанбаатарт машин барина.
7. Би монгол гэрт амьдарна.
8. Би дэлгүүрээс юм авна.
9. Би ажил хийхгүй.
10. Би хүмүүстэй уулзахгүй.

# Арван есдүгээр хичээл



## Холбоос үгс (Conjunctions)

|                  |                            |
|------------------|----------------------------|
| Яагаад гэвэл ... | Because ...                |
| Тийм учраас ...  | That's why ...             |
| ... учраас ...   | Because .../That's why ... |

Би монгол хэл сурах хэрэгтэй. **Яагаад гэвэл** би Монголд амьдардаг.  
I need to learn Mongolian **because** I live in Mongolia.

Би Монголд амьдардаг. **Тийм учраас** монгол хэл сурах хэрэгтэй.  
I live in Mongolia. **That's why** I need to learn Mongolian.

Би Монголд амьдардаг **учраас** монгол хэл сурах хэрэгтэй.  
I live in Mongolia, **that's why** I need to learn Mongolian.

## Дасгал 1

Эзэгдсэн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

- \* Шээ нь: Тэр хүйтэн ус уух, тэр их халууцах  
Тэр хүйтэн ус уусан. Яагаад гэвэл тэр их халууцсан.  
Тэр их халууцсан. Тийм учраас хүйтэн ус уусан.  
Тэр их халууцсан учраас хүйтэн ус уусан.

1. Та, их хэцүү, ажил, хийх; та, их ядрах
2. Хүүхдүүд, гадаа, тоглох(гүй); гадаа, их, бороо орох
3. Гадаа, их хүйтэн, байх; би, гэр, байх
4. Миний найз, өвдөх; тэр, муу хоол, идэх
5. Би, завгүй, байх; би, хичээл, хийх(гүй)
6. Жаргалмаа, олон цаг, хичээл хийх; тэр, хэл, сайн, сурах
7. Тэр эрэгтэй, дандаа, архи уух; эхнэр, санаа зовох
8. Тэр, цөөн цаг, ажиллах; бага мөнгө, авах
9. Манай найз, шинэ цүнх, авах; тэр, их, баяртай байх
10. Хүүхэд, хоол, идэх(гүй); хүүхэд, өвдөх
11. Тэр, монгол, сайн ярих; тэр, олон жил, монгол хэл, сурах
12. Баярхүү, олон найзтай; тэр, сайн хүн
13. Хүмүүс, сайн хоол, идэх хэрэгтэй; хүмүүс, эрүүл, байх хэрэгтэй
14. Гадаа, халуун, байх; би, их, халууцах
15. Тэр, хичээл, ирэх(гүй); тэр, сонирхолтой юм, сурах(гүй)

Цөмн үгс: халууцах — to feel hot, ядрах — to be tired, завгүй — busy, өвдөх — to be sick, эрүүл — healthy

## Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та өчигдөр ядарсан уу? Яагаад?
2. Та өнгөрсөн жил өвдсөн үү? Яагаад?
3. Та яагаад Монголд ирсэн бэ?
4. Монголд ямар байна вэ? Яагаад?
5. Монгол хүмүүс хатуу хүмүүс үү? Яагаад?
6. Америк хүмүүс цөөн хүүхэдтэй юү? Яагаад?
7. Америкт хуучин юм (машин, хувцас) зардаг уу? Яагаад?
8. Америк хүмүүс хуучин юм авдаг уу? Яагаад?
9. Туранхай хүн амархан өвддөг үү? Яагаад?
10. Та ер нь завгүй байдаг уу? Яагаад?
11. Гэрийн даалгавар хэцүү байсан уу? Яагаад?

Шинэ үгс: хатуу — hard / зарах — to sell

## Дасгал 3

Доорх зургууд дээр үзсэн холбоос үгсээ ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences about the pictures below using the conjunctions you have learned.)



## Дасгал 4

Доорх нөхцөл байдлуудад өөрийн бодлоо илэрхийлж бич. (Write an expression for each situation below.)

Жишээ нь: Том нохой байна. (There is a big dog.) → Ямар том нохой вэ? (What a big dog.)

- |                           |                                   |
|---------------------------|-----------------------------------|
| 1. Их гоё цүнх байна.     | 10. Их сайн хүн байна.            |
| 2. Их гоё хувцас байна.   | 11. Тарган хонь байна.            |
| 3. Их гоё пицца байна.    | 12. Их туранхай морь байна.       |
| 4. Их амттай пицца байна. | 13. Их муу хүүхэд байна.          |
| 5. Их том өрөө байна.     | 14. Их хуучин байр байна.         |
| 6. Их завгүй хүн байна.   | 15. Дэлгүүрт их хатуу талх байна. |
| 7. Их үнэтэй цаг байна.   | 16. Их өөхтэй хоол байна.         |
| 8. Их хүйтэн өрөө байна.  | 17. Хөөрхөн хүүхэд байна.         |
| 9. Халуун цай байна.      | 18. Өндөр байшин байна.           |

Линэ үгс (тарган — fat (adjective), туранхай — thin, өөх — fat (noun), хөөрхөн — cute, өндөр — tall)

## Дасгал 5

Нөхцөл байдлуудад тохируулан нэр үгийн оронд "юм" гэдэг үгийг ашиглан өгүүлбэр зохио. (Replace nouns with the word "юм" and make sentences.)

Жишээлбэл: Гэрт их халуун байна. (It's very hot in the house.) → Ямар халуун юм бэ? (How hot is it (here)?)

- |                         |                                |
|-------------------------|--------------------------------|
| 1. Ажил хэцүү байна.    | 9. Сайхан үнэртэй цэцэг байна. |
| 2. Тарган нохой байна.  | 10. Амттай хоол байна.         |
| 3. Туранхай морь байна. | 11. Олон ном байна.            |
| 4. Хатуу мах байна.     | 12. Халуун цай байна.          |
| 5. Бага хоол байна.     | 13. Хүйтэн ус байна.           |
| 6. Гоё цүнх байна.      | 14. Үнэтэй цүнх байна.         |
| 7. Жижиг машин байна.   | 15. Хямд цамц байна.           |
| 8. Сайхан байр байна.   | 16. Сонирхолтой ном байна.     |

# Хорьдугаар хичээл



## Одоо үргэлжлэх цаг (Present continuous tense)

|                        |   |
|------------------------|---|
| Verb stem + ж/-ч байна | am/is/are ...-ing (Action is being seen or heard) |
| байгаа                 | am/is/are ...-ing (Action is not being seen)      |
| байдаг                 | am/is/are ...-ing (Action is always happening)    |

For example:

Тэр дуулж байна. (He is singing. (You see or hear him singing.))

Тэр дуулж байгаа. (He is singing. (You don't see. (He has been singing.))

Тэр дуулж байдаг. (He is (always) singing.)

## Өнгөрөн үргэлжлэх цаг (Past continuous tense)

Verb stem + ж/-ч байсан was/were ...-ing

For example: Тэр дуулж байсан. (He was singing.)

Spelling rules:

|                           | After verb stems ending with vowels or soft sign | After verb stems ending with г, с, (в) or (р) | After verb stems ending with ц, з, д, т or х | After verb stems ending with ш, ч or ж | After verb stems ending with consonants л, м, (в) or (р) |
9. He trusts his friends. His many friends trust him.
10. Ten students are learning Mongolian now. Students need to study many hours.

## Дасгал 5

Бичгийн хэрэгслүүдийн нэрийг цээжилж, зургуудыг харж, юу юу байгааг нэрлэ. (Memorize the stationery vocabulary, then look at the pictures and tell what things are there.)


### Бичгийн хэрэгсэл (Stationery items)

үзэг  
бал  
харандаа  
баллуур  
цэрд/шохой  
дэвтэр  
самбар  
тооны машин

pen  
ballpoint pen  
pencil  
eraser  
chalk  
notebook  
chalkboard  
calculator


шугам  
цүнх  
хайч  
ширээ  
сандал  
цаас  
бичгийн хавчаар  
үдээсний машин

ruler  
purse  
scissors  
table  
chair  
paper  
paperclip  
stapler



## Дасгал 6


Ангид болон багш, оюутнуудын ширээн дээр юу юу байж болохыг олон тооны нөхцөл ашиглан хэл. (Using the plural suffixes, tell about what things can be found in a classroom and on the teacher's and students' tables.)



# Давтлага хичээл

## Дасгал 1

Хаана хэн, юу байгааг хэл. (Tell about where things and children are using the dative locative case.)



## Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Их дэлгүүр хаана байдаг вэ?
2. Цирк хаана байдаг вэ?
3. "Kempinski" зочид буудал хаана байдаг вэ?
4. Сүхбаатарын талбайн хойно юу юу байдаг вэ?
5. Танай гэрийн баруун/зүүн талд юу юу байдаг вэ?
6. "Линго Лаб" төвийн эргэн тойронд юу юу байдаг вэ?

## Дасгал 3

Өгөгдсөн үгс өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр хувиргаж, үг тус бүрийг оролцуулан өгүүлбэр зохио. (Add the dative locative case to the words and make sentences with each word.)

- |         |             |              |            |
|---------|-------------|--------------|------------|
| 1. багш | 5. нохой    | 9. та        | 13. бид    |
| 2. аав  | 6. би       | 10. сургууль | 14. сурагч |
| 3. найз | 7. хүүхдүүд | 11. чи       | 15. хашаа  |
| 4. тэр  | 8. анги     | 12. гэр      | 16. тэд    |

## Дасгал 4

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Та хэн хэнд итгэдэг вэ? Яагаад?
2. Та одоо хэн хэнд тусалмаар байна вэ? Яагаад?
3. Та хүмүүст хичээл заадаг уу?
4. Та хэн хэнд бэлэг өгдөг вэ?
5. Та хэн хэнд юу юу гэж хэлдэг вэ?
6. Та хэдэн оны хэдэн сарын хэдэнд төрсөн бэ?
7. Та хэдэн оны хэдэн сарын хэдэнд сургуулиа төгссөн бэ?
8. Та юунд дуртай вэ?
9. Та хэн хэнд хайртай вэ?

## Дасгал 5

Хүснэгтийг бөглөж, үг бүр дээр өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences with each word.)

| ХЭН      | ХЭНИЙ<br>(-ын <sup>2</sup> хаа <sup>4</sup> ) | ХЭНТЭЙ<br>(-тай <sup>3</sup> гаа <sup>4</sup> ) | ХЭНД<br>(-даа <sup>4</sup> /-таа <sup>4</sup> ) |
|----------|---|---|---|
| багш     |   |   |   |
| эмч      |   |   |   |
| найз     |   |   |   |
| өвөө     |   |   |   |
| эцэг эх  |   |   |   |
| хамаатан |   |   |   |
| та       |   |   |   |

**Note:** In the Mongolian language, the possessive suffix -aa<sup>4</sup> can be used with personal pronouns to mean closeness. For example: Би чамдаа хайртай, I love you (who is my dear).

## Дасгал 6

Доорх үгст олон тооны нөхцөл залгаж бич. (Add plural suffixes to the words below.)

- |            |            |              |             |
|------------|------------|--------------|-------------|
| 1. хүүхэд  | 7. том     | 13. шугам    | 19. нэр     |
| 2. монгол  | 8. эхнэр   | 14. эгч      | 20. үг      |
| 3. ном     | 9. багш    | 15. эмч      | 21. та      |
| 4. эцэг эх | 10. дуучин | 16. солонгос | 22. дарга   |
| 5. ах дүү  | 11. малчин | 17. харандаа | 23. эмэгтэй |
| 6. машин   | 12. найз   | 18. бал      | 24. хүн     |

# Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.

(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Би найзандаа тусалсан.  
Б. Би найзаад тусалсан.  
В. Би найздаа тусалсан.
2. I will give flowers to your mother.  
А. Би танай ээжид цэцэг өгнө.  
Б. Би танай ээжэд цэцэг өгнө.  
В. Би танай ээжд цэцэг өгнө.
3. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Тэр Оросод амьдардаг.  
Б. Тэр Орост амьдардаг.  
В. Тэр Оросонд амьдардаг.
4. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Тэд маханд дуртай.  
Б. Тэд махад дуртай.  
В. Тэд мах дуртай.
5. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Монголчууд бууз дуртай.  
Б. Монголчууд буузанд идэх дуртай.  
В. Монголчууд бууз идэх дуртай.
6. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Галхүү ээжээ хайртай.  
Б. Галхүү ээждээ хайртай.  
В. Галхүү түүний ээж хайртай.
7. I was in Erdenet in June.  
А. Би Эрдэнэтэд 6 сар байсан.  
Б. Би Эрдэнэтэд 6 сарын байсан.  
В. Би Эрдэнэтэд 6 сард байсан.
8. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Тэр охин 2005 онд төрсөн.  
Б. Тэр охин 2005 онт төрсөн.  
В. Тэр охин 2005 он төрсөн.
9. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Япон нар хар үстэй.  
Б. Япончууд нар үстэй.  
В. Японс нар үстэй.
10. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Багшууд ирж байна.  
Б. Багшчууд ирж байна.  
В. Багш нар ирж байна.
11. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Дэлгүүрүүд одоо хаасан.  
Б. Дэлгүүр нар одоо хаасан.  
В. Дэлгүүрчүүд одоо хаасан.
12. The child is standing on the fence.  
А. Хүүхэд хашааны дээр зогсож байна.  
Б. Хүүхэд хашаа дээр зогсож байна.  
В. Хүүхэд хашаан дээр зогсож байна.
13. Аль нь зөв бэ? Which one is right?  
А. Манай гэрийн хажууд мод байдаг.  
Б. Манай гэр хажууд мод байдаг.  
В. Манай гэрэн хажууд мод байдаг.
14. People are in front of the store.  
А. Хүмүүс дэлгүүрийн ард байна.  
Б. Хүмүүс дэлгүүрийн наана байна.  
В. Хүмүүс дэлгүүрийн урд байна.
15. What is in my hand? (Guess.)  
А. Миний гарт юу байдаг вэ?  
Б. Миний гарт юу байна вэ?  
В. Миний гарт юу байгаа вэ?
16. Wow, this is a pretty shirt.  
А. Хөөх, энэ гоё цамц байна.  
Б. Хөөх, энэ гоё цамц байдаг.  
В. Хөөх, энэ гоё цамц байгаа.

Оноо (point): 16/.....

# Хорин зургадугаар хичээл



## Хүний бие, эрүүл мэнд (People's body and health)

|              |           |               |                            |
|--------------|-----------|---------------|----------------------------|
| бие          | body      | гэдэс         | stomach                    |
| толгой       | head      | нуруу         | back                       |
| нүүр         | face      | эмнэлэг       | hospital                   |
| ам           | mouth     | өвдөх         | to be sick, to have a pain |
| хамар        | nose      | эмч           | doctor                     |
| шүд          | teeth     | эмчид үзүүлэх | to go to see a doctor      |
| нүд          | eye       | эм уух        | to take medicine           |
| чих          | ear       | халуурах      | to have a fever            |
| гар          | hand, arm | ханиах        | to cough                   |
| хөл          | leg, feet | ханиад хүрэх  | to catch cold              |
| хуруу        | finger    | эмчлэх        | to treat                   |
| хөлийн хуруу | toes      | эдгэх         | to be healed               |
| үс           | hair      | үхэх          | to die                     |
| хэл          | tongue    | нас барах     | to die (for people)        |

### Дасгал 1

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Та жил бүр эмчид үзүүлдэг үү?
2. Та их эм уудаг уу?
3. Таны бие (толгой, шүд, нүд, хөл, гар, гэдэс, нуруу) өвддөг үү?
4. Шүдний эмнэлэг хаана хаана байдаг вэ?
5. Америк хүмүүс урт үстэй юү? Та үсчин явдаг уу?
6. Ази (европ) хүмүүс том нүдтэй юү, жижиг нүдтэй юү?
7. Хүн яагаад нэг ам, хоёр чихтэй байдаг вэ?
8. Шүдэнд (нүдэнд, биенд) юу юу сайн бэ?
9. Шүдэнд (нүдэнд, биенд) юу юу муу вэ?

### Дасгал 2

Доорх нөхцөл байдлуудад юу өвдөж болохыг бич. (Write about what sicknesses can be caused in the situations below.)

1. Би муу хоол иднэ.
2. Би гадаа, дулаан хувцасгүй тоглоно.
3. Би компьютер тоглоом тоглоно.
4. Би олон цаг гар бөмбөг тоглоно.
5. Би олон цаг хичээлээ хийнэ.
6. Би хоолгүй олон цаг ажиллана.
7. Би суухгүй, олон цаг зогсоно.
8. Би ярих их дуртай. Их ярина.
9. Би ус уухгүй.
10. Би амралгүй их ажил хийнэ.

### Дасгал 3


Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation.)

Жишээ нь: Миний чих өвдөж байна. → Эмчид үзүүлээрэй.

1. Миний толгой өвдөж байна.
2. Миний гэдэс өвдөж байна.
3. Би халуурч байна.
4. Миний нуруу өвдөж байна.
5. Миний бие олон хоног өвдөж байна.
6. Би гадаа олон цаг тоглосон. Тэгээд ханиад хүрсэн.
7. Би их чихэр идсэн. Тэгээд одоо миний шүд өвдөж байна.
8. Би их ажил хийсэн. Тэгээд одоо миний гар өвдөж байна.
9. Би олон цаг суугаагүй. Тэгээд миний хөл өвдөж байна.

### Дасгал 4

Доорх зургуудыг хараад тэдэнд юу юу тохиолдсоныг бич. (Look at the pictures below and write what happened to the people.)





## Хичээлд хэрэглэгддэг үгс (Words that are used in a lesson)

|            |               |                  |                    |
|------------|---------------|------------------|--------------------|
| үсэг       | letter        | сурах            | to study, to learn |
| үг         | word          | асуулт           | question           |
| эгшиг      | vowel         | асуух            | to ask             |
| гийгүүлэгч | consonant     | хариулт          | answer             |
| өгүүлбэр   | sentence      | хариулах         | to answer          |
| үйл үг     | verb          | давтлага         | review             |
| нэр үг     | noun          | давтах           | to review          |
| тэмдэг нэр | adjective     | жишээ            | example            |
| хэлзүй     | grammar       | асуултын тэмдэг  | question mark      |
| дуудлага   | pronunciation | анхаарлын тэмдэг | exclamation mark   |
| тоо        | number        | цэг              | full stop          |
| олон тоо   | plural        | таслал           | comma              |
| дасгал     | exercise      | хаалт            | parenthesis        |
| хичээл     | lesson        | шалгалт          | exam               |
| завсарлага | break         | шалгалт өгөх     | to take an exam    |
| заах       | to teach      | шалгалт авах     | to give an exam    |

### Хичээл дээр

- Багш аа, (надад) нэг асуулт байна.
- Танаас юм асуух гэсэн юм. [asuuhgsii]
- "Chair"-ийг монголоор юу гэдэг юм бэ? [yugdii]
- "Chair"-ийг монголоор "сандал" гэдэг.
- "Сүх" гэж юу гэсэн үг юм бэ? [yugsügi]
- "Сүх" гэж "ах" гэсэн үг.
- Зүрх, сэтгэл гэдэг хоёр үг ямар ялгаатай юм бэ? [yalgaataiii]
- "Зүрх" гэдэг үгийг яаж бичдэг юм бэ? [bichdii]

### At the lesson

- Teacher, I have one question.
- I would like to ask you something.
- How do you say "chair" in Mongolian?
- Chair is called сандал in Mongolian.
- What does "сүх" mean?
- Сүх means ах.
- What is the difference between зүрх and сэтгэл?  
("Зүрх" is physical heart and "сэтгэл" is emotional heart.)
- How do you spell "зүрх"?

# Хорин долдугаар хичээл



## Баймж үг (хэрэгтэй, хэрэггүй (need, don't need))

When verbs are used with хэрэгтэй/хэрэггүй, we don't need to add any suffixes to subjects.

For example:

Хүмүүс хоол **идэх хэрэгтэй**. (People **need to eat** food.)

Би үнэтэй машин **авах хэрэггүй**. (I **don't need to buy** an expensive car.)

But when verbs are not used with хэрэгтэй/хэрэггүй, we need to add the dative locative case to subjects. For example:

Хүмүүст хоол хэрэгтэй. (People need food.)

Надад үнэтэй машин хэрэггүй. (I don't need an expensive car.)

## Дасгал 1

Өгүүлбэр бүрийг үйл үггүй болгон бичиж, асуулт зохио. (Write each sentence without verbs and make questions out of them.)

Жишээ нь: Би машин авах хэрэгтэй. → Надад машин хэрэгтэй. → Танд машин хэрэгтэй юү?

1. Баярхүү ном унших хэрэгтэй.
2. Хүмүүс хоол идэх хэрэгтэй.
3. Би тоглоом тоглох хэрэггүй.
4. Чи ус уух хэрэгтэй.
5. Та монгол хэл сурах хэрэгтэй.
6. Мөнхмаа хөдөө амрах хэрэгтэй.
7. Бид сайн найз байх хэрэгтэй.
8. Тэд хөгжим сурах хэрэгтэй.
9. Та багштай уулзах хэрэгтэй.
10. Багш шинэ дэвтэр авах хэрэггүй.
11. Алтмаа дасгал хийх хэрэггүй.
12. Би машин барих хэрэгтэй.

## Дасгал 2

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Children need to live with their parents. Children need parents.
2. Children need to live in a warm house. They need a warm house.
3. Parents need to love their children. Children need love.
4. I need to learn Mongolian very well. I need Mongolian.
5. We need to eat good food. We need good food.
6. I don't need to go to the store tomorrow. I don't need meat tomorrow.
7. People need to do work. People need work.
8. What do children need to do? What do children need?
9. What do men need to do? What do men need?
10. What do women need to do? What do women need?
11. What do you need to do? What do you need?

### Дасгал 3

Шинэ үгсийг цээжилж, доорх асуултад хариул. (Memorize new words and answer the questions below.)


|              |                              |            |                 |
|--------------|------------------------------|------------|-----------------|
| хайрцаг      | box                          | сав        | container       |
| (гялгар) уут | (plastic) bag without handle | аяга       | cup             |
| тор          | bag with handle              | халаас     | pocket          |
| цүнх         | purse                        | түрийвч    | wallet          |
| хөргөгч      | refrigerator                 | шүүгээ     | cupboard/closet |
| дугтуй       | envelope                     | -д/-т хийх | to put in       |

Жишээ нь: Та юунд дэвтрээ хийдэг вэ? → Би цүнхэндээ дэвтрээ хийдэг.

1. Та юунд номоо хийдэг(гүй) вэ?
2. Та юунд хоол хийдэг вэ?
3. Та юунд мөнгөө хийдэг(гүй) вэ?
4. Та юунд мах хийдэг(гүй) вэ?
5. Та юунд хувцсаа хийдэг вэ?
6. Та хайрцагт юу юу хийдэг вэ?
7. Та торонд юу юу хийдэг вэ?
8. Та цүнхэндээ юу юу хийдэг вэ?
9. Та хөргөгчинд юу хийдэг(гүй) вэ?
10. Та саванд юу юу хийдэг(гүй) вэ?
11. Та халаасандаа юу хийдэг(гүй) вэ?
12. Та түрийвчиндээ юу хийдэг вэ?

### Дасгал 4

Доорх зүйлсийг нэрлэж, дотор нь юу юу хийж болохыг бич. (Tell the names of the objects below and write what things can be put in them.)



### Дасгал 5

Доорх нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation below.)

Жишээ нь: Би мөнгөө оймсондоо хийдэг. → Мөнгөө оймсондоо битгий хий. Түрийвчиндээ хий.

1. Би гутлаа цүнхэндээ хийдэг.
2. Би мөнгөө торонд хийдэг.
3. Би хоолоо хайрцаганд хийдэг.
4. Би захиагаа гялгар уутанд хийдэг.
5. Би номоо саванд хийдэг.
6. Би балаа амандаа хийдэг.
7. Би гар утсаа аяганд хийдэг.
8. Би нохойгоо шүүгээнд хийдэг.
9. Би муураа уутанд хийдэг.
10. Би үзгээ хөргөгчинд хийдэг.
11. Би цагаа усанд хийдэг.
12. Би цагаа халаасандаа хийдэг.

# Хорин наймдугаар хичээл



## Байх (To have)

S-д/-т ... байна. (байгаа = бий, байдаг, байсан)

S+д/-т ... байхгүй.

Надад үзэг байна.

I have a pen.

Надад үзэг байхгүй.

I don't have a pen.

-адад үзэг байгаа/бий.

I have a pen.

Надад үзэг байдаггүй.

I don't have a pen.

-адад үзэг байсан.

I had a pen.

Надад үзэг байгаагүй.

I didn't have a pen.

|                     | To have things | To have (people) |
|---------------------|----------------|------------------|
| -тай <sup>3</sup>   | √              | √                |
| S+д/-т ..... байна. | √              |                  |

## Дасгал 1

Эзүүлэгдэхүүнүүдийг өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр хувиргаж бич. (Add the dative locative case to the subjects.)

• Ишээ нь: Цэцэгмаа..... олон тоглоом байгаа. → Цэцэгмаад олон тоглоом байгаа.

1. Баярхүү..... ном байна.
2. Аав..... мөнгө байгаа.
3. (Би) ..... асуулт байна.
4. Бид..... том цүнх байсан.
5. Тэд..... тоглоом байгаа.
6. Та нар..... цэцэг бий юу?
7. Хүүхдүүд..... тэр ном байгаа.
8. Багш..... бичгийн цаас бий.
9. Ээж..... шинэ үзэг байсан.
10. Та..... хар бал байна уу?
11. (Тэр) ..... жижиг дэвтэр байдаг.
12. Тэр оюутан..... тооны машин байна.

## Дасгал 2

Эгэгдсэн үгсийг ашиглан асуулт зохиож, хариул. (Make questions using the given words and answer them.)

• Ишээ нь: Та, бичих юм, байх → Танд бичих юм байгаа юу/бий юу? (Do you have something to write with?)  
Надад бичих юм байхгүй. (I don't have anything to write with.)

1. Та, идэх юм, байх?
2. Та, идэх хоол, байх?
3. Чи, хэлэх юм, байх?
4. Тэр, уух юм, байх?
5. Та, асуух асуулт, байх?
6. Тэр, уух ус, байх?
7. Тэд, орчуулах текст, байх?
8. Чи, унших ном, байх?
9. Чи, хэрэглэх цаас, байх?
10. Чи, бичих үзэг, байх?

Эинэ үгс: орчуулах — to translate, хэрэглэх — to use



## ... -сан<sup>4</sup>д баярлалаа (Thank you for ...-ing)

Манайд ирсэнд баярлалаа.

Надад тусалсанд баярлалаа.

Гэр бүлийн минь талаар асуусанд баярлалаа.

Надад тэр тухай сануулсанд баярлалаа.

Надад энэ талаар урьдчилж хэлсэнд баярлалаа.

Утсаар ярьсанд баярлалаа.

Thank you for coming to my house.

Thank you for helping me.

Thank you for asking about my family.

Thank you for reminding me about that.

Thank you for telling me about this in advance.

Thank you for calling.

### Дасгал 3

Өгөгдсөн нөхцөл байдалд тохируулан талархлаа илэрхийл. (Express thankfulness for each situation.)

Жишээ нь: Найз тань танай гэрт ирсэн. → Ирсэнд баярлалаа. (Thank you for coming.)

1. Найз тань танд бэлэг өгсөн.
2. Найз тань тантай хамт зах явсан.
3. Найз тань тан руу утсаар ярьсан.
4. Найз тань танд бүжиглэж үзүүлсэн.
5. Найз тань танд тусалсан.
6. Найз тань танд шинэ дуу зааж өгсөн.
7. Найз тань таныг баярт урьсан.
8. Найз тань танд дуу дуулж өгсөн.
9. Найз тань таныг хоолонд урьсан.
10. Найз тань танд сайхан кино үзүүлсэн.
11. Найз тань танд шинэ номын тухай хэлсэн.
12. Найз тань танд имэйл бичсэн.
13. Найз тань танд гоё зураг өгсөн.
14. Найз тань танд сайхан үг хэлсэн.
15. Найз тань тантай хамт ажилласан.

Шинэ үгс: утасдах — to call on the phone, урих — to invite

### Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Thank you for asking.
2. Thank you for telling me this.
3. Thank you for helping me.
4. Thank you for inviting me.
5. Thank you for cooking.
6. Thank you for teaching the lesson.
7. Thank you for being with me.
8. Thank you for playing with me.
9. Thank you for trusting me.
10. Thank you for bringing the fruit.

# Хорин есдүгээр хичээл



## Гарахын тийн ялгал (Ablative case)

-аас<sup>4</sup> (from, of, than)

|  |  |
|--|--|
| Би <b>Америкаас</b> ирсэн.               | I came <b>from</b> America.                |
| Хүүхдүүд <b>гэрээсээ</b> ирсэн.          | The children came <b>from</b> their house. |
| Би <b>ээжээсээ</b> үзэг авсан.           | I got a pen <b>from</b> my mother.         |
| Би <b>дэлгүүрээс</b> дэвтэр авна.        | I will buy a book <b>from</b> the store.   |
| Тэр багшаас асуулт асуух дуртай.         | He likes to ask the teacher questions.     |
| Би нохойноос айдаг.                      | I'm afraid <b>of</b> dogs.                 |
| Тэр найзаасаа <b>тусламж гуйгаагүй</b> . | She didn't ask her friend for help.        |
| Америк <b>Монголоос</b> том.             | America is bigger <b>than</b> Mongolia.    |
| Монгол <b>Америкаас</b> жижиг.           | Mongolia is smaller <b>than</b> America.   |

Spelling rules:

|   | After words with <b>а</b> or <b>у</b> | After words with <b>э, ү</b> or <b>и</b> | After words with <b>о</b> | After words with <b>ө</b> |
|---|---------------------------------------|--|---------------------------|---------------------------|
| After words ending with consonants or short vowels                    | <b>-аас</b>                           | <b>-ээс</b>                              | <b>-оос</b>               | <b>-өөс</b>               |
| After words ending with long vowels or diphthongs (related to people) | <b>-(г)аас</b>                        | <b>-(г)ээс</b>                           | <b>-(г)оос</b>            | <b>-(г)өөс</b>            |
| After words ending with long vowels or diphthongs (related to things) | <b>-(н)аас</b>                        | <b>-(н)ээс</b>                           | <b>-(н)оос</b>            | <b>-(н)өөс</b>            |

For example:

|         |          |             |                 |
|---------|----------|-------------|-----------------|
| ахаас   | гараас   | эмэгтэйгээс | модноос         |
| эгчээс  | эмээгээс | хашаанаас   | <b>ботгноос</b> |
| охиноос | өвөөгөөс | хөдөөнөөс   | жимснээс        |
| тазраас | дүүгээс  | гахайнаас   | <b>үүлнээс</b>  |

Note:

|                       |                              |                     |
|-----------------------|------------------------------|---------------------|
| -өхөр + өөс = нөхрөөс | <b>дарга + аас = даргаас</b> | хорь + оос = хориос |
| хамар + аас = хамраас | <b>бага + аас = багаас</b>   | тавь + аас = тавиас |

Question pronouns and personal pronouns:

|              |               |                    |
|--------------|---------------|--------------------|
| эу → юунаас  | та → танаас   | бид → биднээс      |
| хэн → хэнээс | чи → чамаас   | та нар → та нараас |
| би → надаас  | тэр → түүнээс | тэд → тэднээс      |

## Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Хүүхдүүд, аав (ээж, багш, ах, эгч), олон асуулт, асуух
2. Тэд, найз (хөрш, дарга, захирал, эмээ, өвөө), тусламж, гуйх
3. Бид нар, багш (аав ээж, ах, эгч, хүүхдүүд, дарга), эмээх хэрэгтэй
4. Би, хүмүүс (найз, хүүхдүүд, хичээл, ажил, монгол хоол), залхах
5. Тэр, нохой (муур, морь, хонь, ямаа, тэмээ, үхэр), айх
6. Би, энд, ажил (гэр, байр, сургууль, ресторан, дэлгүүр), ирэх
7. Хүүхдүүд, өрөө (анги, сургууль, гэр, байшин(г), байр), гарах
8. Та, битгий, ажил (хичээл, хурал, уулзалт), хоцрох
9. Хүүхэд, машин (автобус, морь, микроавтобус), буух

Шинэ үгс: гуйх — to ask for, эмээх — to fear (out of respect), залхах — to get tired of, айх — to be afraid, хурал — official meeting, уулзалт — meeting, хоцрох — to be late for, буух — to get off

## Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь: Хэн хэнээс юуны тухай асуудаг вэ? (Who asks whom about what?)

Хүүхдүүд багшаасаа хичээлийн тухай асуудаг. (Children ask their teacher about lessons.)

1. Хэн хэнээс юу авдаг вэ?
2. Хэн хаанаас юу авдаг вэ?
3. Хэн хэнээс юу гуйдаг вэ?
4. Хэн хэнээс/юунаас залхдаг вэ?
5. Хэн хэнээс/юунаас айдаг вэ?
6. Хэн хэнээс эмээх хэрэгтэй вэ?
7. Хэн юунаас хоцордог вэ?
8. Хэн хаанаас ирсэн бэ?
9. Хэн юунаас болгоомжлох хэрэгтэй вэ?
10. Хэн хэнээс болгоомжлох хэрэгтэй вэ?

Шинэ үг: болгоомжлох — to be careful

## Дасгал 3

Биеийн төлөөний үгсийг гарахын тийн ялгалын нөхцөлөөр хувирга. Өмнөх хүснэгтээсээ харалгүй дараагийн хүснэгтээ бөглөж бич. (Add the ablative case to the personal pronouns. Fill out the next table without looking at the previous table.)

| ХЭН       | ХЭНЭЭС | ХЭН       | ХЭНЭЭС | ХЭН       | ХЭНЭЭС |
|-----------|--------|-----------|--------|-----------|--------|
| Би        |        | Тэд (нар) |        | Тэр       |        |
| Чи        |        | Та нар    |        | Тэд (нар) |        |
| Та        |        | Бид (нар) |        | Чи        |        |
| Тэр       |        | Тэр       |        | Би        |        |
| Бид (нар) |        | Та        |        | Бид (нар) |        |
| Та нар    |        | Чи        |        | Та нар    |        |
| Тэд (нар) |        | Би        |        | Та        |        |

## Дасгал 4

Эгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I came from America (Mongolia, my home, my work, the store, the restaurant).
2. I got the paper from my teacher (my neighbor, my parents, her, store).
3. Children are afraid of bad people (dogs, cats, goats, them).
4. Did you ask your friend (him) about that new book?
5. What time did you come from your work (your lesson) to your house?
6. I heard about Mongolia from my friend (the teacher, you).



**... -аас<sup>4</sup> ... хүртэл (from ... to (until) ... )**

Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл хичээл хийдэг вэ? (**From what time to** what time do you do lessons?)

Бид 9 цагаас 12 цаг 15 минут хүртэл хичээл хийдэг. (We do lessons from 9 o'clock to 12:15.)

Бид 9-өөс 12:15 хүртэл хичээл хийдэг. (We do lessons from 9 to 12:15.)

Би эндээс Дархан хүртэл машинаар явсан. (I went from here to Darkhan by car.)

## Дасгал 5

÷суултад хариул. (Answer the questions.)

1. Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл ажилладаг вэ?
2. Та хэдээс хэд хүртэл сургууль дээрээ байдаг вэ?
3. Та хэдэн сараас хэдэн сар хүртэл монгол хэл сурах вэ?
4. Та хэдэн оноос хэдэн он хүртэл сургуульд сурсан бэ?
5. Та хаанаас хаа хүртэл онгоцоор явдаг вэ?

—инэ үг: дээрээ — at your

## Дасгал 6

Эгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I slept from 10 pm to 10 am.
2. They go to school from fall to summer.
3. That boy works from morning to night.
4. I lived in the countryside from 2003 to 2008.
5. He did his lesson from evening to morning.
6. Please translate the sentences from one to ten.
7. Please count from one to one hundred.

—инэ үгс: 10 pm — оройн 10 цаг, 10 am — өглөөний 10 цаг

# Гучдугаар хичээл



## Хөндлөнгийн үг (Direct speech)

"Та багш уу?" гэж тэр надаас асуусан.  
Тэр надаас "Та багш уу?" гэж асуусан.  
"Тийм ээ, би багш" гэж би хариулсан.

He asked me, "Are you a teacher?"  
He asked me, "Are you a teacher?"  
"Yes, I'm a teacher," I replied.

### Дасгал 1

Харилцаа яриа бүрт доорх загварын дагуу хөндлөнгийн үгтэй өгүүлбэр бич. (Write sentences with direct speech for each conversation as in the example.)

А. "....." гэж ..... асуух  
Б. "....." гэж ..... хэлэх  
В. .... гэж ..... бодох

Жишээ нь:

Аав: — Миний хүү, хичээлээ хийсэн үү?

Хүү: — Хийсэн, аав аа.

А. "Миний хүү, хичээлээ хийсэн үү?" гэж аав хүүгээсээ асуусан.

Б. "Хийсэн, аав аа" гэж хүү аавдаа хэлсэн.

В. Энэ их сайн хүү гэж би бодож байна.

- Ээж: — Миний хүү, өнөөдөр гэртээ эрт ирж чадах уу?  
Хүү: — Чадахгүй ээ, ээж ээ.
- Дүү: — Эгч ээ, миний цүнх хаана байна (вэ)?  
Эгч: — Ширээн доор байна.
- Багш: — Чи яагаад гэрийн даалгавраа хийгээгүй юм бэ?  
Оюутан: — Багш аа, би хийсэн. Харин дэвтрээ гэртээ мартчихжээ.
- Жолооч: — Та хаашаа явах вэ?  
Жон: — Их дэлгүүр лүү явна аа.
- Худалдагч: — Та хэдэн талх авах вэ?  
Үйлчлүүлэгч: — Хоёр хар талх авъя.
- Охин: — Аав аа, та хэзээ надтай тоглох юм бэ?  
Аав: — Маргааш тоглоно оо.
- Батхүү: — Чи юу идэх дуртай вэ?  
Энхмаа: — Мэдэхгүй ээ, мэдэхгүй.
- Жаргалмаа: — Гадаа ямар байна (вэ)?  
Доржмаа: — Гадаа нартай, дулаахан байна.

Шинэ үгс: эрт — early, худалдагч — seller, үйлчлүүлэгч — customer

## Дасгал 2

Эгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. My friend asked me, "Where were you?"  
I said to my friend, "I was outside."
2. My teacher asked me, "Why didn't you write your lesson?"  
I said to my teacher, "I forgot my pen at my house."
3. Bayarhuu asked Enhmaa, "Where did you play tennis?"  
Enhmaa said to Bayarhuu, "I played tennis at the school."
4. I asked her, "When did you come from the countryside?"  
She said to me, "I came from the countryside last week."
5. I asked you, "What time will you be here tomorrow?"  
You said me, "I will be here at 10 am tomorrow."

## Дасгал 3

Асуултад харуул. (Answer the questions.)

### -аас<sup>4</sup> шалтгаалах — to depend on

- |  |                                      |
|--|--------------------------------------|
| *Шээлбэл: Та өдөр бүр гадаа алхдаг уу? | Do you walk outside everyday?        |
| — Цаг агаараас шалтгаалдаг.            | — It depends <b>on the weather</b> . |
| — Сэтгэл санаанаас шалтгаалдаг.        | — It depends on how I feel.          |

Цаг яагаад заримдаа удаан, заримдаа хурдан өнгөрдөг вэ?

- |   |                                    |
|---|------------------------------------|
| *Why does time sometimes go fast and sometimes go slow? |                                    |
| — Юу хийж байгаагаас шалтгаалдаг.                       | — It depends on what we are doing. |
| — Хаана байгаагаас шалтгаалдаг.                         | — It depends on where we are.      |

1. Хүүхдүүд өдөр бүр гадаа тоглодог уу?
2. Бүх хүн хэл хурдан сурдаг уу?
3. Та шөнө бүр сайн унтдаг уу?
4. Та бүх хоолыг идэж чадах уу?
5. Танай улсад бүх хоол үнэтэй юү?
6. Та өдөр бүр завгүй байдаг уу?
7. Гадаад улсад амьдрах амархан уу?
8. Та бүх мөнгол хүний яриаг ойлгодог уу?
9. Та дандаа сайхан зүйл боддог уу?
10. Та ер нь баяр хөөртэй байдаг уу?
11. Хүмүүс дандаа хөдөө явдаг уу?
12. Зарим хүүхэд яагаад сайн, зарим хүүхэд яагаад муу байдаг вэ?
13. Ямар нэг шашинд итгэдэг бүх хүн сайн зүйл хийдэг үү?

— илнэ үгс: улс — country, яриа — speech/talking, баяр хөөртэй — joyful, шашин — religion, зүйл — thing



# Давтлага хичээл

## Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Томчууд яагаад ажил хийх хэрэгтэй вэ?
2. Хүмүүс яагаад хоол идэх хэрэгтэй вэ?
3. Хүүхдүүд яагаад сургуульд сурах хэрэгтэй вэ?
4. Та юу хийх хэрэгтэй вэ? Танд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?
5. Хүүхдүүдэд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?
6. Оюутнуудад юу хэрэгтэй вэ?
7. Эрэгтэйчүүдэд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?
8. Эмэгтэйчүүдэд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?

## Дасгал 2

"Хийх" гэдэг үйл үгийг ашиглан өгөгдсөн нөхцөл байдалд тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the verb "хийх.")

Жишээ нь: Надад мах байна. → Махаа хөргөгчинд хий.

1. Миний гарт мөнгө байна.
2. Надад ном, дэвтэр байна.
3. Түүнд гар утас байна.
4. Тэд нарт чихэр байна.
5. Надад талх байна.
6. Надад үзэг, харандаа, бал байна.
7. Ширээн дээр аяга, таваг байна.
8. Хүүхэд хувцаснуудаа барьж байна.
9. Сандал дээр тоглоом байна.
10. Би дэлгүүрээс олон юм авч байна.

## Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Гэрт чинь ирсэн найздаа та юу гэж хэлэх вэ?
2. Хичээд заасан багшдаа та юу гэж хэлэх вэ?
3. Өөрт чинь тусалсан найздаа (та) юу гэж хэлэх вэ?
4. Өөрт чинь хоол хийж өгсөн найздаа та юу гэж хэлэх вэ?
5. Таныг гэртээ урьсан найздаа (та) юу гэж хэлэх вэ?
6. Өөртэй чинь хамт ажилласан найздаа (та) юу гэж хэлэх вэ?
7. Тантай хамт дэлгүүр лүү явсан найздаа юу гэж хэлэх вэ?
8. Гэр бүлийн тань талаар асуусан найздаа юу гэж хэлэх вэ?
9. Өөрт чинь бэлэг өгсөн найздаа та юу гэж хэлэх вэ?

Шинэ үгс: өөрт чинь — to you, өөртэй чинь — with you

## Дасгал 4

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation.)

1. Би дандаа найзаасаа мөнгө, тусламж гуйдаг.
2. Би хүмүүсээс тусламж гуйх дургүй. Бүх юмыг ганцаараа хийдэг.
3. Би хүмүүсээс ерөөсөө уучлалт гуйдаггүй.
4. Би хүмүүсээс айдаг учраас хүмүүстэй байх дургүй.
5. Би бүх юмнаас залхаж байна.
6. Би ер нь хичээл, хурал, уулзалтаар тав, арван минут хоцордог.
7. Би машинаас айдаггүй.

## Дасгал 5

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл хичээл хийдэг вэ?
2. Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл унтдаг вэ?
3. Та хэдэн сараас хэдэн сар хүртэл монгол хэл сурах вэ?
4. Та гэрээсээ сургууль хүртэл хэдэн минут явдаг вэ?
5. Та өглөөнөөс орой хүртэл хичээлээ хийдэг үү?

## Дасгал 6

Харилцаа яриа бүрт хөндлөнгийн үгтэй өгүүлбэр бич. Мөн харилцаа яриа бүр дээр тэр хүмүүсийн талаар юу бодож байгаагаа бич. (Write sentences with direct speech for each conversation. Also write what you think about the people in each conversation.)

1. Анхмаа: — Чи надаас уучлалт гуйхгүй юм уу?  
Базархүү: — Үгүй. Чи надаас уучлалт гуйдаггүй.
2. Галхүү: — Чи надад хоол хийсэн үү?  
Одмаа: — Хийсэн. Миний найз, хоолоо ид.
3. Хүү: — Ээж ээ, надтай хамт тоглоорой.  
Ээж: — Ээж нь завгүй байна.
4. Нөхөр: — Өнөөдөр ядарсан уу? Би хоол хийсэн.  
Эхнэр: — Баярлалаа, би их ядарсан.
5. Эмээ: — Миний хүү, энэ автобус хаашаа явах вэ?  
Хүү: — Мэдэхгүй ээ, мэдэхгүй.
6. Ах: — Чи тэр хүнээс айгаад байгаа юм уу?  
Дүү: — Харин тийм ээ.
7. Гэрэлмаа: — Чи гэрийн даалгавраа хийсэн үү?  
Болдхүү: — Чамд хамаагүй.

Линэ үг: Чамд хамаагүй. — You don't care. (It is not your business.)

## Дасгал 7


Асуух төлөөний үгсийн оронд тохирох үгийг бичиж, асуултад хариул. (Answer the questions by replacing question pronouns with appropriate words.)

Жишээлбэл: Хэн хэний хэнтэй юу үзсэн бэ?  
Би таны эгчтэй кино үзсэн.

1. Хэн хэзээ хэдэн цагт хэнтэй хаана юу идсэн бэ?
2. Хэн хэдэн удаа юу хийх хэрэгтэй вэ?
3. Хэнд юу хэрэгтэй вэ?
4. Хэн хэнтэй хаана хэдэн цаг юуны тухай ярьсан бэ?
5. Хэн юунд дуртай вэ?
6. Хэн хэнээс юу гуйсан бэ?
7. Хэн хэнтэй хэдэн удаа юу тоглодог вэ?
8. Хэн хэдэн оны хэдэн сарын хэдэнд төрсөн бэ?
9. Хэн хэзээ юунаас айсан бэ?
10. Хэн хэзээ хаанаас ирсэн бэ?
11. Хэн хэнд ямар юу авсан бэ?
12. Хэн хэнд ямар юу заадаг вэ?

## Дасгал 8

Үгийн сүлжээг бөглө. (Fill out the crossword puzzle.)



### Across

1. to die
2. hospital
3. hand
4. stomach
5. ear
6. mouth
7. body
8. to have a fever
9. doctor
10. finger
11. to get sick

### Down

1. head
2. face
3. tongue
4. back
5. to be healed
6. eye
7. to treat
8. to cough
9. leg
10. hair
11. nose

# Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.

Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. People need food.  
A. Хүмүүс хоол хэрэгтэй.  
 B. Хүмүүст хоол хэрэгтэй.  
B. Хүмүүс хоолонд хэрэгтэй.
2. Аль нь зөв бэ? Which one is right?  
 A. Хүүхдүүд амрах хэрэгтэй.  
 B. Хүүхдүүдэд амрах хэрэгтэй.  
B. Хүүхдүүдэнд амрах хэрэгтэй.
3. Аль нь зөв бэ? Which one is right?  
 A. Эрэгтэйчүүдэд тамхи хэрэггүй.  
B. Эрэгтэйчүүд тамхи хэрэггүй.  
B. Эрэгтэйчүүд тамхинд хэрэггүй.
4. I have a book.  
A. Би ном байгаа.  
B. Би номонд байгаа.  
 B. Надад ном байгаа.
5. Аль нь зөв бэ? Which one is right?  
 A. Ирсэнд баярлалаа.  
B. Ирсэн баярлалаа.  
B. Ирэх баярлалаа.
6. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Туслах баярлалаа.  
 B. Тусалсанд баярлалаа.  
B. Тусалсан баярлалаа.
7. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Би нохой айдаг.  
B. Би нохойнд айдаг.  
 B. Би нохойноос айдаг.
8. He asked his friend for help.  
 A. Тэр найзаасаа тусламж гуйсан.  
B. Тэр найздаа тусламж гуйсан.  
B. Тэр найзтайгаа тусламж гуйсан.
9. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Сурагч багшдаа асуулт асуудаг.  
B. Сурагч багшаа асуулт асуудаг.  
 B. Сурагч багшаасаа асуулт асуудаг.
10. Аль нь зөв бэ? Which one is right?  
 A. "Баярлалаа" гэж охин ээждээ хэлсэн.  
B. "Баярлалаа" охин гэж ээждээ хэлсэн.  
B. Охин "Баярлалаа" ээждээ гэж хэлсэн.
11. Аль нь зөв бэ? Which one is right?  
A. Тэр сайн хүн би гэж бодож байна.  
 B. Тэр сайн хүн гэж би бодож байна.  
B. Тэр сайн хүн гэж бодож би байна.
12. Аль нь зөв бэ? Which one is right?  
 A. Би багшаас "Энэ юу вэ?" гэж асуусан.  
B. Би "Энэ юу вэ?" багшаас гэж асуусан.  
B. Багшаас "Энэ юу вэ?" би гэж асуусан.
13. Enhmaa put her hand phone in her purse.  
A. Энхмаа гар утсаа цүнхэнд нь хийсэн.  
 B. Энхмаа гар утсаа цүнхэндээ хийсэн.  
B. Энхмаа гар утсаа цүнхээ хийсэн.
14. Put your money in your wallet.  
A. Мөнгөө түрийвчинд хий.  
B. Мөнгөө таны түрийвчинд хий.  
 B. Мөнгөө түрийвчиндээ хий.
15. She has a pen.  
 A. Түүнд үзэг байна.  
B. Тэр үзэг байна.  
B. Түүнд үзэгтэй байна.
16. It depends on the weather.  
A. Цаг агаарт шалтгаалдаг.  
 B. Цаг агаараас шалтгаалдаг.  
B. Цаг агаар дээр шалтгаалдаг.

Оноо (point): 16/.....

# Гучин нэгдүгээр хичээл



## Харьцуулсан зэрэг (Comparative)

|   |                             |
|---|-----------------------------|
| өндөр (tall)                            | нам(хан)(short)             |
| хөгшин (old (people and living things)) | залуу (young)               |
| тарган (fat)                            | туранхай (thin)             |
| өргөн (wide)                            | нарийн (narrow)             |
| хол (far)                               | ойр(хон) (near)             |
| сонирхолтой (interesting)               | сонирхолгүй (uninteresting) |
| адил(хан) (same)                        | өөр (different)             |
| зөв (right)                             | буруу (wrong)               |
| үнэн (true)                             | худал (not true/false)      |
| хурдан (fast)                           | удаан (slow)                |
| урт (long)                              | богино (short)              |
| хүчтэй (strong)                         | сул (weak)                  |
| хатуу (hard)                            | зөөлөн (soft)               |

Жаргалмаа **Ганхүүгээс** өндөр. Jargalmaa is taller **than Ganhuu**.  
Ганхүү **Жаргалмаагаас** намхан. Ganhuu is shorter **than Jargalmaa**.

## Дасгал 1

Өгөгдсөн тэмдэг нэрсийг ашиглан хүн, мал, юмсыг хооронд нь харьцуул. (Compare people, livestock, and things using the given adjectives.)

1. Гахай, ямаа (тарган, туранхай)
2. Аав, ээж (хатуу, зөөлөн)
3. Тэмээ, ямаа (өндөр, намхан)
4. Миний ном, таны ном (хуучин, шинэ)
5. Монгол хэл, англи хэл (хэцүү, амархан)
6. Онгоц, машин (хурдан, удаан)
7. Даавуу, цаас (зөөлөн, хатуу)
8. Монгол хоол, солонгос хоол (үнэтэй, хямд)
9. Миний үс, таны үс (урт, богино)
10. Гэр, байшин (дулаан, сэрүүн)
11. Ази хүмүүс, европ хүмүүс (жижиг, том)
12. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд (хүчтэй, сул)

Шинэ үг: даавуу — cotton

## Дасгал 2

Доорх жишээ өгүүлбэрт бичсэний адилаар хүн болон юмсыг харьцуул. (Compare people and things as in the examples given below.)

Жишээ:

Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс өөр. (Men are different than women.)


Монголчууд япончуудтай адилхан хар үстэй. (Mongolians have black hair same as Japanese.)

Монголчууд солонгосчууд шиг хар үстэй. (Mongolians have black hair like Koreans do.)

- |                             |                           |
|-----------------------------|---------------------------|
| 1. Ази хүмүүс, европ хүмүүс | 7. Өдөр, шөнө             |
| 2. Монголчууд, америкчууд   | 8. Шоколад, чихэр         |
| 3. Томчууд, хүүхдүүд        | 9. Чихэр, давс            |
| 4. Хонины мах, үхрийн мах   | 10. Цамц, өмд             |
| 5. Монгол гэр, байр         | 11. Хар цай, сүүтэй цай   |
| 6. Пицца, талх              | 12. Англи хэл, монгол хэл |

## Дасгал 3

Доорх зургуудыг хараад хүн, юм, амьтдыг харьцуулж бич. (Look at the pictures below and compare people, things, and animals.)





## Давуу зэрэг (Superlative)

### Хамгийн (-est/most)

|               |          |                |                          |
|---------------|----------|----------------|--------------------------|
| хамгийн сайн  | best     | хамгийн хүйтэн | coldest                  |
| хамгийн муу   | worst    | хамгийн үнэтэй | most expensive           |
| хамгийн том   | biggest  | хамгийн чухал  | most important           |
| хамгийн жижиг | smallest | хамгийн дуртай | like the most (favorite) |

### Дасгал 4

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Танай улсын хамгийн өндөр байшин хэдэн давхар вэ?
2. Танай улсын хамгийн өндөр уул ямар уул вэ?
3. Танай улсын хамгийн алдартай хүмүүс хэн хэн бэ?
4. Хамгийн үнэтэй (чухал, муу) юм юу вэ?
5. Ямар хүн хамгийн сайн (муу) хүн бэ?
6. Хамгийн амттай (муухай) хоол юу вэ?
7. Америкт хамгийн үнэтэй юм юу вэ?
8. Хамгийн хэрэггүй юм юу вэ?

Шинэ үгс: алдартай — famous, чухал — important

### Дасгал 5

Асуултад харуул. (Answer the questions.)

Жишээ нь: Таны хамгийн дуртай хоол ямар хоол вэ? → Миний хамгийн дуртай хоол пицца.

1. Таны хамгийн дуртай хоол ямар хоол вэ?
2. Таны хамгийн дуртай спорт ямар спорт вэ?
3. Таны хамгийн дуртай юм юу вэ?
4. Таны хамгийн дургүй хоол ямар хоол вэ?
5. Таны хамгийн дуртай ундаа ямар ундаа вэ?
6. Таны хамгийн дургүй юм юу вэ?
7. Таны хамгийн дуртай улирал ямар улирал вэ?
8. Таны хамгийн дуртай ном ямар ном бэ?
9. Таны хамгийн дургүй кино ямар кино вэ?
10. Таны хамгийн дуртай кино ямар кино вэ?
11. Таны хамгийн дургүй улирал ямар улирал вэ?

# Гучин хоёрдугаар хичээл



## -ж/-ч чадах (to be able to)

- Та морь унаж чадах уу?
- Тийм, (би морь унаж) чадна.
- Үгүй, (би морь унаж) чадахгүй.

- Can you ride a horse?
- Yes, I can (ride a horse).
- No, I can't (ride a horse).

- Та морь унаж чаддаг уу?
- Тийм, (би морь унаж) чаддаг.
- Үгүй, (би морь унаж) чаддаггүй.

- Can you ride a horse?
- Yes, I can (ride a horse).
- No, I can't (ride a horse).

## Дасгал 1

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Та теннис тоглож чадах уу?
2. Та усанд сэлж чаддаг уу?
3. Та монгол хэл зааж чадах уу?
4. Та ганцаараа харьж чадах уу?
5. Та найздаа тусалж чадах уу?
6. Та хаана амьдарч чадахгүй вэ?
7. Та юу юу хийж чаддаг вэ?
8. Та юу юу хийж чаддаггүй вэ?
9. Та монгол хоол хийж чадах уу?
10. Та солонгос хоол идэж чаддаг уу?
11. Та олон үг нэг дор цээжилж чадах уу?
12. Тэр монгол текст орчуулж чадах уу?
13. Та ямар ямар хоол хийж чаддаг вэ?
14. Та таван цагт энд ирж чадах уу?
15. Та надтай хамт хөдөө явж чадах уу?
16. Та хүүхдүүдэд юу юу зааж чадах вэ?
17. Та 10 хоног хоолгүй байж чадах уу?
18. Та 4 хоног усгүй байж чадах уу?

— нэ үгс: (элэх — to swim, харих — to go home, нэг дор — at once, цээжлэх — to memorize)

## Дасгал 2

Эгүүлбэрийг орчуулаад асуулт зохио. (Translate the sentences, then make questions.)

1. I can cook Mongolian food.
2. They can sing very well.
3. She can't dance very well.
4. I can ride a horse.
5. We can drive a car.
6. He can build a house.
7. I can catch a fish.
8. I can't eat Mongolian food.
9. She can meet you tomorrow.
10. She can make a Mongolian deel.
11. I can live here.
12. She can come tomorrow.
13. I can't help him.
14. They can't come here at 8 o'clock.
15. I can't meet him tomorrow.
16. They can eat Mongolian food.
17. You can learn Mongolian very well.
18. She can help you.

## Дасгал 3

Асуулт бүрт гурваас доошгүй хариулт бич. (Write at least three answers for each question.)

|                  | ... юу юу хийж чаддаг вэ? | ... юу юу хийж чаддаггүй вэ? |
|------------------|---------------------------|------------------------------|
| 6 сартай хүүхэд  |                           |                              |
| 3 настай хүүхэд  |                           |                              |
| 7 настай хүүхэд  |                           |                              |
| 18 настай хүүхэд |                           |                              |
| Том хүн          |                           |                              |
| Нохой            |                           |                              |
| Шувуу            |                           |                              |
| Морь             |                           |                              |
| Монголчууд       |                           |                              |
| Америкчууд       |                           |                              |

Шинэ үг: шувуу — bird

## Уучлал гуйх (To ask for forgiveness)

A: — Уучлаарай.

Б: — Зүгээр (зүгээр).

— Намайг уучлаарай.

— Ёстой уучлаарай.

— Үнэхээр уучлаарай.

— Хоцорсонд уучлаарай.

— Ирж чадаагүйд уучлаарай.

— Уучлаарай, мартчихжээ.

A: — Excuse me/Sorry.

B: — No problem.

— Please forgive me.

— I'm very sorry.

— I'm really sorry.

— Sorry for being late.

— Sorry for not being able to come.

— Sorry, I forgot about it.

# Гучин гуравдугаар хичээл



## -ж/-ч болох (May)

- |                                     |                                   |
|-------------------------------------|-----------------------------------|
| — Танаас асуулт асууж болох уу?     | — May I ask you a question?       |
| — Тийм, (та асуулт асууж) болно.    | — Yes, you may (ask question).    |
| — Үгүй, (та асуулт асууж) болохгүй. | — No, you may not (ask question). |
| — Энд сууж болох уу?                | — May I sit here?                 |
| — Болно оо, болно.                  | — Yes, you may.                   |

## Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| 1. (Би) <sup>27</sup> орж болох уу? | 11. Би одоо гэр лүүгээ явж болох уу?    |
| 2. (Би) ангид орж болох уу?         | 12. Хүүхдүүд ангид унтаж болох уу?      |
| 3. Би энд байж болох уу?            | 13. Би танай нохойг хооллож болох уу?   |
| 4. Би өнөөдөр амарч болох уу?       | 14. Би сургуульд хоол авчирч болох уу?  |
| 5. (Би) энэ цайг ууж болох уу?      | 15. (Би) энэ сандал дээр сууж болох уу? |
| 6. (Би) энэ номыг авч болох уу?     | 16. Би ангид нохой авчирч болох уу?     |
| 7. (Би) энэ хоолыг идэж болох уу?   | 17. (Би) танайд дахиад ирж болох уу?    |
| 8. (Би) танд нэг юм хэлж болох уу?  | 18. Би өнөөдөр хоол хийж болох уу?      |
| 9. Танаас нэг юм асууж болох уу?    | 19. Би танай гэрт амьдарч болох уу?     |
| 10. Бид нар ангиас гарч болох уу?   | 20. Би тантай хөдөө явж болох уу?       |

Линэ үгс: хонох — to spend a night, хооллох — to feed

## Дасгал 2

Эгүүлбэрийг орчуулж, асуулт зохио. (Translate the sentences and make questions.)

- |                             |                                     |
|-----------------------------|-------------------------------------|
| 1. You may come in.         | 9. They may live here.              |
| 2. You may ask questions.   | 10. You may open the window.        |
| 3. You may sit here.        | 11. You may close the door.         |
| 4. You may leave now.       | 12. He may go with us.              |
| 5. You may play now.        | 13. She may cook tonight.           |
| 6. She may come tomorrow.   | 14. They may rest now.              |
| 7. You may trust him.       | 15. They may eat now.               |
| 8. You may teach Mongolian. | 16. They may ride a horse tomorrow. |

<sup>27</sup> If it is clear from context that you are going to do something, then we don't have to say "Би."

### Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

- |                              |  |
|------------------------------|--|
| 1. Can you ride a horse?     | 10. "I can wait for you" she said to me.     |
| 2. Can you drive a car?      | 11. Can you call me tomorrow?                |
| 3. May I ask you a question? | 12. May she play now?                        |
| 4. Can you build a house?    | 13. I can't come to my lesson tomorrow.      |
| 5. Can you catch a fish?     | 14. May I sit here?                          |
| 6. May I come in?            | 15. Can you hold this piece of wood?         |
| 7. He can work next week.    | 16. May I speak in Mongolian now?            |
| 8. I can't help her.         | 17. "I can't cook Mongolian food," she said. |
| 9. May I leave now?          | 18. She can play games with us tomorrow.     |

### Дасгал 4

Асуулт бүрт гурваас доошгүй хариулт бич. (Write at least three answers for each question.)

|                   | ... юу юу өгч болох вэ? | ... юу юу өгч болохгүй вэ? |
|-------------------|-------------------------|----------------------------|
| 6 сартай хүүхдэд  |                         |                            |
| 3 настай хүүхдэд  |                         |                            |
| 7 настай хүүхдэд  |                         |                            |
| 18 настай хүүхдэд |                         |                            |
| Том хүнд          |                         |                            |

### Дасгал 5

Асуулт бүрт гурваас доошгүй хариулт бич. (Write at least three answers for each question.)

|                       | ... юу юу хийж болох вэ? | ... юу юу хийж болохгүй вэ? |
|-----------------------|--------------------------|-----------------------------|
| Гэрт                  |                          |                             |
| Эмнэлэгт              |                          |                             |
| Ангид                 |                          |                             |
| Автобусанд            |                          |                             |
| Гадаа                 |                          |                             |
| Гадаад хүмүүс Монголд |                          |                             |

# Гучин дөрөвдүгээр хичээл



байх аа

магадгүй

юм шиг байна

probably, I think

maybe

It looks (seems, sounds, feels) like

Энхмаа хоол хийх **байх аа**.  
хийдэг байх аа.  
хийж байгаа байх аа.  
хийх дуртай байх аа.  
хийсэн байх аа.  
хийгээгүй байх аа.

**Probably** Enhmaa will cook.  
cooks.  
is cooking.  
likes to cook.  
cooked.  
didn't cook.

Энхмаа хоол хийх **юм шиг байна**.  
хийдэг юм шиг байна.  
хийж байгаа юм шиг байна.  
хийх дуртай юм шиг байна.  
хийсэн юм шиг байна.  
хийгээгүй юм шиг байна.

**It looks like** Enhmaa will cook.  
cooks.  
is cooking.  
likes to cook.  
cooked.  
didn't cook.

Энхмаа хоол хийж **магадгүй**.  
хийдэг байж магадгүй.  
хийж байгаа байж магадгүй.  
хийх дуртай байж магадгүй.  
хийсэн байж магадгүй.  
хийгээгүй байж магадгүй.

**Maybe** Enhmaa will cook.  
cooks.  
is cooking.  
likes to cook.  
cooked.  
didn't cook.

Тийм байх аа. I think so/Probably so.  
Түггүй байх аа. I don't think so/Probably not.

Тийм юм шиг байна. It seems/looks so.  
Түггүй юм шиг байна. It seems/looks not.

Тийм байж магадгүй. Maybe so.  
Түггүй байж магадгүй. Maybe not.

Тийм ч байж магадгүй, үгүй ч байж магадгүй. Maybe so, maybe not.

Тэр ирсэн ч байж магадгүй, үгүй ч байж магадгүй. Maybe he came, maybe not.  
Тэр ирсэн ч байж магадгүй, ирээгүй ч байж магадгүй. Maybe he came, maybe not.

## Дасгал 1

A: — Сайн байна уу? Би Гэрэлмаа байна.

A: — Hello?

B: — Hello.

A: — Are you Bathuu?

B: — Yes.

A: — Hi, I'm Gerelmaa.

— Та хэнтэй ярих гэсэн юм бэ?

— Батхүүтэй ярих гэсэн юм.

— За, одоохон.

— Тийм хүн байдаггүй.

— Та буруу залгачихжээ.

— Who do you want to talk to?

— I would like to talk to Bathuu.

— Okay, wait a minute.

— Such (that) person isn't (generally) here.

— You dialed the wrong number.



# Давтлага хичээл

## Дасгал 1

Үйл үгийн "-ж/-ч" нөхцөлийг ашиглан өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохио. (Make sentences with the given words using the suffixes "-ж/-ч.")

Жишээлбэл: явах, үзэх → Тэд гадагшаа (out) явж кино үзсэн.

- |                   |                    |                     |
|-------------------|--------------------|---------------------|
| 1. ирэх, авах     | 7. гарах, тоглох   | 13. унших, орчуулах |
| 2. ирэх, уулзах   | 8. гарах, гүйх     | 14. зурах, бэлэглэх |
| 3. орох, амрах    | 9. явах, идэх      | 15. олох, өгөх      |
| 4. орох, унших    | 10. явах, амрах    | 16. идэх, ажиллах   |
| 5. унтраах, унтах | 11. асуух, бичих   | 17. асуух, хэрэглэх |
| 6. асаах, хайх    | 12. цэвэрлэх, хийх | 18. хайх, олох      |

## Дасгал 2

"Тэгэх" гэдэг үгийг ашиглан асуултад хариул. (Answer the questions using the verb "тэгэх.")

- |                                    |                                     |
|------------------------------------|-------------------------------------|
| 1. Чи найзтайгаа уулзсан уу?       | 8. Та ингэж чадах уу?               |
| 2. Чи энэ балаар бичих үү?         | 9. Чи өчигдөр энд ирсэн үү?         |
| 3. Та манайд очоорой.              | 10. Та цай уух уу?                  |
| 4. Чи найз руугаа одоо утасдах уу? | 11. Та зун манай гэрт ирж амраарай. |
| 5. Та дандаа машинаар явдаг уу?    | 12. Би танайд дахиад ирнэ ээ.       |
| 6. Над руу утасдаарай.             | 13. Та таван цагт ирээрэй.          |
| 7. Би тан руу утасдана аа.         | 14. Та тамхи татдаг уу?             |

## Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Call your mother tonight. She will be happy.
2. I will call you in the afternoon because I will be busy in the morning.
3. I will go to my school tomorrow morning and I will get some books.
4. The child saw his mother and he ran to her very fast.
5. He was very afraid of my big dog and ran to the door.
6. "My family will move to Erdenet soon," she said to me.
7. The teacher told students, "Look at this picture. Don't look at the window."
8. Do children look at their parents' eyes and talk?
9. Look at me and talk. Don't look that way.
10. Where are you going? Are you going to the store?

### Дасгал 4

Эзгийн оронд "-ын<sup>2</sup>хаа<sup>4</sup>, -нхаа<sup>4</sup>, -ны<sup>2</sup>хаа<sup>4</sup>" нөхцөлүүдээс аль тохирохыг нь нөхөж бич. (Add the proper suffixes from "-ын<sup>2</sup>хаа<sup>4</sup>, -нхаа<sup>4</sup>, -ны<sup>2</sup>хаа<sup>4</sup>" in the spaces.)

\* Ушээ нь: Би найз..... гэр лүү явсан. → Би найзынхаа гэр лүү явсан. (I went to my friend's house.)

1. Тэр, өвөө..... гэрээс энд ирнэ.
2. Би найз..... зуслан руу явмаар байна.
3. Галхүү дүү..... багштай уулзах хэрэгтэй.
4. Алимаа эгч..... гэр лүү утасдах хэрэгтэй.
5. Тэд хөрш..... нохойноос айдаг.
6. Тэр, ах..... гэрт хөзөр тоглох дуртай.
7. Баярхүү нохой..... тухай ярих дуртай.
8. Чи надад гэр бүл..... тухай яриарай.
9. Тэр чамд ажил..... тухай ярихгүй.
10. Би найз..... аав ээжид туслах хэрэгтэй.
11. Та нар хүүхэд..... үгэнд итгэх хэрэгтэй.
12. Би эгч..... охинд цэцэг бэлэглэсэн.
13. Ангирмаа шинэ өрөө..... тухай түүнд ярьсан.
14. Би найз..... гэрт очоогүй.

Линэ үг: бэлэглэх — to give as a gift

### Дасгал 5

Хүснэгтийг бөглөж, үг тус бүр дээр өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences with each word.)

| ХЭН           | ХЭНИЙ | ХЭНТЭЙ | ХЭНД | ХЭНЭЭС | ХЭН РҮҮ |
|---------------|-------|--------|------|--------|---------|
| эмээ          |       |        |      |        |         |
| оюутан        |       |        |      |        |         |
| найз          |       |        |      |        |         |
| эгч           |       |        |      |        |         |
| ах            |       |        |      |        |         |
| дарга         |       |        |      |        |         |
| би            |       |        |      |        |         |
| тэр           |       |        |      |        |         |
| та            |       |        |      |        |         |
| бид (бид нар) |       |        |      |        |         |
| чи            |       |        |      |        |         |
| тэд (тэд нар) |       |        |      |        |         |
| та нар        |       |        |      |        |         |

## Дасгал 6

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Та үхэр тэргээр явж үзсэн үү?
2. Та хөдөө морин тэргээр явж үзсэн үү?
3. Та галт тэргээр явах дуртай юу?
4. Та ер нь онгоцоор ийш(ээ) тийш(ээ) их явдаг уу?
5. Та юугаар хичээлээ бичдэг вэ? Яагаад?
6. Та юугаар бууз иддэг вэ?
7. Та юугаар шөл уудаг вэ?
8. Хүмүүс төмрөөр юу юу хийдэг вэ?
9. Та цаасаар юу юу хийж чадах вэ?
10. Та ямар ямар хэлээр сайн ярьж чаддаг вэ?
11. Та монгол хүмүүстэй англиар ярьдаг уу, монголоор ярьдаг уу?
12. Та зуны, өвлийн амралтаараа юу юу хийдэг вэ?
13. Танай оронд хүмүүс баяраар ер нь юу хийдэг вэ?

## Дасгал 7

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан холбож зур. (Match Mongolian and English words by connecting them with lines.)

|          |               |                  |                   |
|----------|---------------|------------------|-------------------|
| үнэрлэх  | to be cut off | гүйх             | glass             |
| харагдах | cotton        | бэлэглэх         | to fly            |
| тасрах   | chopstick     | шил              | to run            |
| савх     | spoon         | чулуу            | bus stop          |
| даавуу   | knife         | нисэх            | to give as a gift |
| халбага  | to smell      | онгоцны буудал   | bicycle           |
| хутга    | to walk       | унадаг дугуй     | stone             |
| алхах    | to look       | автобусны буудал | airport           |

# Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.

Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?

- A. Тэр зах руу явч, ногоо авсан.
- Б. Тэр зах руу явж, ногоо авсан.
- В. Тэр зах руу яваж, ногоо авсан.

2. Аль нь зөв бэ? Which one is right?

- A. Би найздаа номоо өгч тусалсан.
- Б. Би найздаа номоо өгөж тусалсан.
- В. Би найздаа номоо өгж тусалсан.

3. Аль нь зөв бэ? Which one is right?

- A. Охин аяга угаач, би амарсан.
- Б. Охин аяга угааж, би амарсан.
- В. Охин аяга угаахж, би амарсан.

4. Та над руу утсаар ярьсан уу?

- A. Тэгнэ.
- Б. Тэгье.
- В. Тэгсэн.

5. Чи одоо хоол хийгээрэй.

- A. Тэгье.
- Б. Тэгээрэй.
- В. Тэгнэ.

6. Би танд тусална.

- A. Тэгье.
- Б. Тэгнэ.
- В. Тэгээрэй.

7. Та цай уух уу?

- A. Тэгье.
- Б. Тэгнэ.
- В. Тэгээрэй.

8. I went to my friend's house.

- A. Би найзын гэр лүүгээ явсан.
- Б. Би найзынхаа гэр лүү явсан.
- В. Би миний найзын гэр лүү явсан.

9. I met my teacher's mother.

- A. Би манай багшийн ээжтэй уулзсан.
- Б. Би багшийн ээжтэйгээ уулзсан.
- В. Би багшийнхаа ээжтэй уулзсан.

10. He will make a toy out of stone.

- A. Тэр, чулуунаас тоглоом хийнэ.
- Б. Тэр, чулуугаар тоглоом хийнэ.
- В. Тэр, чулуутай тоглоом хийнэ.

11. She speaks in Mongolian very well.

- A. Тэр монголоор их сайн ярьдаг.
- Б. Тэр монголд их сайн ярьдаг.
- В. Тэр монгол их сайн ярьдаг.

12. What do you do for your holidays?

- A. Та амралтдаа юу хийдэг вэ?
- Б. Та таны амралтаар юу хийдэг вэ?
- В. Та амралтаараа юу хийдэг вэ?

13. Don't eat your food with your hand.

- A. Хоолоо гараараа битгий ид.
- Б. Хоолоо гартайгаа битгий ид.
- В. Хоолоо чиний гараар битгий ид.

14. That pupil doesn't look at his teacher.

- A. Тэр сурагч багшдаа хардаггүй.
- Б. Тэр сурагч багш руугаа хардаггүй.
- В. Тэр сурагч багшаа хардаггүй.

15. Аль нь зөв бэ? Which one is right?

- A. Чи хаашаа явсан бэ?
- Б. Чи хаана явсан бэ?
- В. Чи хаана руу явсан бэ?

16. Аль нь зөв бэ? Which one is right?

- A. Тэд гэр рүүгээ явмаар байна.
- Б. Тэд гэр лүүгээ явмаар байна.
- В. Тэд гэрээ рүү явмаар байна.

Оноо (point): 16/.....

# Дөчин нэгдүгээр хичээл



## Заахын тийн ялгал (Accusative case)

The accusative case (-ыг, г) is used to determine definite and indefinite nouns. Indefinite direct objects have no accusative case ending, but when direct objects are used with pronouns like **энэ**, **тэр**, **аль** or words with the genitive case, then the accusative case is used. This suffix is also used with peoples' names, personal pronouns, or names related to people when they are used as direct objects. For example:

|   |                                |
|---|--------------------------------|
| Би ном уншсан.                          | I read a book.                 |
| Би <b>энэ</b> (тэр, таны) номыг уншсан. | I read this (that, your) book. |
| Та <b>аль</b> номыг уншсан бэ?          | Which book did you read?       |
| Би Баярхүүг харсан.                     | I saw Bayarhuu.                |
| Би таныг харсан.                        | I saw you.                     |
| Би ээжийгээ хүлээж байна.               | I'm waiting for my mother.     |

|   | After words ending with short vowels or consonants | Masculine words ending with <b>ч, ж, ш, ь, и</b> or <b>г</b> | After words ending with long vowels or diphthongs |
|---|--|--|---|
| Masculine words (with <b>а, о</b> or <b>у</b> )   | <b>-ыг</b>   | <b>-ийг</b>  | <b>-г</b>   |
| Feminine words (with <b>э, ү, и</b> or <b>ө</b> ) | <b>-ийг</b>  | <b>-ийг</b>  | <b>-г</b>   |

For example:

|           |            |        |         |
|-----------|------------|--------|---------|
| эгчийг    | багшийг    | ангийг | дүүг    |
| үхрийг    | Доржийг    | ахыг   | гахайг  |
| үзгийг    | багийг     | уулыг  | санг    |
| жолоочийг | сургуулийг | өвөөг  | байшинг |

**Note:** үхэр + ийг = үхрийг, дарга + ыг = даргыг, анги + ийг = ангийг, сургууль + ийг = сургуулийг

### Question pronouns and personal pronouns:

|              |               |                   |
|--------------|---------------|-------------------|
| юу → юуг     | та → таныг    | бид → биднийг     |
| хэн → хэнийг | чи → чамайг   | та нар → та нарыг |
| би → намайг  | тэр → түүнийг | тэд → тэднийг     |

When pronouns, adjectives and numbers are used as direct objects in place of nouns, they are used with the accusative case. For example:

|                                     |                                      |
|-------------------------------------|--------------------------------------|
| аль номыг → алийг (which one)       | улаан дэвтэр → улааныг (the red one) |
| энэ номыг → энийг (this one)        | том дэвтэр → томыг (the big one)     |
| тэр номыг → тэрийг (that one)       | олон дэвтэр → олныг (many of it)     |
| ахын номыг → ахынхыг (the brothers) | хоёр дэвтэр → хоёрыг (two of it)     |

## Дасгал 1

Нэр үгст заахын тийн ялгалын нөхцөл залгаж бич. (Add the accusative case to the nouns.)

- |           |               |            |
|-----------|---------------|------------|
| 1. ширээ  | 8. анги       | 15. манаач |
| 2. сандал | 9. байр       | 16. эхнэр  |
| 3. аав    | 10. толь      | 17. цоож   |
| 4. дүү    | 11. багш      | 18. мод    |
| 5. машин  | 12. нөхөр     | 19. байшин |
| 6. хашаа  | 13. эмийн сан | 20. дэвтэр |
| 7. малгай | 14. бал       | 21. бар    |

Шинэ үгс: толь — mirror, эмийн сан — pharmacy, манаач — watchman, цоож — lock, бар — team

## Дасгал 2

Харилцаа яриаг унш. (Read the conversation.)

### Дэлгүүрт

Худалдагч: — Та юу авах вэ?

Үйлчлүүлэгч: — Тэр цамцыг үзэж болох уу?

Худалдагч: — Болно, болно. Алийг?

Үйлчлүүлэгч: — Тэрийг.

Худалдагч: — Энийг үү?

Үйлчлүүлэгч: — Үгүй, тэр улааныг. Хэд юм бэ?

Худалдагч: — 10 000.

Үйлчлүүлэгч: — Энэ хаанахын цамц юм бэ?

Худалдагч: — Германых

Үйлчлүүлэгч: — Өмсөж үзэж болох уу?

Худалдагч: — Болно. Тэнд толь байгаа.

Үйлчлүүлэгч: — Энэ надад томдож (багадаж, уртдаж, богинодож) байна. Танд арай жижиг (том, богино, урт) байгаа юу?

Худалдагч: — Байгаа, байгаа. Май.

Үйлчлүүлэгч: — Энэ надад таарч байна. Авъя.

Худалдагч: — Танд зохиж байна.

Шинэ үгс: худалдагч — seller, үйлчлүүлэгч — customer, өмсөх — to put on/to wear, томдох — to be big, арай жижиг — smaller, таарах — to fit, зохих — to suit

## Дасгал 3

Цаардлагатай газар нь заахын тийн ялгалын нөхцөл бич. (Add the accusative case if necessary.)

1. Би ном ..... авсан. Би энэ ном ..... авсан.

2. Манай нөхөр тэр ширээ ..... хийсэн. Манай нөхөр ширээ ..... хийсэн.
3. Би олон монгол нэр ..... мэднэ. Би түүний нэр ..... мэднэ.
4. Багш тэдэнд хичээл ..... заасан. Багш энэ хичээл ..... заасан.
5. Би өчигдөр олон шинэ үг ..... сурсан. Харин тэр үг ..... сураагүй.
6. Сүрэнхүү зураг ..... зурах их дуртай. Тэр аль зураг ..... зурсан бэ?
7. Дулмаа надад багшийн ном ..... өгсөн. Дулмаа надад ном ..... өгсөн.
8. Хэн өнөө орой хоол ..... хийх вэ? Хэн өнөөдрийн хоол ..... хийх вэ?
9. Чи миний цай ..... битгий уу. Тэр цай ..... уугаарай.
10. Чи тэр харандаа ..... авсан уу? Чи дэлгүүрээс харандаа ..... авсан уу?
11. Та аль цаасан шувуу ..... хийсэн бэ? Та шувуу ..... хийх дуртай юу?
12. Ах надад энэ зураг ..... өгсөн. Ах надад олон зураг ..... өгсөн.
13. Чи Батхүү ..... зурж байна уу? Чи хэн ..... зурж байна вэ?
14. Би ах ..... хүлээж байна. Чи хэн ..... хүлээж байна вэ?
15. Би та ..... ойлгож байна. Чи (би) ..... ойлгож байна уу?
16. Би тэд ..... сайн мэднэ. Чи тэд ..... мэдэх үү?
17. Та (би) ..... битгий хүлээгээрэй. Та (тэр) ..... хүлээгээрэй.
18. Хүүхэд ээж аав ..... санадаг. Хүүхэд хэн ..... санадаг вэ?

Шинэ үгс: хүлээх — to wait, санах — to miss, to remember

## Дасгал 4

Биеийн төлөөний үгсийг заахын тийн ялгалын нөхцөлөөр хувирга. Өмнөх хүснэгтээсээ харалгүй дараагийн хүснэгтээ бөглөж бичээд биеийн төлөөний үгс болон өгөгдсөн үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Add the accusative case to the personal pronouns. Fill out the next table without looking at the previous table. Then make sentences with the personal pronouns and the given verbs.)

| ХЭН       | ХЭНИЙГ | ХЭН       | ХЭНИЙГ | ХЭН       | ХЭНИЙГ |
|-----------|--------|-----------|--------|-----------|--------|
| Би        |        | Тэд (нар) |        | Тэр       |        |
| Чи        |        | Та нар    |        | Тэд (нар) |        |
| Та        |        | Бид (нар) |        | Чи        |        |
| Тэр       |        | Тэр       |        | Би        |        |
| Бид (нар) |        | Та        |        | Бид (нар) |        |
| Та нар    |        | Чи        |        | Та нар    |        |
| Тэд (нар) |        | Би        |        | Та        |        |

Үйл үгс: мэдэх, санах, хүлээх, ойлгох

## Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: I waited for you. → Би таныг хүлээсэн.

- |                              |                                     |
|------------------------------|-------------------------------------|
| 1. She waited for me.        | 7. I waited for you many hours.     |
| 2. Please wait for Bayarhuu. | 8. I don't like to wait for people. |
| 3. Did you wait for me?      | 9. I didn't wait for him yesterday. |
| 4. Wait for your brother.    | 10. I need to wait for that person. |
| 5. Who are you waiting for?  | 11. I will wait for my mother.      |
| 6. I can't wait for them.    | 12. They won't wait for students.   |

## Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: I understand you. → Би таныг ойлгож байна.

1. She didn't understand me (the teacher, her, them, her friend, her mother).
2. Did you understand me (that woman, him, your teacher)?
3. Please understand your friend (your father, them, her).
4. Please don't misunderstand me (us, your friend, your sister, him).
5. He needs to understand his parents. He will understand his parents one day.

Шинэ үгс: to understand — ойлгох, to misunderstand — буруу ойлгох

## Дасгал 7

Доогуур нь зурсан болон хаалтанд байгаа үгст *-ыг<sup>2</sup>/-г* нөхцөл залгаж, өгүүлбэрийг орчуул. Add *-ыг<sup>2</sup>/-г* to the underlined words and words in parentheses, then translate the sentences.)

1. Та тэр (тэд, би, багш, охин) дуудсан уу?
2. Би уржигдар дэлгүүрт оюутан (та нар, ах, найз) таниагүй.
3. Тэр би (та, эмээ, найз, багш) хараагүй.
4. Тэр өчигдөр Сүххүү (Батхүү, Доржмаа) сонсоогүй.
5. Би өдөр бүр ээж (найз, аав, дүү, эмээ өвөө) санадаг.
6. Та би (тэр, тэд, сайн найз, бид) битгий мартаарай.

Шинэ үгс: дуудах — to call, харах — to see, таних — to recognize, сонсох — to hear/to listen to

## Дасгал 8

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| 1. You need to forgive your friend. | 6. Don't offend people.                 |
| 2. She praises her child a lot.     | 7. We need to forgive people.           |
| 3. I forgave them.                  | 8. Did I offend you?                    |
| 4. Don't praise your son too much.  | 9. Do parents need to praise their son? |
| 5. "I can't forgive her" she said.  | 10. I don't want to offend my friend.   |

Шинэ үгс: to forgive — уучлах, to praise — магтах, to offend — гомдоох, хэтэрхий — too

## Дасгал 9

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Би, энэ, ном, унших, их, дуртай
2. Би, энэ өрөө, цэвэрлэх; та, тэр өрөө, цэвэрлэх
3. Та, энэ гутал, хэн, авах?
4. Чи, яагаад энэ сандал, засах(гүй)?
5. Мөнхмаа, багшийн ном, ширээн дээр, тавих
6. Чи, миний цүнх, харах?
7. Та нар, ангийн хаалга, түгжих?
8. Та, би (найз, багш, ах, эгч), их, хүлээх?
9. Та, би (тэд нар, хүүхдүүд, багш, захирал), ойлгох?
10. Чи, тэр (би, Батхүү, бид нар, тэд нар, жижиг охин), харах?
11. Би, гадаа, найз (дүү, тэр, чи, та, Гэрэлмаа, багш), таних(гүй)
12. Би, төрсөн өдрийн баяр, тэр (найз нар, гэр бүл, Баярхүү), урих

Шинэ үгс: засах — to fix, түгжих — to lock, урих — to invite

## Дасгал 10

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: Тэр, ээж, хувцас, угаах → Тэр ээжийнхээ хувцсыг угаасан.

1. Би, дандаа, хүү (охин, эхнэр/нөхөр), хувцас, угаах
2. Тэр, өрөө (анги, машин), цонх, сайн цэвэрлэх хэрэгтэй
3. Би, шинэ, багш (сургууль, оюутан), нэр, мартах
4. Төмөрхүү, өрөө (шүүгээ, анги, сургууль), хаалга, засах хэрэгтэй
5. Та, нөхөр (хүү, охин, дүү, эгч, ах), мөрөөдөл, сайн мэдэх?
6. Та, ажил (зуны амралт, хичээл), төлөвлөгөө, хийх
7. Та, энэ цаас, дээр, гэр (сургууль, ажил), хаяг, бичих
8. Та, энэ цаас, дээр, ажил (аав, гэр, сургууль), утасны дугаар, бичих
9. Би, машин (гэр, өрөө, цүнх), түлхүүр, ширээ, дээр, мартах
10. Та, байр (утас), мөнгө, төлөх?
11. Чи, хашаа (анги, шүүгээ, гэр, өрөө), хаалга, хаах?
12. Би, найз (нохой, муур, гэр, цэцэрлэг), зураг авах

Шинэ үгс: мөрөөдөл — day dream, төлөвлөгөө — plan, хаяг — address, төлөх — to pay

## Дасгал 11

Асуултад харуул. (Answer the questions.)

Ашиг нь: Хэн хэнийг хүлээж байна вэ? → Би найзыгаа хүлээж байна.

- |                                 |                                      |
|---------------------------------|--------------------------------------|
| 1. Хэн хэнийг гомдоодог вэ?     | 5. Хэн хэнийг хэзээ, юунд урьсан бэ? |
| 2. Хэн хэнийг хайрлах ёстой вэ? | 6. Хэн хэнийг уучлах ёстой вэ?       |
| 3. Хэн хэнийг магтдаг вэ?       | 7. Хэн хэнийг хүндлэх хэрэгтэй вэ?   |
| 4. Хэн хэнийг өрөвддөг вэ?      | 8. Хэн хэнийг сонсох хэрэгтэй вэ?    |

Шинэ үгс: хайрлах — to love, өрөвдөх — to feel sorry for, хүндлэх — to respect

## Дасгал 12

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Та ер нь монгол хүмүүсийг ойлгодог уу?
2. Хүмүүс найз нөхөд, аав ээжийгээ дандаа ойлгодог уу?
3. Та хүмүүсийг олон цаг хүлээж чадах уу?
4. Та хүмүүсийн хувцсыг анзаардаг уу?
5. Аав ээж хүүхдүүдээ магтах хэрэгтэй юү?
6. Та найз нарыгаа санаж байна уу?
7. Та хүүхэд насаа санаж байна уу?
8. Та олон жилийн дараа найз нарыгаа харвал таних уу?
9. Та хүмүүсийг уучилж чаддаг уу?
10. Хүмүүс аав ээж, найз нөхөд, ах дүүгээ хайрлах ёстой юү?
11. Хүүхдүүд настай хүмүүсийг хүндлэх ёстой юү?
12. Хүмүүсийг юу өөрчилдөг вэ?
13. Хүмүүс найз нөхдийгөө ямар үед мартдаг вэ?

Шинэ үгс: анзаарах — to notice, хүүхэд нас — childhood, өөрчлөх — to change

# Дөчин хоёрдугаар хичээл



## Захирах хүсэх төлөв (1-р бие) (Imperative mood (First person))

Би тийшээ явъя.      Let me go there.      Би цонх нээе.      Let me open it.  
Би гэрт оръё.      Let me go in the house.      Би энийг өргөө.      Let me lift this.

### Spelling rules:

|  | After verb stems ending with vowels or soft sign | After verb stems ending with consonants |
|--|--|---|
| After verb stems with <b>а, у</b> or <b>я</b>    | <b>-я</b>  | <b>-ъя</b>                              |
| After verb stems with <b>э, ү, и</b> or <b>ө</b> | <b>-е</b>  | <b>-ье</b>                              |
| After verb stems with <b>о</b>                   | <b>-ё</b>  | <b>-ьё</b>                              |

For example:

|           |            |            |          |
|-----------|------------|------------|----------|
| Би хаая.  | Би нүүе.   | Би авъя.   | Би үзье. |
| Би ууя.   | Би хийе.   | Би уулзъя. | Би идье. |
| Би барья. | Би өргөө.  | Би харъя.  | Би өгье. |
| Би нээе.  | Би тоглоё. | Би хэлье.  | Би олъё. |
| Би эргэе. | Би бооё.   | Би эрье.   | Би оръё. |

## Дасгал 1

Үйл үгийн үндсүүд дээр "-я, -е, -ё (-ъя, -ье, -ьё)" нөхцөлүүдээс тохирохыг нь бичиж, өгүүлбэр зохио. (Add the appropriate suffixes "-я, -е or -ё (-ъя, -ье or -ьё)" to the verb stems and make sentences with them.)

- |           |          |            |             |
|-----------|----------|------------|-------------|
| 1. авчир  | 14. гуй  | 27. сонс   | 40. уучил   |
| 2. ажилла | 15. гүй  | 28. сур    | 41. хаа     |
| 3. амар   | 16. заа  | 29. суу    | 42. хар     |
| 4. амьдар | 17. зар  | 30. тавь   | 43. хий     |
| 5. асуу   | 18. зогс | 31. танилц | 44. хүлээ   |
| 6. бай    | 19. зур  | 32. тоол   | 45. хэл     |
| 7. барь   | 20. соль | 33. тогло  | 46. хэрэглэ |
| 8. тайл   | 21. ир   | 34. тусал  | 47. цэвэрлэ |
| 9. бод    | 22. мэд  | 35. угаа   | 48. эхэл    |
| 10. бос   | 23. нээ  | 36. уна    | 49. эргэ    |
| 11. бол   | 24. ор   | 37. унш    | 50. яв      |
| 12. буу   | 25. оч   | 38. уулз   | 51. ярь     |
| 13. гар   | 26. өг   | 39. уу     | 52. зүү     |

Шинэ үгс: тайлах — to take off, солих — to exchange, танилцах — to get to know, эргэх — to turn, зүүх — to wear

## Дасгал 2

Дасгал 1-ийн үйл үгийн үндсүүдэд "-цгаая, -цгээе, -цгөөе, -цгооё" нөхцөлүүдээс торирохыг нь залга. Add the appropriate suffixes "-цгаая, -цгээе, -цгөөе or -цгооё" to the verb stems from Exercise 1.)

-цгаая → Явцгаая. (Let's go.)

-цгөөе → Өгцгөөе. (Let's give.)

-цгээе → Идэцгээе. (Let's eat.)

-цгооё → Тоглоцгооё. (Let's play.)

## Дасгал 3

Эгэгдсэн үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given verbs.)

Жишээ нь: ажилла, амар → А. Би ажиллая, чи амраарай. Б. Би амаръя, чи ажиллаарай.

1. ажилла, амар

5. ор, хүлээ

9. яв, амар

2. онгойлго, хаа

6. тогло, хар

10. ид, хий

3. суу, зогс

7. заа, сонс

11. сур, заа

4. хэл, бич

8. сонс, унш

12. ярь, орчуул

## Дасгал 4

Эгэгдсэн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: А. Би цай аваад ирье. (Let me go and get some tea.) Б. Чи цай аваад ир. (Go and get some tea.)

1. хоол авах, ирэх

6. хувцас цэвэрлэх, ирэх

2. ном авах, ирэх

7. хоол хийх, ирэх

3. үзэг авах, ирэх

8. дэлгүүр явах, ирэх

4. аяга угаах, ирэх

9. хаалга хаах, ирэх

5. гар угаах, ирэх

10. цонх онгойлгох, ирэх

Шинэ үг: онгойлгох — to open

## Дасгал 5

Өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences.)

1. .... учраас та битгий муу хоол идээрэй.

2. .... учраас та битгий гадаа гараарай.

3. .... учраас та битгий хөдөө яваарай.

4. .... учраас та битгий шил хагалаарай.

5. .... учраас та битгий мод хугалаарай.

6. .... учраас та битгий их тостой хоол идээрэй.

7. .... учраас та битгий олон цаг ажиллаарай.

Шинэ үгс: хагалах — to break (glass), хугалах — to break (into two pieces)



## Үндэс үүсгэх -хан<sup>4</sup> дагавар (Suffix -хан<sup>4</sup>)

### нэр үг+хтя+хан<sup>4</sup> (noun+genitive case+хан<sup>4</sup>)

|                       |                    |                     |  |
|-----------------------|--------------------|---------------------|--|
| ангийн <b>хан</b>     | classmates         | гэрийн <b>хэн</b>   | family members                             |
| сургуулийн <b>хан</b> | schoolmates        | өрөөний <b>хөн</b>  | roommates                                  |
| ажлын <b>хан</b>      | co-workers         | байрных <b>хан</b>  | people who live in same apartment building |
| хотын <b>хон</b>      | city people        | цуглааны <b>хан</b> | assembly people, church people             |
| хөдөөний <b>хөн</b>   | countryside people |                     |  |
| гэр бүлийн <b>хэн</b> | family members     |                     |  |

## Дасгал 6

Асуултад харуул. (Answer the questions.)

1. Хотынхон ажилсаг уу, залхуу юу?
2. Хөдөөнийхөн өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?
3. Танай сургуулийнхан зуны амралтаараа юу хийдэг вэ?
4. Танай гэр бүлийнхэн хагас, бүтэн сайн өдөр юу хийдэг вэ?
5. Танай өрөөнийхөн сайн оюутнууд байсан уу?
6. Танай байрныхан бие биенийгээ сайн мэдэх үү?
7. Танай ажлынхан бие биендээ тусалдаг уу?
8. Та ажлынхантайгаа хөдөө явдаг уу?
9. Та ангийнхантайгаа уулздаг уу?
10. Танай цуглааныхан долоо хоногт хэдэн удаа уулздаг вэ?

Шинэ үгс: ажилсаг — hard working, залхуу — lazy, бие биенийгээ — each other

## Дасгал 7

Өгүүлбэрийн өгүүлэгдэхүүнийг "-хан<sup>4</sup>" дагаврыг ашиглан өөрчилж бич. (Change the subjects of the sentences using the suffix "-хан<sup>4</sup>.")

Жишээлбэл:

Манай ангийн сурагчид шинэ бүжиг сурсан. → Манай ангийнхан шинэ бүжиг сурсан.

1. Манай ажлын хүмүүс бие биенийгээ сайн ойлгодог.
2. Хөдөөний хүмүүс сайхан сэтгэлтэй.
3. Хотын хүмүүс мал сайн мэдэх үү?
4. Манай сургуулийн багш, сурагчид их сайхан харилцаатай байдаг.
5. Манай өрөөний охид надад их юм зааж өгдөг.
6. Базархүү цуглаанд явдаг. Тэр цуглааны хүмүүс бие биедээ дандаа тусалдаг.
7. Манай байрны хүмүүс байрныхаа урд сууж, ярих дуртай.
8. Манай багийн тамирчид сайн тоглосон.

Шинэ үгс: сэтгэл — heart, харилцаа — relationship, тамирчид — athletes

## Дасгал 8

Эгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences.)

1. Би ангийнхантайгаа .....
2. Энхмаа ангийнхнаасаа .....
3. Тэр, ангийнхандаа .....
4. Батсүх ажлынхандаа .....
5. Чи ажлынхан руугаа .....
6. Та ажлынхныгаа .....
7. Би өрөөнийхөнтэйгөө .....
8. Тэр, байрныхандаа .....
9. Хотынхон хөдөөнийхнөөс .....
10. Манай ангийнхан манай ажлынхантай .....

## Хүмүүсийг ерөөх (To say a blessing to people) 🗣️

- |                              |                                     |
|------------------------------|-------------------------------------|
| — Сайн сайхан бүхнийг хүсье! | — Wish you all the best!            |
| — Аз жаргал хүсье!           | — Wish you the happiness!           |
| — Амжилт хүсье!              | — Good luck!                        |
| — Бурхан (таныг) өршөөг!     | — God bless you!                    |
| — Эрүүл мэндийн төлөө!       | — For health! (When cheering)       |
| — Ажлын амжилтын төлөө!      | — For work success! (When cheering) |

# Дөчин гуравдугаар хичээл



## Баймж үг (ёстой (have to, must, to be supposed to))

"Ёстой/ёсгүй" is used with infinitive verb. For example:

Тэр хүү сургуульд **сурах ёстой**.

Тэр хүү ажил **хийх ёсгүй**.

Тэр хүү сургуульд **сурах ёстой байсан**.

Энхмаа одоо энд ирэх ёстой.

Энхмаа энд ирэх ёстой байсан.

That boy **has to study** at a school.

That boy **doesn't have to do** work.

That boy **had to study** at a school.

Enhmaa is supposed to come here now.

Enhmaa was supposed to come here.

## Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Хүүхдүүд юу хийх ёстой вэ?
2. Эцэг эх юу хийх ёстой вэ?
3. Багш ямар байх ёстой вэ?
4. Эмэгтэй хүн ямар байх ёстой вэ?
5. Эрэгтэй хүн ямар байх ёстой вэ?
6. Та юу хийх ёстой вэ?

## Дасгал 2

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. They have to be here at 9 o'clock.
2. I have to learn Mongolian.
3. I have to take medicine.
4. You have to rest now.
5. You have to trust your friend.
6. She has to talk with her friend.
7. You have to do work.
8. I have to know the truth.
9. I have to tell you the truth.
10. I have to ask my friend about that.
11. You have to forgive him.
12. He has to help his parents.

## Дасгал 3

"Ёстой, ёсгүй"-г ашиглан нөхцөл байдлуудад тохирсон гурав гурван өгүүлбэр бич. (Write three sentences for each situation using "ёстой, ёсгүй.")

Жишээ нь: Жон 20 жил Монголд амьдарсан. (John lived in Mongolia for 20 years.)

A. Тэр монгол хэл сайн мэдэх ёстой. (He is supposed to know Mongolian well.)

Б. Тэр бууз хийж чадах ёстой. (He is supposed to be able to make buuz.)

В. Тэр Монголд дургүй байх ёсгүй. (He is not supposed to dislike Mongolia.)

1. Жон америк хүн.
2. Аав ээж хүүхдүүддээ хайртай.
3. Төрхүү олон жил машин барьсан.
4. Гэрэлхүү эмч.
5. Дэлгэрмаа эмэгтэй хүн.
6. Галхүү монгол хүн.

## Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. He was supposed to come here yesterday but he didn't come.
2. My book is supposed to be here.
3. You were not supposed to do this work.
4. He is not supposed to talk about this.
5. They are supposed to be having a lesson now.
6. They are not supposed to be playing outside.
7. It is supposed to work.
8. You were supposed to teach a lesson yesterday. Why didn't you come?
9. I was supposed to ask him for forgiveness but I couldn't.
10. You are supposed to be able to do this.
11. We are supposed to be there at 10 o'clock.
12. The lesson was supposed to start at 9.

|                |                                 |                               |
|----------------|---------------------------------|-------------------------------|
| <b>удахгүй</b> | soon                            | (future affirmative sentence) |
| <b>мөд</b>     | soon                            | (future negative sentence)    |
| <b>удалгүй</b> | soon after/after a little while | (past and present tenses)     |

|                                 |  |
|---------------------------------|--|
| Эр удахгүй ирнэ.                | She will come soon.                                  |
| Эр мөд ирэхгүй.                 | She won't come soon.                                 |
| Эр дэлгүүр яваад удалгүй ирсэн. | She went to the store and came after a little while. |

## Дасгал 5

Эгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Ашигъяа нь: Хөдөө, явах

|   |   |
|---|---|
| 1. Би <b>удахгүй</b> хөдөө явна.                    | I will go to the countryside soon.                                |
| 2. Би <b>мөд</b> хөдөө явахгүй.                     | I won't go to the countryside soon.                               |
| 3. Би сургуулиа төгсөөд <b>удалгүй</b> хөдөө явсан. | Soon after I graduated from my school, I went to the countryside. |

- |                        |                        |
|------------------------|------------------------|
| 1. Хичээл, дуусах      | 6. Бид, уулзах         |
| 2. Тэд, гэрлэх         | 7. Машин, ирэх         |
| 3. Хурал, эхлэх        | 8. Гадаа, дулаан болох |
| 4. Бороо, зогсох       | 9. Би, амрах           |
| 5. Хүүхдүүд, хоол идэх | 10. Мод, ногоорох      |

— **инэ** үг: ногоорох — to become green

## Дасгал 6

Ээрийнхөө тухай "удахгүй, мөд, удалгүй"-г ашиглан багшдаа ярьж өг. (Tell your teacher about yourself using the words "удахгүй, мөд, удалгүй.")

## Дасгал 7

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I just came from my homeland, so I won't go back soon.
2. My friend went to the store. She will come soon. Please wait inside.
3. Soon after you left, the electricity came on.
4. They will graduate from their school soon.
5. I have work to do here at my office, so I will probably not go to my home soon.
6. She got sick and soon after she took the medicine, she was ok.
7. Soon after they got married, they moved to Erdenet.
8. She called me yesterday on the phone. She won't call me again soon.
9. He just left for his lesson. He won't come soon.
10. Soon after it snowed, it started melting.
11. She got angry but soon after, she became calm.
12. She is angry. She won't be calm soon.
13. He started working soon after he graduated from his university.

Шинэ үгс: нутаг — homeland, хайлах — to melt, тайвшрах — to become calm

## Ямар нэгэн асуудал гарсан үед (When there is a problem) 🐼

- |  |   |
|--|---|
| — Яасан бэ?                            | — What happened?                          |
| — Та зүгээр үү?                        | — Are you okay?                           |
| — Танд тусламж хэрэгтэй юү?            | — Do you need help?                       |
| — Яана аа, тийм үү?                    | — Oh no, really?                          |
| — Зүгээр ээ, битгий санаа зовоорой.    | — It's okay. Please don't worry.          |
| — За, тэр <u>яах вэ</u> . [yahuu]      | — Okay, that's not a big deal.            |
| — Яах вэ, яах вэ. [yahuu, yahuu]       | — It's okay, please don't worry about it. |
| — Яах юм бэ, яах юм бэ? [yahii, yahii] | — It's okay, you don't have to do it.     |

# Дөчин дөрөвдүгээр хичээл



## Энгийн өнгөрсөн цагууд (Simple past tenses)

|                   | Personally witnessed | Not personally witnessed | General | Recent | In spoken language | In written language |
|-------------------|----------------------|--------------------------|---------|--------|--------------------|---------------------|
| -сан <sup>4</sup> | √                    |                          | √       |        | √                  | √                   |
| -лаа <sup>4</sup> | √                    |                          |         | √      | √                  | √                   |
| -в                | √                    |                          |         |        |                    | √                   |
| -жээ/-чээ         |                      | √                        |         |        | √                  | √                   |

### When someone gives information to people:

|                         |   |
|-------------------------|---|
| Батхүү хөдөө явсан.     | Bathuu went to the countryside.                 |
| Батхүү сая хөдөө явлаа. | Bathuu just went to the countryside.            |
| Батхүү хөдөө явав.      | Bathuu went to the countryside.                 |
| Батхүү хөдөө явжээ.     | (I found out that) Bat went to the countryside. |

### In direct conversation in everyday life:

|                                    |            |
|------------------------------------|------------|
| Батхүү хөдөө <u>явчихсан</u> .     | [yavtsan]  |
| Батхүү сая хөдөө <u>явчихлаа</u> . | [yavchlaa] |
| Батхүү хөдөө <u>явчихжээ</u> .     | [yavchij]  |



## Саяхан өнгөрсөн цаг (Recent past tense)

|                         | After verb stems with <b>а, у</b> or <b>я</b> | After verb stems with <b>э, ү</b> or <b>и</b> | After verb stems with <b>о</b> | After verb stems with <b>ө</b> |
|-------------------------|---|---|--------------------------------|--------------------------------|
| <b>Affirmative form</b> | -лаа  | -лээ  | -лоо                           | -лөө                           |
| <b>Negative form</b>    | -сангүй<br>-аагүй                             | -сэнгүй<br>-ээгүй                             | -сонгүй<br>-оогүй              | -сөнгүй<br>-өөгүй              |
| <b>Question form</b>    | -(а)в уу?<br>-в?                              | -(э)в үү?<br>-в?                              | -(о)в уу?<br>-в?               | -(ө)в үү?<br>-в?               |

### Key words for recent past:

|        |          |                    |                 |
|--------|----------|--------------------|-----------------|
| саяхан | recently | дөнгөж сая         | just now        |
| сая    | just     | арван минутын өмнө | ten minutes ago |

### For example:

|                              |   |
|------------------------------|---|
| Хүү маань сая унтлаа.        | My son just slept.                            |
| Багш дөнгөж сая ангид орлоо. | The teacher went into the classroom just now. |
| Чи сая ирэв үү?              | Did you just come?                            |
| Чи хэзээ ирэв?               | When did you come?                            |

**Note:** -лаа<sup>4</sup> can also be used for near future tense.

|              |                  |
|--------------|------------------|
| Би явлаа.    | I'm leaving.     |
| Та явлаа юу? | Are you leaving? |

## Дасгал 1

Харилцаа яриануудыг унш. (Read the conversations.)

### Харилцаа яриа 1

А: — Сайхан амрав уу?

Б: — Сайхан амарлаа. Их олон юмны тухай зүүдэллээ.

А: — Сайхан зүүд байв уу, муухай зүүд байв уу?

Б: — Сайхан зүүд байлаа.

А: — Юу юуны тухай зүүдлэв?

Б: — Монголын тухай, ажлынхаа тухай, гэр бүлийнхээ тухай зүүдэллээ.

### Харилцаа яриа 2

А: — Хүүе, чи хаана байв аа?

Б: — Найзынхаа гэрт.

А: — Тэнд юу хийв?

Б: — Нэг сайхан кино үзлээ. Тоглоом тоглолоо.

А: — Хэн хэн тэнд байв?

Б: — Гэрэлмаа, Дугармаа, Энхмаа бид дөрөв байлаа.

А: — Хэр удаан тоглоом тоглов?

Б: — Хоёр цаг тоглолоо.

А: — Хөгжилтэй байв уу?

Б: — Хөгжилтэй байлаа.

### Харилцаа яриа 3

А: — Чи хэзээ ирэв?

Б: — 20 минутын өмнө ирлээ.

А: — Юугаар ирэв?

Б: — Таксигаар ирлээ.

А: — Хэнтэй ирэв?

Б: — Багш нартай.

А: — Жаргалмаа багш ирэв үү?

Б: — Ирлээ, ирлээ.

### Харилцаа яриа 4

Б: — Энийг хэнд авав?

А: — Чамд.

Б: — Маш их баярлалаа.

А: — Зүгээр ээ.

Б: — Хаанаас авав? Их дэлгүүрээс авав уу?

А: — Тийм.

Шинэ үгс: зүүдлэх — to dream, зүүд — dream, хөгжилтэй — with fun

## Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

- |                                    |                                 |
|------------------------------------|---------------------------------|
| 1. Чи найз руугаа утсаар ярив уу?  | 10. Сая хэн ирэв?               |
| 2. Чи хоолоо идэв үү?              | 11. Чи хаанаас ирэв?            |
| 3. Чи ажлаа хийж дуусгав уу?       | 12. Тэд ямар тоглоом тоглов?    |
| 4. Чи амарч чадав уу?              | 13. Цахилгаан хэзээ тасрав?     |
| 5. Чи мах авав уу?                 | 14. Ус хэзээ тасрав?            |
| 6. Чи гэрийн даалгавраа хийв үү?   | 15. Чи яагаад хичээлээс хоцров? |
| 7. Та тэр хүнийг харав уу?         | 16. Хүүхэд яагаад уйлав?        |
| 8. Чи сая гарсан чимээг сонсов уу? | 17. Та өглөө юу хийв?           |
| 9. Цахилгаан ирэв үү?              | 18. Та ямар хоол хийв?          |

## Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өнгөрсөн цагаар төгссөн батлах болон асуух өгүүлбэр зохио. (Make affirmative and interrogative sentences with the past tense using the given words.)

Жишээ нь: Ээж, сая, ирэх

1. Ээж сая ирэв үү?

2. Ээж сая ирлээ.

3. Ээж хэзээ ирэв?

- |                         |                           |
|-------------------------|---------------------------|
| 1. Та, би, ойлгох       | 8. Тэр, та, утасдах       |
| 2. Та, сурсан үг, санах | 9. Та, би, их, хүлээх     |
| 3. Чи, найз, урих       | 10. Хүүхэд, нохой, айх    |
| 4. Чи, хаалга, түгжих   | 11. Чи, ангийнхан, туслах |
| 5. Тэд, сандал, засах   | 12. Та, ажлынхан, хэлэх   |
| 6. Чи, хүүхдүүд, дуудах | 13. Та нар, хичээл, бичих |
| 7. Та, Бурмаа, харах    | 14. Чи, энэ дуу, сурах    |

Линэ үг: түгжих — to lock

# Дөчин тавдугаар хичээл



## Мэдэгдэлгүй өнгөрсөн цаг (Past tense (not personally witnessed))

|   | Affirmative form | Negative form              | Question form            |           |
|---|------------------|----------------------------|--------------------------|-----------|
| After verb stems ending with vowel, soft sign or consonants other than <b>г, с, (в)</b> or <b>(р)</b> | -жээ/-ж          | -аа <sup>4</sup> гүй байна | without question pronoun | -ж уу/үү? |
|   |                  |                            | with question pronoun    | -ж?       |
| After verb stems ending with <b>г, с, (в)</b> or <b>(р)</b>   | -чээ/-ч          | -аа <sup>4</sup> гүй байна | without question pronoun | -ч уу/үү? |
|   |                  |                            | with question pronoun    | -ч?       |

When people didn't personally witness an action, then find out (by hearing someone or seeing results) about it, this tense can be used. For example:

Тэр сая явжээ.

(I found out that) he has just left.

Морьд энд байжээ.

Horses were here. (We see footprints.)

Also when people make up stories, this tense can be used. For example:

Чи нэг машинтай байжээ. Тэгсэн чинь ... (Let's say) you had one car. But ...

Эрт урьд цагт нэгэн охин байжээ. Once upon a time, there was one girl.

When speaking, when people find out something happened, they can use -чихжээ/-чиж.

For example: Жаргалмаа явчихжээ. [javchij] (I found out that) Jargalmaa has left. (Her coat and bag weren't there.)

### Key words for this past tense:

аль хэдийн (already), нэг мэдсэн чинь (all of a sudden)

## Дасгал 1

Үлгэрийг унш. (Read the story.)

### Үнэг, чоно, зараа гурав

Эрт урьд цагт үнэг, чоно, зараа гурав амьдарч байжээ. Нэг өдөр тэд чавга олж, хэн нь тэр чавгыг идэх талаар хэлэлцжээ. Чоно "Архинд хэн амархан согтдог маань идье" гэв. Энэ саналыг бүгдээрээ зөвшөөрөв. Чоно "Би амсаад согтдог" гэлээ. Үнэг "Би үнэрлээд согтдог" гэлээ. Зараа "Би сонсоод согтдог" гээд гуйвж байжээ. Ингээд чавгыг зараа идэхээр болжээ.

*Шинэ үгс:* үнэг — fox, чоно — wolf, зараа — hedgehog, чавга — plum, хэлэлцэх — to discuss, согтох — to get drunk, зөвшөөрөх — to agree, амсах — to taste, үнэрлэх — to smell, гуйвах — to sway

## Дасгал 2

Үйл үгст өнгөрсөн цагийн нөхцөл залгаж, асуулт зохио. (Add the past tense suffix to the verbs and make questions.)

Жишээ нь: Хоол дуус.....

- А. Хоол дуусчихжээ. [duuschij]  
 Б. Хоол дуусчихаж уу? [duuschijuu]  
 В. Аль хоол дуусчихаж? [duuschij]

- |                         |                                       |
|-------------------------|---------------------------------------|
| 1. Гадаа цас ор.....    | 13. Тэр хөгшир.....                   |
| 2. Багш ир.....         | 14. Цаг эвдэр.....                    |
| 3. Ах яв.....           | 15. Зам эвдэр.....                    |
| 4. Ус буцал.....        | 16. Би шинэ үгээ март.....            |
| 5. Хоол бол.....        | 17. Би номоо март.....                |
| 6. Цахилгаан тасар..... | 18. Үс чинь цагаан бол.....           |
| 7. Цахилгаан ир.....    | 19. Нүүр чинь хар бол.....            |
| 8. Ус тасар.....        | 20. Хувцас чинь муухай бол.....       |
| 9. Ус ир.....           | 21. Үсэн дээр чинь будаа наалд.....   |
| 10. Кино эхэл.....      | 22. Хувцсан дээр чинь цаас наалд..... |
| 11. Хүүхэд унт.....     | 23. Шүдэн дээр чинь ногоо наалд.....  |
| 12. Мах дуус.....       | 24. Нүүрэн дээр чинь хоол наалд.....  |

Шинэ үгс: буцлах — to boil, цахилгаан — electricity, хөгшрөх — to become old, эвдрэх — to be broken, наалдах — to be stuck

## Дасгал 3

Нөхцөл байдлуудыг уншаад өнгөрсөн цагийн доорх 3 нөхцөлөөс тохирохыг нь бич. (Read the situations and add the proper past tense (one of the three past tenses below) after the verbs.)

-чихсан<sup>4</sup> [-tsan<sup>4</sup>]      -чихлаа<sup>4</sup> [-chlaa<sup>4</sup>]      -чихжээ [-chij]

Тэр явчихсан.                      (I know) he left.  
 Тэр явчихлаа.                      He just left.  
 Тэр явчихжээ.                      (I found out that) he has left.

1. Багш ирээгүй байна. Найз чинь "Багш ирсэн үү?" гэж танаас асуусан. Та "Ирээгүй" гэж хэлсэн. Харин 10 минутын дараа багш ирсэн. Та найздаа "Багш ир....." гэж хэлсэн.
2. Багш 30 минутын өмнө ирсэн. Та багшийг харсан. Найз чинь "Багш ирсэн үү?" гэж танаас асуусан. Та "Багш ир....." гэж хэлсэн.
3. Найз чинь "Багш ирсэн үү?" гэж танаас асуусан. Та "Мэдэхгүй. Би үзээд ирье" гэж хэлсэн. Тэгээд нөгөө өрөөнд орж үзсэн. Багш байсан. Та "Багш ир....." гэж хэлсэн.
4. Та нэг цагийн өмнө хоол хийсэн. Найз чинь "Хоол болсон уу?" гэж асуусан. Та "Хоол бол....." гэж хэлсэн.
5. Та хоол хийж байна. Найз чинь "Хоол болсон уу?" гэж асуусан. Та "Болоогүй байна" гэж

- хэлсэн. Харин хоол дөнгөж сая боллоо. Та найздаа "Хоол бол....." гэж хэлсэн.
6. Та хоол хийж байна. Харин яг одоо та зурагт үзэж байна. Ах чинь "Хоол болсон уу?" гэж асуусан. Та "Үзээд ирье" гэж хэлсэн. Тэгээд хоол идэж үзсэн. Хоол болсон байсан. Та ахдаа "Хоол бол....." гэж хэлсэн.
  7. Өрөө харанхуй байсан. Та унтраалга дарсан. Харин цахилгаан байхгүй байсан. Та "Өө, цахилгаан тасар....." гэж хэлсэн.
  8. Цахилгаан тасраад нэг цаг өнгөрсөн. Найз чинь "Яагаад хоолоо хийгээгүй юм бэ?" гэж асуусан. Та "Цахилгаан тасар....." гэж хэлсэн.
  9. Та найзтайгаа утсаар ярьж байсан. Яг тэр үед цахилгаан тасарсан. Та "Өө, цахилгаан тасар....." гэж найздаа хэлсэн.
  10. Та 10 минутын өмнө дүүгээ унтуулсан. Ээж чинь "Дүү чинь унтсан уу?" гэж асуухад та "Дүү унт....." гэж хэлсэн.
  11. Та дүүгээ унтуулаад өрөөнөөс гарч ирж байна. Ээж чинь "Дүү чинь унтсан уу?" гэж асуусан. Та "Дүү унт....." гэж хэлсэн.
  12. Та дүүгээ хайгаад өрөөнд нь орсон. Харин дүү чинь унтаж байсан. Та "Дүү унт....." гэж ээждээ хэлсэн.

Шинэ үгс: унтраалга — switch, өнгөрөх — to pass

## Дасгал 4

Үйл үг бүр дээр "-чихсан<sup>4</sup>, -чихлаа<sup>4</sup>, -чихжээ" нөхцөлүүдийг ашиглан гурав гурван өгүүлбэр зохиож, ямар нөхцөлд уг өгүүлбэрийг хэлж болохыг бич. (Make three sentences for each verb using "-чихсан<sup>4</sup>, -чихлаа<sup>4</sup>, -чихжээ" and write down in which situations you can use each sentence.)

- |          |          |           |           |
|----------|----------|-----------|-----------|
| 1. яв    | 5. ав    | 9. зас    | 13. наалд |
| 2. бол   | 6. ир    | 10. мэд   | 14. хий   |
| 3. эвдэр | 7. тасар | 11. буцал | 15. сур   |
| 4. өмс   | 8. март  | 12. дуус  | 16. эхэл  |

## Дасгал 5

Өгүүлбэрийг орчуулаад уг нөхцөл байдалд тохирсон зөвлөгөөг өг. (Translate the sentences, then give advice that is appropriate to the situation.)

1. Let's say your friend was sick. But she never saw a doctor. What would you say to her?
2. Let's say your friend had ten thousand togrogs. His friend needed ten thousand togrog. But he wouldn't give it to his friend. What would you say to your friend?
3. Let's say it was snowing outside. Your daughter was playing outside without a coat. What would you say to your daughter?
4. Let's say your friend bought a new computer. But his new computer was not turned on. What would you say to your friend?
5. Let's say your brother offended his friend. He didn't want to ask his friend for forgiveness. What would you say to him?



# Давтлага хичээл

## Дасгал 1

Заахын тийн ялгалын нөхцөлийг шаардлагатай газар нь бич. (Add the accusative case where needed.)

- |                                   |                                      |
|-----------------------------------|--------------------------------------|
| 1. Ээж хоол..... хийсэн.          | 8. Худалдагч аа, нэг талх..... авъя. |
| 2. Би энэ хоол..... хийсэн.       | 9. Худалдагч аа, нэг..... авъя.      |
| 3. Чи амттай хоол..... хийсэн үү? | 10. Худалдагч аа, тэр..... авъя.     |
| 4. Чи аль хоол..... хийсэн бэ?    | 11. Би та..... хүлээж байсан.        |
| 5. Би энэ..... үзэж болох уу?     | 12. Би автобус..... хүлээж байсан.   |
| 6. Би энэ ном..... үзэж болох уу? | 13. Би гоё зураг..... харсан.        |
| 7. Би ном..... үзэж болох уу?     | 14. Би Гэрэлмаа..... харсан.         |

## Дасгал 2

Үйл үгийн үндсэнд "я, е, ё" нөхцөлүүдээс тохирохыг нь зөв залгаж бич. (Add the appropriate suffix "я, е, ё" to the verb stems.)

- |           |         |            |             |
|-----------|---------|------------|-------------|
| 1. авчир  | 7. зогс | 13. оч     | 19. унш     |
| 2. ажилла | 8. зур  | 14. өг     | 20. хий     |
| 3. асуу   | 9. соль | 15. суу    | 21. хэрэглэ |
